



Монголын Эмэгтэйчүүдийн Сан



МОНГОЛ УЛС ДАХЬ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

2015-2019 ОН



Монгол Улс, Улаанбаатар хот
2020 он



“Монгол Улс дахь эмэгтэйчүүдийн эрхийн нөхцөл байдал: 2015 – 2019 он” судалгааны тайланг Women’s Fund Asia (Азийн эмэгтэйчүүдийн сан) байгууллагын санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй **“Монгол Улсад Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай НҮБ-ын Конвенцын (ЭАБХУТК) хэрэгжилтийг хангах зорилгоор оролцогч талуудын чадавхийг бэхжүүлэх”** төслийн хүрээнд боловсруулав.



Монголын Эмэгтэйчүүдийн Сан

МОНГОЛ УЛС ДАХЬ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

2015-2019 ОН

Монгол Улс, Улаанбаатар хот
2020 он

ӨМНӨХ ҮГ	6
ТОВЧИЛСОН ҮГ	7
Судалгааны арга зүй:	8
Судалгааны зорилго	8
Судалгааны зорилт	8
Судалгааны асуултууд	8
Судалгааны загвар	8
Судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийх арга	9
Судалгааны баг	9
СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ	12
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ	17
ХОЁРДУГААР БҮЛЭГ: ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИН ДЭХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦОО	35
ГУРАВДУГААР БҮЛЭГ: ХӨДӨӨГИЙН ЭМЭГТЭЙЧҮҮД	47
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХ	61
ТАВДУГААР БҮЛЭГ: ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХИЙН БУСАД АСУУДЛУУД (ЭРҮҮЛ МЭНД, БОЛОВСРОЛ, ГЭРЛЭЛТ, ГЭР БҮЛ)	75
ХАВСРАЛТ 1: СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ	92
ХАВСРАЛТ 2: ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХИЙГ ХАНГАХТАЙ ХОЛБООТОЙ (2015-2019) СҮҮЛИЙН ТАВАН ЖИЛИЙН ХУГАЦААНД МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ НЭГТГЭЛ	118
Ашигласан материал	123



Монгол Улс Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай НҮБ-ын Конвенцыг түдгэлзэх ямар нэгэн тайлбаргүйгээр 1981 онд соёрхон баталсан билээ. Манай улс 1990 онд хүний эрх, тэгш байдлыг эрхэмлэн дээдэлсэн ардчилсан Үндсэн Хуулиа баталснаас хойш, эмэгтэйчүүдийн эрхийг хангах, хамгаалах чиглэлээр эрх зүйн болон системийн түвшний олон ахиц дэвшлийг бий болгоод байгаа билээ. Гэсэн хэдий ч эмэгтэйчүүдийн эрх, жендэрийн тэгш байдал нь хууль эрх зүй, бодлого, тэдгээрийн хэрэгжилт, соёл уламжлал, олон нийтийн ойлголт хандлага, хэвшмэл ойлголтын хүрээнд төдийлөн сайн хангагдахгүй байна.

Эрэгтэй, эмэгтэй хүмүүс нийгэм, улс төр, эдийн засгийн бүхий л харилцаанд ижил боломжтойгоор оролцох нөхцөлийг бий болгоход соёл уламжлал, тогтолцоо, хууль эрх зүй, жендэрийн хэвшмэл ойлголтын улмаас тулгардаг бэрхшээлийг тодорхойлох, нийгмийн баялгаас эрэгтэй эмэгтэй хүмүүс адил тэгш эрхтэйгээр хүртэх, хөгжилд хувь нэмрээ оруулах боломжуудыг эрэлхийлэх, асуудал дэвшүүлэхийг зорьж “Монгол Улс дахь эмэгтэйчүүдийн эрхийн нөхцөл байдал” (2015-2019) судалгааг хийж гүйцэтгэлээ.

Тус судалгаагаар жендэрт суурилсан хүчирхийлэл, эмэгтэйчүүдийн улс төр, шийдвэр гаргах түвшний оролцоо, хөдөөгийн малчин эмэгтэйчүүдийн асуудлууд, эрүүл мэнд, боловсрол, гэрлэлт, гэр бүл, хөдөлмөр эрхлэлтийн харилцаан дахь эмэгтэйчүүдийн эрх, жендэрийн тэгш байдлын талаарх өнөөгийн нөхцөл байдал, статусыг тодорхойлох, эрхийн хэрэгжилт хангалтгүй байгаагийн суурь шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлсийг тодруулахыг зорилоо.

Судалгааны үр дүн нь олон нийт, бүлэг, бодлогын нөлөөлөл гэх мэт өргөн хүрээнд ажилладаг бүлэг, төрийн болон төрийн бус байгууллагууд, олон улсын байгууллагуудад манай улсын эмэгтэйчүүдийн эрхийн хэрэгжилт, бодит нөхцөл байдлын талаар нотолгоонд тулгуурласан цогц мэдээлэл өгөх бөгөөд лобби, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зэрэг олон үйл ажиллагаанд ашиглах боломжтой.

Судалгааны арга зүйг боловсруулах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, тайланг бэлтгэн боловсруулах ахлах судлаачаар АШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн багш, судлаач Г.Золжаргалан, MSW (Нийгмийн ажлын магистр), Хүйсийн тэгш эрхийн төв ТББ-ын судлаач Т.Цогзолмаа, LLM (Хууль зүйн ухааны магистр) ХТЭТ нар, судалгааны мэдээлэл цуглуулах багийн ахлах судлаачдаар Иргэдэд Туслах Хүний Эрхийн Төвийн тэргүүн, өмгөөлөгч С.Дондов, Эмэгтэй удирдагч сангийн тэргүүн М.Болормаа, Хил хязгааргүй алхам ТББ-ын тэргүүн Н.Баярсайхан, Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих холбооны тэргүүн Ш.Ариунаа нар ажиллалаа.

Ахлах судлаач, багийн ахлагчаар ажилласан судлаачид болон судалгааны мэдээллийг боловсруулах, дүн шинжилгээ хийх ажлыг амжилттай гүйцэтгэсэн бусад судлаачид, мөн судалгааны явцад хамтран ажилласан иргэний нийгмийн байгууллагууд, мэргэжилтнүүддээ талархаж буйгаа илэрхийлье.

Судалгааны бүх үйл явцад арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэн ажилласан олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, тэгш эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг International Women's Rights Action Watch Asia Pacific (IWRAP AP) байгууллагын хамт олон, Жендэрийн үндэсний шинжээч Ж.Занаа болон тайланг Монгол хэлнээс Англи хэл рүү хөрвүүлсэн Л.Болор нартаа талархсанаа илэрхийлье.

Мөн, манай судалгаанд оролцож, өөрсдийн мэдлэг, мэргэшил, туршлагаа харамгүй хуваалцаж, санал бодлоо солилцсон оролцогчдодоо баярласнаа илэрхийлж байна.

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

АН	Ардчилсан нам
АББД	Ажлын байран дахь бэлгийн дарамт
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
ГХЯ	Гадаад хэргийн яам
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЖҮХ	Жендэрийн үндэсний хороо
ЖЭТБХТХ	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль
ЖСХ	Жендэрт суурилсан хүчирхийлэл
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
ИТХ	Иргэдийн төлөөлөгчийн хурал
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
МУ	Монгол Улс
МХЗ	Мянганы хөгжлийн зорилт
МБС	Мэргэжлийн боловсрол сургалт
МБСҮЗ	Мэргэжлийн боловсрол сургалтын үндэсний зөвлөл
МАН	Монгол ардын нам
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НҮЭМ	Нөхөн үржихүйн эрүүл мэнд
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОУБ	Олон улсын байгууллага
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
ТББ	Төрийн бус байгууллага
УИХ	Улсын их хурал
УЕПГ	Улсын ерөнхий прокурорын газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ХБХЕГ	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар
ХХГХ	Хүн худалдаалах гэмт хэрэг
ХМХ	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл
ХЭ	Хүний эрх
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШХА	Швейцарийн хөгжлийн агентлаг
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХ	Эрүүгийн хууль
ЭАБХУТК	Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц
UPR	Хүний эрхийн төлөв байдлын тайлан

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Энэхүү судалгаа нь Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын хэрэгжилтийг үнэлэх замаар Монгол Улс дахь эмэгтэйчүүдийн эрхийн төлөв байдлыг тодорхойлох үндсэн зорилготой юм. Судалгааны үр дүнг тус Конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын бэлтгэсэн 10 дахь илтгэлийн зэрэгцээ “Альтернатив илтгэл”-ийг бичих үндсэн эх сурвалж болгон ашиглах тул бид судалгааны хүрээг 2015-2019 оноор тодорхойллоо.

СУДАЛГААНЫ ЗОРИЛТ

1. Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцыг хэрэгжүүлэх чиглэлээр өгсөн зөвлөмжийн дагуу өнгөрсөн 4 жилийн хугацаанд Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, түүний ахиц, дэвшил болон цаашид анхаарах асуудлуудыг тодорхойлох;
2. Монгол Улс дахь эмэгтэйчүүдийн зөрчигдөж буй эрх, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох.

СУДАЛГААНЫ АСУУЛТУУД:

Бид дараах асуудлуудын хүрээнд Монгол Улс дахь эмэгтэйчүүдийн эрхийн нөхцөл байдлыг тодорхойлохыг зорьсон.

1. Жендэрт суурилсан хүчирхийлэл (Гэр бүлийн хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэрэг, ажлын байран дахь бэлгийн дарамт, бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх гэмт хэрэг)
2. Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо
3. Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах үндэсний тогтолцоо
4. Хөдөөгийн эмэгтэйчүүдэд тулгамдаж буй асуудлууд
5. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэнд тулгамдаж буй асуудлууд
6. Гэрлэлт, гэр бүлийн харилцаа
7. Эмэгтэйчүүдийн боловсрол
8. Эмэгтэйчүүдийн эрүүл мэнд

Эдгээр асуудлын дагуу судалгааны асуултуудыг боловсруулахдаа, ЭАБХУТК болон Конвенцын хэрэгжилтийн асуудлаарх Засгийн газрын 10 дахь илтгэлд тусгах асуудлын жагсаалтыг гол эх сурвалжаа болгосон. Судалгааг чиглүүлэх асуултыг дараах байдлаар томъёолов:

- Сонгосон асуудлуудын (дээр дурдсан 8 асуудал) хүрээнд эмэгтэйчүүдийн өнөөгийн нөхцөл байдал ямар байна вэ?
- Эмэгтэйчүүдийн эрх зөрчигдөхөд соёл уламжлал, бодлогын орчин мөн нийгэм-эдийн засгийн ямар хүчин зүйлс нөлөөлж байна вэ?
- Монгол Улсад хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа хууль, хөтөлбөрүүд нь сонгосон асуудлуудын хүрээнд эмэгтэйчүүдийн эрхийг хэрхэн баталгаажуулж мөн хэрхэн зөрчиж байна вэ?
- Монгол Улсын Засгийн газар 2015-2019 оны хооронд ЭАБХУТК-ын хэрэгжилтийг хангах чиглэлээр ямар үйл ажиллагаа хэрэгжүүлсэн, ямар үр дүн гарсан бэ?

СУДАЛГААНЫ ЗАГВАР:

Бид судалгааны дараах загваруудыг ашиглан энэхүү судалгааг хийж гүйцэтгэлээ.

Баримт бичиг шинжлэх судалгаа /literature review

Монгол Улс дахь эмэгтэйчүүдийн эрхийн нөхцөл байдлыг сонгосон асуудлын хүрээнд бид Монгол Улсад хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа хууль, үндэсний хөтөлбөр болон төрийн байгууллага, олон улсын байгууллагаас эмэгтэйчүүдийн эрх болон бидний сонгосон асуудлын хүрээнд 2015-2019 оны хооронд хийсэн судалгааны тайлангуудад дүн шинжилгээ хийлээ. Дүн шинжилгээг агуулгын шинжилгээний аргаар боловсруулсан бөгөөд асуудал тус бүрээр баримтын судалгаа хийх аргачлалыг нарийвчлан боловсруулсан (Хавсралт 1). Тус аргачлалыг судалгааны үндсэн асуултууд, ЭАБХУТК болон Конвенцын хэрэгжилтийн асуудлаарх Засгийн Газрын 10 дахь илтгэлд тусгах асуудлын жагсаалтыг үндэслэн боловсруулсан. Баримтын судалгааны хүрээнд бид нийт 44 хууль, 13 үндэсний хөтөлбөр, 40 орчим судалгааны тайланд дүн шинжилгээ хийлээ.

Чанарын судалгаа

Баримтын судалгааны үр дүнд үндэслэн эмэгтэйчүүдийн эрх хөндөгдөж, зөрчигдөхөд хамгийн их нөлөөлж буй хүчин зүйлс, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг гүнзгийрүүлэн судлах зорилгоор зорилтот бүлгүүд, экспертүүдтэй ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага хийв. Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагыг урьдчилан боловсруулсан асуултын дагуу хөтлөн явуулаа (Хавсралт 1). Чанарын судалгааг эхлэхийн өмнө судлаачдад судалгааны ёс зүй болон мэдээлэл цуглуулах үед анхаарах асуудлын талаар танилцуулах сургалт явуулсан.

Тоон судалгаа

Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, түүн дотроо бага насны хүүхэдтэй эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд тулгамдаж буй асуудлын талаар өмнө хийгдсэн судалгаа хомс байсан тул нөхцөл байдлын талаар тодорхой мэдээлэл авах үүднээс асуумж судалгаа хийв (Хавсралт 1).

Судалгаанд ашигласан загварыг сонгосон асуудал тус бүрээр Хүснэгт 1-т томъёолон харуулав.

СУДАЛГААНД АШИГЛАСАН АРГУУД

	Баримтын судалгаа	Ганцаарчилсан ярилцлага (эксперт болон зорилтот бүлгийн эмэгтэйчүүд)	Фокус бүлгийн ярилцлага	Асуумж судалгаа
Жендэрт суурилсан хүчирхийлэл; Гэрлэлт, гэр бүл	✓	25	✗	✗
Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо	✓	20	3	✗
Малчин эмэгтэйчүүдэд тулгамдаж буй асуудлууд	✓	12	3	✗
Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудлууд	✓	7	3	718

*Бүлгийн ярилцлагын нэг бүлэг нь 8-10 хүний бүрэлдэхүүнтэй байна.

Оролцооны судалгаа

Судалгааг эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах чиглэлээр ажилладаг 19 төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн 4 баг хийж гүйцэтгэв.

Улаанбаатар хот, Баян-Өлгий, Архангай, Завхан аймагт үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллага, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах чиглэлээр ажилладаг ТББ-уудын төлөөлөл хамгийн их зөрчигддөг эмэгтэйчүүдийн эрх, цаашид анхаарах зүйл, орхигдсон асуудлууд зэрэг танадалтын цар хүрээ, судалгааны асуудлыг хэлэлцэж сонгох, арга зүй боловсруулах, баримтын судалгааны эх сурвалжийг тодорхойлох, мэдээлэл цуглуулах, тоон болон чанарын мэдээлэлд дүн шинжилгээ хийх, үр дүнг нэгтгэх, боловсруулах зэрэг ажлын бүх түвшинд уг төслийг удирдан зохион байгуулсан Монголын эмэгтэйчүүдийн сан, ахлах судлаачидтай хамтран шийдвэр гарган, оролцож ажилласан.

Нийгмийн судалгаа, ялангуяа нийгмийн орхигдсон бүлэг, хамгийн эмзэг нөхцөлд буй хүн амын асуудлыг гаргаж ирэх, түүнийг бодлого боловсруулагчдад хүргэхэд энэ бүлэгтэй ажилладаг иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллийг судалгааны зөвлөлдөх, шийдвэр гаргах бүх түвшинд оролцуулсан нь орхигдсон бүлэг, олон нийт, иргэний нийгмийн байгууллагыг үр өгөөж хүртэж, үр шимийг хүлээн авагч гэхээсээ илүү эрх ашгийнхаа төлөө өөрсдөө шийдвэр гаргахад оролцох, дуу хоолойгоо хүргэх чухал алхам болж байгаа юм.

СУДАЛГААНЫ ТҮҮВЭР:

Дэлхий нийтийг хамарсан COVID-19 цар тахлын халдварын улмаас судалгааны мэдээлэл цуглуулах үйл явцад бэрхшээл тулгарсан. Иймд бид чанарын судалгаанд зорилтот түүврийн аргыг ашиглав. Харин асуумж судалгааг онлайн хэлбэрээр авсан ба судалгаанд нийт 718 хүн оролцсон.

Судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийх арга:

- Баримтын судалгааны үр дүн болон чанарын судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийхдээ фрэмворк (framework) матрицын аргыг ашиглан агуулгын шинжилгээ хийв. (Хавсралт 1).
- Тоон судалгааны мэдээлэлд SPSS програмыг ашиглан дүн шинжилгээ хийлээ.

СУДАЛГААНЫ БАГ:

Олон улсын зөвлөх байгууллага:

- International Women's Rights Action Watch Asia Pacific (IWRAP Asia Pacific)

Зөвлөх:

- Ж.Занаа, Жендэрийн үндэсний шинжээч

Судалгааны ажлын хэсгийн зохицуулагч:

- Ч.Уянга, Монголын эмэгтэйчүүдийн сан, Мониторинг үнэлгээ хариуцсан ажилтан;

Ахлах судлаачид:

- Г.Золжаргалан, MSW, Нийгмийн ажлын магистр. АШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн багш, судлаач;
- Т.Цогзолмаа, LL.M/ Хууль зүйн ухааны магистр. Хүйсийн тэгш эрх төв ТББ;

Жендэрт суурилсан хүчирхийлэл (гэр бүлийн хүчирхийлэл; хүн худалдаалах гэмт хэрэг; бэлгийн дарамт, бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх гэмт хэрэг; ажлын байрны бэлгийн дарамт), гэрлэлт, гэр бүл:

Багийн ахлагч:

- С.Дондов, Иргэдэд туслах хүний эрхийн төв ТББ, Тэргүүн, өмгөөлөгч;

Гишүүд:

- Н.Арвинтариа, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Гүйцэтгэх захирал;
- Т.Цогзолмаа, Хүйсийн тэгш эрх төв, судлаач;
- Б.Болормаа, Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо, Хөтөлбөр хариуцсан зохицуулагч;
- Т.Наранцэцэг, Монфемнет Үндэсний Сүлжээ, Санхүү, захиргааны ажилтан;

Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо:

Багийн ахлагч:

- М.Болормаа, Эмэгтэй удирдагч сан, Тэргүүн

Гишүүд:

- Б.Батцэнгэл, Эмэгтэй удирдагч сан, Хэвлэл Мэдээлэл, Олон нийт хариуцсан зөвлөх;
- А.Отгончимэг, Монголын багш эцэг эхийн холбоо ТББ, Тэргүүн;
- П.Даваанамжил, Монголын Эмэгтэйчүүдийн Сан, Тэтгэлэг олгох хөтөлбөрийн зохицуулагч;

Хөдөөгийн эмэгтэйчүүдийн асуудал:

Багийн ахлагч:

- Н.Баярсайхан, Хил хязгааргүй алхам ТББ, Тэргүүн;

Гишүүд:

- Хайса Зауреш, Казах Эмэгтэйчүүдийн «Арулар» Холбоо, Гүйцэтгэх Захирал;
- М.Дуламжав, Өрнөх хөгжил сүлжээ ТББ, Гүйцэтгэх захирал, Завхан аймаг;
- Г.Баярхүү, Либерал Эмэгтэйчүүдийн Оюуны Сан ТББ, Архангай салбар;

Эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрх, эрүүл мэнд, боловсролын асуудлууд:

Багийн ахлагч:

- Ш.Ариунаа, Монголын Эмэгтэйчүүдийн Хөдөлмөрийг Дэмжих Холбоо, Тэргүүн;

Гишүүд:

- Б.Алтанчимэг, Нөхөн үржихүйн эрх сүлжээ ТББ, Ерөнхий зохицуулагч;
- Ц.Бүжидмаа, Либерал Эмэгтэйчүүдийн Оюуны Сан ТББ, доктор;
- Ц.Отгонтунгалаг, Монголын үйлдвэрчний эвлэлийн Холбооны Хөдөлмөрийн хяналт, хуулийн бодлогын газрын дарга;
- А.Оюундалай, Монголын Эмэгтэйчүүдийн Хөдөлмөрийг Дэмжих Холбооны Хөвсгөл аймаг дахь салбарын зохицуулагч;
- Н.Эрдэнэсүвд, Монголын Эмэгтэйчүүдийн Хөдөлмөрийг Дэмжих Холбооны Өвөрхангай аймаг дахь салбарын зохицуулагч, Өвөрхангай аймаг, Арвайхээр сум;
- Т.Эрхэмбаяр, Нийгмийн ажлын үйлчилгээ, үнэлгээний төв, судлаач;

Хянан тохиолдуулсан:

- Ч.Уянга, Монголын эмэгтэйчүүдийн сан, Мониторинг үнэлгээ хариуцсан ажилтан

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ

1. “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-ийн шинэчилсэн найруулга (2017 он) хэрэгжиж эхэлснээс хойш цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийн тоо, 2017 онтой харьцуулахад бараг 2 дахин өссөн бол Эрүүгийн хуулийн 11.7 (гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх)-д заасан гэмт хэрэг буурах хандлагатай байна. Бүртгэгдсэн гэмт хэрэг буурч байгаа ч гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирогч хүнд гэмтэх, амиа алдах болон хүүхэд хохирох хэрэг өсөх хандлагатай байна. “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгыг баталснаас хойш гэр бүлийн хүчирхийллийн улмаас 15 хүн амиа алдсан байна.
2. “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-д хохирогчид үйлчилгээ үзүүлэхэд хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй болон сэтгэцийн эмгэгтэй хүний хэрэгцээ, шаардлагыг харгалзана гэж заасан боловч хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн үйлчилгээ байхгүй байна. Сонсголын бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүд гэр бүлийн хүчирхийлэл болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн тохиолдолд дуудлага хүлээн авах тусгай дугаар, тоноглол, бэлтгэгдсэн хүний нөөц байхгүй, Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төвүүдэд тэргэнцэртэй, харааны бэрхшээлтэй хүн нэвтэрч орох боломжгүй, хууль, шүүх, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай дохионы хэлмэрч, хөтөч байхгүй байгаа нь тэд эрхээ бүрэн эдэлж чадахгүйд хүрч байна.
3. 2020 оны 01-р сард АББД-тай тэмцэх хуулийн зохицуулалтыг шаардсан иргэний нийгмийн байгууллагын нөлөөллийн ажлын үр дүнд МУ-ын Зөрчлийн тухай хуулийн 6.26-д “Ажлын байрны бэлгийн дарамт бусдад учруулсан бол торгох, албадан сургалтад хамруулах, баривчлах шийтгэл оногдуулах, ажил олгогч хөдөлмөрийн дотоод журамдаа АББД-аас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг барагдуулах хэм хэмжээг тусгах үүргээ биелүүлээгүй” бол хуулийн этгээдийг торгох зохицуулалттай болсон.
4. Цагдаагийн байгууллагад бүртгэгдэж байгаа “хүчиндэх” гэмт хэргийн тоо тасралтгүй өсч байна. Сүүлийн 3 жилийн хугацаанд өдөрт 1 хэрэг бүртгэгдэн, шалгагдаж байна. Хохирогчдын 80 орчим хувийг 10-29 насны охид, эмэгтэйчүүд, 46.8%-ийг 8-17 насны охид эзэлж байна.
5. Бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчийг шүүхээр хэргээ шийдвэрлүүлэх явцад хувийн нууцтай байх, хамгаалагдах эрх зөрчигдөж байна. Бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх гэмт хэргийн хохирогчдод нөхөн сэргээх, үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээ байхгүйгээс бүх шатны байгууллагаар өөрөө явж үйлчилгээ авдаг нь, цаг хугацаа, сэтгэл санааны хувьд давхар хохирлыг учруулж байна.
6. Монгол Улсад мэргэшсэн, туршлагатай мэргэжилтэн дутмаг, мэргэжилтнүүд сэтгэл зүйд үүссэн цочрол, гэмтлийг тогтоох (trauma-informed systems of care) талаар ойлголтгүй байна. Бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх гэмт хэргийн хохирогчдод учирсан хор хохирлыг мөнгөн хэлбэрээр тооцох, сэтгэл санааны хохирол болон нөхөн сэргээх зардлыг тооцож олгодоггүйгээс шүүхээс зөвхөн эрүүл мэндийг нь нөхөн сэргээхэд зарцуулсан баримтад тулгуурлан хохирлыг тогтоож байна.
7. Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх, хууль, эрх зүйн орчин шинэчлэгдэн сайжирсан хэдий ч энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, шийдвэрлэх байдал хангалтгүй байна. Цагдаагийн ерөнхий газрын мэдээллээр 2015 оноос 2020 оны эхний улиралд “Хүн худалдаалах” гэмт хэргээр (2002 оны Эрүүгийн хуулийн 113-р зүйл, 2015 оны Эрүүгийн хуулийн 13.1-р зүйл) нийт цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн 45 эрүүгийн хэргээс шүүхээр 19 хэрэг шийдвэрлэгдсэн байна. Үүнээс дүгнэхэд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хэргийн дөнгөж 37 % нь шүүхээр

шийдвэрлэгдэж байна. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой эрүүгийн нэг ч хэрэг 2017 онд шүүхээр шийдвэрлэгдээгүй байна. Энэ нь хүний наймаатай тэмцэх эрх зүйн орчин болон бодит нөөц хангалтгүй байгааг харуулж байна.

8. Сүүлийн жилүүдэд хүний наймааны хөдөлмөрийн мөлжлөгийн илрүүлэлт хангалтгүй, иргэдийн дунд энэ тухай ойлголт мэдлэг муугаас хохирогч болох, хуулийн байгууллагад мэдээлэхгүй байх, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид, хувийн аж ахуйн нэгж, компани, хувиараа аж ахуй эрхлэгчид, малчдын дунд бусдын хөдөлмөрийг мөлжих явдал түгээмэл байна. Хөдөлмөрийн мөлжлөг, цус, эд эрхтэн авч ашиглах хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн нэг ч тохиолдол шүүхээр шийдвэрлэгдээгүй, цагдаагийн байгууллагад бүртгэгдээгүй байна.
9. Хүний наймаатай холбоотой гэмт хэргийн илрүүлэлт зөвхөн Улаанбаатар хотоор хязгаарлагдаж байна. Тиймээс энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх нэгжийг өргөжүүлж, үндэсний хэмжээнд ажиллах бүтцийг бий болгох шаардлагатай. Мөн хүний наймаатай холбоотой гэмт хэргийг мөрдөн шалгах тусгай тасаг бий болгох эсвэл мөрдөгчийн тоог нэмэгдүүлэх, тэднийг мэргэшүүлэх чиглэлээр сургах хэрэгцээ шаардлага байна.

ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИН ДЭХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦОО

10. Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улс ЖЭТБХТХуульд заасны дагуу улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх түр тусгай арга хэмжээг 30%-аас доошгүй байхаар тогтоосныг 20% болгож бууруулсан. Одоогийн байдлаар эмэгтэйчүүдийн эзлэх хувь УИХ-д 17.4%, Засгийн газарт 0.7%, Яамдын дэд сайдад 7.7%, хэрэгжүүлэгч агентлагт 3.3%, нутгийн удирдлагад 18.2% байгаа нь түр болон тусгай арга хэмжээний үр дүн Үндсэн хууль болон ЭАБХУТКонвенцын зарчимд нийцэхгүй хэвээр байгааг харуулж байна.
11. Монгол Улсад 2008 оноос хойш улс төрийн намууд сонгуулийн тогтолцоо, нэр дэвших явцыг улс төрийн бизнес болгож, нэр дэвшигчид нь намдаа дэнчин гэж 50-100 сая, түүнээс дээш төгрөгийг төлж байна. Энэ нь зөвхөн мөнгөтэй хүн нэр дэвших, сонгогдох боломжтой гэсэн ойлголтыг төрүүлж ялангуяа эмэгтэйчүүдийн оролцооны эрхийг хязгаарлаж, хөрөнгө, санхүүгээр ялгаварлаж байна.
12. Жендэрийн хэвшмэл ойлголтоос улбаалан монгол эмэгтэйчүүдийн эрх төдийлөн сайн хангагдахгүй байна. Жишээ нь эмэгтэйчүүдийн дунд хүчирхийллийг тэвчих, санал нийлэхгүй ч нөхрийнхөө үгийг дагах, нөхөр шийдвэр гаргах ёстой гэсэн хандлага түгээмэл байна. Эмэгтэйчүүдийг буруутгах хандлага нийгмийн бүх салбарт хадгалагдсаар байна.
13. Жендэрийн хэвшмэл ойлголтоос гадна тодорхой бүлгийн хүн амын талаарх хэвшмэл ойлголт нийгэмд оршин тогтносон хэвээр байна. Жишээлбэл хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг өөрсдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудлаар шийдвэр гаргах чадваргүй, гэр бүлийнхэн нь тэдний амьдралд оролцох ёстой гэсэн хэвшмэл ойлголт нь олон нийтийн дунд, мөн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын дунд түгээмэл байна. Үүнээс улбаалан тухайн бүлэг, түүн дотор хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн тусламж үйлчилгээ авах, өөрсдөө бие даан шийдвэр гаргах эрх зөрчигдөж байна.

ХӨДӨӨГИЙН ЭМЭГТЭЙЧҮҮД

14. 2019 оны жилийн эцсийн мэдээгээр 171,605 малчин өрхийн 119 мянган малчин эмэгтэй байгаа бөгөөд мал аж ахуйн салбарт ажиллагсад нь хөдөлмөр эрхэлж буй нийт иргэдийн 30 %-ийг эзэлж байна. Мал аж ахуй нь уламжлалт нүүдлийн, фермерийн, төв сууринд ойр гэсэн төрөл байна. Төрөөс сүүлийн 10 жилд эрчимжсэн аж ахуйг дэмжихээр түлхүү анхаарснаас нүүдлийн уламжлалт малчид руу чиглэсэн төрийн бодлого, дэмжлэг, нийгмийн үйлчилгээний тогтолцоо суларсан байна.

15. Монгол Улсын хэмжээнд хөдөөгийн эмэгтэйчүүдийн алагчлалаас ангид байх эрхийн хэрэгжилтийн асуудлаар ул суурьтай цогц суурь судалгаа хомс, судлагдахуун болтол анхаарч үзээгүй учраас тоон мэдээ, мэдээлэл бүрэн гаргаж чадахгүй байна.
16. Монгол Улсад 3 хүн тутмын 1 нь ядуу, 1 нь ядуурлын шугамаас дөнгөж дээр буюу эдийн засаг, үнийн өсөлт, уур амьсгал, эрүүл мэнд зэрэг гэнэтийн эрсдэл үүсэхэд ядууралд өртөх эрсдэлтэй байна. Нийт хүн амд хөдөөгийн хүн амын эзлэх хувь бага ч хөдөөд ядуурлын түвшин тогтвортой биш, хэт савлагаатай, байгалийн аясаар оршин тогтнодог нүүдлийн уламжлалт мал аж ахуй эрхлэгч малчид ядууралд өртөх тун ойр туйлын эмзэг байдалд байна.
17. Малчдын эрүүл мэндийн үйлчилгээ авах боломж нь малчид хамгийн ойр өрх/сумын эмнэлэг хүртэл дунджаар 25.0 км, аймаг, дүүргийн эмнэлгээс хамгийн ойр нь дунджаар 90 км явж үйлчлүүлэх, нийслэлийн нарийн мэргэжлийн эмнэлэгт очиход талдаа 1800 км орчим холоос явж үйлчилгээ авч байна.
18. Хөдөөд нийт хүн амын 30.8% нь ядуу байгаа нь хот суурин газрын ядуурлын (27.2%) түвшнээс бага зэрэг өндөр байна. Ядуурлын байдал хот суурин газар, хөдөөд ялгаатайн зэрэгцээ газар зүйн байршлаар мөн өөр өөр байна. Улаанбаатар хотод аймгийн төвүүдтэй харьцуулахад, мөн сумын төвд хөдөө нутгийнхтай харьцуулахад ядуурлын түвшин бага байна.

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

19. 2018 оны статистикаас харахад хүн амын ядуурлын хүрээ 2018 онд 28.4 % болж 2016 онтой харьцуулахад ялимгүй буурсан байна. Гэвч ядуурлын шугамыг 25%- иар өсгөхөд нийт хүн амын 14.9% буюу 474.8 мянган хүн ядууралд өртөх эрсдэлтэй байна.
20. Үндэсний статистикийн хорооны мэдээллийн сангаас харахад 2019 оны 4-р улирлын байдлаар нийт ажиллах хүч болох 1,293,579 мянган хүний 594,368 нь эмэгтэйчүүд байна. Нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 52.4%- ийг эмэгтэйчүүд эзэлж байна. Дундаж цалин улсын хэмжээнд 2019 оны 3-р улирлын байдлаар 1,287,600₮ байгаа ба хүйсээр харьцуулж үзэхэд эмэгтэйчүүдийн хувьд 1,040,200₮ буюу 19.3%-аар доогуур байна.
21. Бага насны хүүхэдтэй, жирэмсэн эмэгтэйчүүд хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхагдаж байна. Жишээ нь 718 эмэгтэй оролцсон судалгааны үр дүнгээс харахад 22.1%-д нь жирэмсэн болон нялх хүүхэдтэй байх үед ажлаас халахыг шаардсан тохиолдол байсан, 37% нь ямар нэг төрлийн ялгаварлан гадуурхалтад өртсөн байна. Мөн хүүхэд харах хүнгүй, цэцэрлэг ясли хүрэлцээгүй, ажил, цэцэрлэгийн цуглах, тарах цаг давхцадаг зэрэг асуудал эмэгтэйчүүд ажил хөдөлмөр эрхлэхэд хамгийн том бэрхшээл болж байгааг тус судалгаанд оролцогчид хариулжээ.
22. Монгол Улсад хөдөлмөрийн хяналтын тогтолцоо хангалтгүй байна. Мөн хөдөлмөрийн хяналтын байцаагчийн орон тоо дутагдалтайгаас ажлын байр хяналтгүй, урьдчилан сэргийлдэггүй, мөн хөдөлмөрлөх эрхтэй холбоотой гомдол, санал шийдвэрлэгдэхгүй өнгөрч байна.
23. Засгийн газар цалинтай ээж, олон хүүхэдтэй, өрх толгойлсон эмэгтэйчүүдийн нийгмийн баталгааж хангах нийгмийн халамжийн тодорхой хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Гэвч эдгээр хөтөлбөрийн хүрээнд олгогдсон мөнгөн тэтгэмж нь амьжиргаанд нь хүрэлцэхгүй, цалинтай хөдөлмөр эрхлэх тохиолдолд цуцлагдах нөхцөлтэй байгаа нь "эмэгтэйчүүд бол хүүхэд гаргах, гэр бүлээ асран халамжлан гэртээ суух үүрэгтэй" гэсэн хэвшмэл ойлголтыг хөхиүлэн дэмжиж байна.
24. Сүүлийн хоёр жилд Монгол Улсын нэг хүнд ногдох ДНБ-ний жилийн дундаж өсөлт 4.4% байв. Энэ өсөлтийн гуравны нэг нь уул уурхайн салбараас хамааралтай боловч тус салбар нь нийт ажиллагсдын 6 орчим хувийг л ажлын байраар хангадаг. Уул уурхайн салбарт түшиглэсэн эдийн засгийн өсөлтийг бүх ажиллагсад тэгш хүртэж чаддаггүйн зэрэгцээ ур чадвар шаардахгүй бага

цалинтай үйлчилгээний ажил эрхэлдэг олон тооны ажиллагсад, тэр дундаа эмэгтэйчүүд өсөлтийн үр өгөөжийг хүртэж чадахгүй үлдсээр байна.

ЭМЭГТЭЙЧҮҮД ЭРҮҮЛ МЭНД

25. 2018 оны байдлаар эмэгтэйчүүдийн дунд тохиолдож байгаа хорт хавдрын эхний тавд элэг (33%), умайн хүзүү (12,4%), ходоод (10,3%), хөх (8,1%), улаан хоолой (5,9%) байна. Умайн хүзүүний хорт хавдрын 372 шинэ тохиолдол бүртгэгдсэн нь 100,000 эмэгтэй хүн амд 23.2 байна. 100,000 эмэгтэй хүн амд Дархан-Уул, Сэлэнгэ, Дорнод, Говьсүмбэр, Говь-Алтай, Баянхонгор, Хэнтий, Өмнөговь, Дундговь аймагт улсын дунджаас /23.2%/ -иар өндөр байна. Хорт хавдрын оношлогдох үеийг харахад умайн хүзүүний өмөнгийн нийт тохиолдлын 49.0% нь 2-р үе шатандаа оношлогдсон нь өмнөх онтой харьцуулахад буураагүй байна.
26. Манай улс нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлдэг хэдий ч, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн хувьд тулгамдсан асуудал хэвээр байна. Жишээ нь ХЭҮК-ийн Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлд (2019) дурдсанаар өрхийн эрүүл мэндийн төвүүдэд эмэгтэйчүүдийн эмчгүй, эсхүл эмч нар нь туршлага багатай, дүүргийн эмнэлэгт үзүүлэхэд 1-2 сар хүлээдэг, эмнэлэгт дохионы хэлний орчуулагч байдаггүй, эмч нарын ажлын ачаалал их, харилцаа хандлага муу зэргээс шалтгаалан эрүүл мэндийн байгууллагаас дээрх үйлчилгээг авахад хүндрэлтэй байдаг байна. Мөн хотод болон орон нутагт оюуны бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд жирэмслэлтээс сэргийлэх тариаг заавал хийдэг, татгалзсан тохиолдолд халамжийн тэтгэмж олгохгүй, асаргааг сунгахгүй гэх мэтээр халамжийн ажилтан, өрхийн эмч нар дарамт үзүүлж хүчээр хийдэг байна.
27. Сумын эмнэлгийн төсөв хангалтгүйгээс эм тариа ховор тул эм тариагаа өөрсдөө худалдаж авах хэрэгцээ үүсдэг. Хөдөөд эмийн үнэ их өндөр, үйлдвэрлэсэн улсаас шалтгаалан нэг төрлийн эм, тарианы үнэ хэт зөрүүтэй тул хамгийн сайн эмчилгээ хийлгэхийн тулд үнэтэйг авах, санхүүгийн боломжгүй ядуу малчид хамгийн хямдыг авснаар эмчилгээнд итгэлгүй болж, эргэлзэх, улмаар зээл авч үнэтэй эм тариа авах зайлшгүй шаардлага гардаг нь малчин эмэгтэйчүүдэд эдийн засгийн дарамт болдог.

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН БОЛОВСРОЛ

28. Нийт хүүхдийн 20.2% буюу таван хүүхэд тутмын нэг нь сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж чадахгүй, ялангуяа хот суурин газрын ядуу болон шилжин суурьшсан өрхийн хүүхэд, хөдөөгийн малчдын хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамгийн их өртөж байна. Сургуулийн өмнөх боловсролын талаар дэвшүүлсэн зорилтыг бүрэн хангах, бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нийгэм, эдийн засгийн салбарын бодлогын уялдаа, оролцооны үр өгөөж хангалттай түвшинд тогтвортой байж чадахгүй байна.
29. Эмэгтэйчүүд, охидын боловсролын асуудлаар тусгайлсан судалгаа байхгүй, судалгааны тайлангуудад энэ тухай тусгагдахгүй байна. Мөн хүчирхийлэлд өртсөн болон жирэмсэн охидын талаарх нэгдсэн тоо мэдээлэл байхгүй, түүнчлэн тэдэнд чиглэсэн ямар нэгэн цогц үйлчилгээ байхгүй байна.
30. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 12-р зүйлийн 12.3 - т Боловсролын байгууллагын үйл ажиллагааны тайланд жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлын үр дүн, гарсан зөрчил, түүнийг арилгах талаар авсан арга хэмжээг тусгах бөгөөд жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлын үр дүн нь сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгчийн үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх шалгуур үзүүлэлтийн нэг байна гэж заасан ч сургуулийн удирдах ажилтнууд тус хуулийн талаар хангалттай ойлголт мэдээлэлгүй байна.

ГЭРЛЭЛТ, ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦАА

31. Үндэсний статистикийн хорооны мэдээгээр гэр бүл цуцлалт 2015 онд 3873, 2016 онд 4003, 2017 онд 3945, 2018 онд 4201, 2019 онд 4262 байна. Үүнийг хугацаагаар нь авч үзвэл долоогоос дээш жил амьдарсан гэр бүл олонх нь байна.
32. Гэр бүлийн тухай хуулиар хүүхдийн тэтгэмжийг тогтоохдоо 0-11 насны хүүхдэд амьжиргааны баталгаажих түвшингийн 50%-иар, 11-ээс дээш насны хүүхдэд 100%-иар тогтоож байгаа нь гэрлэлтээ цуцлуулж хүүхдийн тэтгэвэр тогтоолгож буй эмэгтэйчүүд, хүүхдийнхээ амьдралын наад захын хэрэгцээг хангаж чадахгүй байна. Жишээ нь, амьжиргааны баталгаажих доод түвшин 2020 онд 230,000 төгрөг, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 420,000 төгрөг байхад дундаж цалин 1,200,000 орчим төгрөг байна. Иймд хүүхдийн тэтгэмжийг тогтоохдоо хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, эсвэл дундаж цалинтай дүйцүүлэн тогтоох эрх зүйн орчин бий болгох, сайжруулах шаардлагатай байна.
33. Шүүхээс хүүхдийн тэтгэлгийг тогтоодог боловч шийдвэр гүйцэтгэл дээр очоод биелэгддэггүй. Хариуцагч “ажил хөдөлмөр эрхэлдэггүй”, “хөдөлмөрийн чадваргүй (өвчтэй)”, “шоронд ял эдэлж байгаа” гэх мэт шалтгаанаар хүүхдийн тэтгэмж төлөгдөхгүй байна.
34. 1999 оны Гэр бүлийн тухай хуулинд 5 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан боловч тус хууль нийгмийн шинэчлэлт, өөрчлөлтөнд нийцэхгүй байна. 2016 онд хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд “хүүхдийн тэтгэлгийн сан”-г тусгаж, тус сан нь хугацаандаа хүүхдийн тэтгэмж төлөөгүй үед алданги тооцох зохицуулалтыг оруулсан. Гэвч бодлого боловсруулагчдаас дэмжлэг авч чадаагүй тул хуулийн төслийн хэлэлцүүлгийн үед уг зохицуулалт хасагдсан байна.



**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ:
ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ**

1

БАРИМТЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

1.1 ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ:

Гэр бүлийн хүчирхийлэл:

- “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга” (2017 он) хэрэгжиж эхэлснээс хойш цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийн тоо 2017 онтой харьцуулахад бараг 2 дахин өссөн бол эрүүгийн хуулийн 11.7 (гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх)-д заасан гэмт хэрэг буурах хандлагатай байна. (Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, 2019а; Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, 2018). Бүртгэгдсэн гэмт хэрэг буурч байгаа ч гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирогч хүнд гэмтэх, амиа алдах болон хүүхэд хохирсон хэрэг өсөх хандлагатай байна. “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгыг баталснаас хойш гэр бүлийн хүчирхийллийн улмаас 15 хүн амиа алдсан байна (Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, 2019b). Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн 60 орчим хувь нь Улаанбаатар хотод үйлдэгдэж, нийт хохирогчдын 92.4%-ийг эмэгтэйчүүд эзэлж байна (Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, 2019a).
- Малчин өрхийн 15% нь гэр бүлийн хүчирхийллийн асуудалтай, тэдний дунд 35-49 насны гэр бүл зонхилдог ба бэлгийн болон бие махбодийн хүчирхийллийг тэвчих хандлага хөдөөгийн эмэгтэйчүүдийн дунд илүү байгааг 2014, 2015 онд хийсэн судалгааны үр дүн харуулж байна (Жендэрийн үндэсний хороо, 2019, х.58). Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааны тайланд (2018) дурдсанаар бие махбодийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь аймаг, нийслэлээр ялгаатай, Дархан-Уул, Өмнөговь, Говьсүмбэр, Булган, Ховд аймагт хамгийн өндөр байна. Цагдаад хандаагүй, хандах боломжгүй, тусламж үйлчилгээ авч чадахгүй, алслагдмал нутагт амьдарч байгаа охид эмэгтэйчүүд олон байна (Жендэрийн үндэсний хороо, 2019).
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд “хохирогчид үйлчилгээ үзүүлэхэд хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй болон сэтгэцийн эмгэгтэй хүний хэрэгцээ, шаардлагыг харгалзана” гэж заасан боловч хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн үйлчилгээ байхгүй байна. Сонсголын бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн тохиолдолд дуудлага өгөх тусгай дугаар, тоноглол, бэлтгэгдсэн цагдаагийн ажилтан байхгүй, хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвүүдэд тэргэнцэртэй, харааны бэрхшээлтэй хүн нэвтэрч орох боломжгүй, хууль, шүүх, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай дохионы хэлмэрч, хөтөч байхгүй байна (Хүний эрхийн Үндэсний комисс, 2018).

Хүн худалдаалах гэмт хэрэг:

- Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай бие даасан хуулийг 2012 онд батлан, үүнтэй холбогдуулан Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйл буюу “Хүн худалдаалах” гэмт хэргийн талаарх зүйлд холбогдох нэмэлт өөрчлөлт оруулсан. Бодит байдалд хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх, хууль, эрх зүйн орчин шинэчлэгдэн сайжирч байгаа боловч энэ төрлийн гэмт хэргийн онцлог шинж, хохирогчдод үзүүлэх хамгаалалт, дэмжлэг сул байгаагаас шалтгаалан илрүүлэлт хангалтгүй, хуулийн байгууллага хэргийг маш цөөн шийдвэрлэж байна. Цагдаагийн байгууллагын мэдээллээр 2014-2016 онд нийт 30 хохирогч бүхий 17 хэргийг илрүүлэн шалгасан байна. Харин ХХГХ-ийн хохирогчдод туслалцаа үзүүлдэг Хүйсийн тэгш эрхийн төвийн статистик мэдээллээр тус байгууллага хүн худалдаалах гэмт хэргийн 129 хохирогчид үйлчилгээ үзүүлсэн байна. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын дийлэнх хувийг охид, залуу эмэгтэйчүүд, хөдөлмөрийн насны эрчүүд, цөөнгүй хувийг бага, өсвөр насны хүүхэд эзэлж байна (С.Дондов, 2018).



Ажлын байран дахь бэлгийн дарамт:

- Ажлын байран дахь бэлгийн дарамт нь нийгэмд бодитой оршин байгаа асуудал болохыг 2016 оноос хойш жендэр, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, ажлын байран дахь бэлгийн дарамтын асуудлаар хийсэн судалгаа харуулж байна (Хүйсийн тэгш эрхийн төв, 2018; Жендэрийн үндэсний хороо, 2019; Нийгмийн бодлого хөгжлийн судалгааны хүрээлэн, 2016; Л.Ганбаатар, 2019; Хүний эрхийн Үндэсний комисс, 2017). 2004 онд ажлын байран дахь бэлгийн дарамтын талаарх анхны судалгаанд 5 хүн тутмын нэг нь АББД-т өртдөг, 3 хүн тутмын нэг нь АББД өртсөн хэн нэгнийг мэддэг гэж хариулж байсан. Гэтэл 13 жилийн дараа хийсэн судалгаагаар энэ тоо мэдээ өөрчлөгдөөгүй байна. 2004, 2017 онд хийсэн судалгааны үр дүнгээс харахад төрийн өмчит компанид ажиллагсад илүү энэ төрлийн зөрчил, гэмт хэргийн хохирогч болж байгаа нь тогтоогджээ. МУ-ын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд АББД-тай тэмцэх заалтыг 2011 онд оруулж, ХЭҮК-т үүнтэй холбоотой гомдол гаргах, хянан шийдвэрлүүлэх зохицуулалтыг тусгаж өгсөн нь уг асуудлыг шийдвэрлэх анхны ахиц байв. Гэвч Хүний эрхийн Үндэсний Комисс, ЖҮХ хоёрын ойлголт нэгдмэл бус байгаагаас үүдэн хуулийн хэрэгжилт хангалтгүй байна (Хүйсийн тэгш эрхийн төв, 2018).
- Монголын эмэгтэйчүүдийн сангийн захиалгаар 2016 онд хийсэн онлайн судалгаанд 753 хүн хамрагдсанаас 86,8% нь эмэгтэйчүүд, 93,6% нь дээд боловсролтой байлаа. Ажлын байрны бэлгийн дарамт, зөрчлийн 98%-ийг эрэгтэйчүүд үйлдсэн, дарамт үзүүлэгчдийн 84,3%-ийг 30-59 насны эрэгтэйчүүд байгаа нь АББД бол албан тушаал, эрх мэдэлдээ дулдуйдан шахаж дарамталдаг, улмаар цалин урамшуулал нэмэх, дүн тавих, албан тушаал ахих, гэрээ хэлцэл үргэлжүүлэх эсэх зэрэг өөрийн эрх мэдлээр далайлган шантаажилдаг болохыг нотолж байна. Түүнчлэн судалгаанд оролцогчид, бэлгийн дарамт үйлдсэн 204 хүний 97,5% нь эрэгтэйчүүд гэж хариулсан ба эдгээрийг албан тушаал, ажил мэргэжлийн хувьд авч үзэхэд 88.2% нь дээд боловсролтой, эрх бүхий албан тушаалтан байжээ. Мөн АББД-ын хохирогчдын 57,6%, үйлдэгчдийн 42,8 хувь нь төрийн байгууллагынхан байгаа нь анхаарал татаж байна (АББД-тай тэмцэх ТББ-дын Эвсэл, 2016 он).
- Биеийн тамир, спортын газарт нийт 42 байгууллага, холбоод харьяалагддаг ба 2019 оны эхний 6 сарын байдлаар нийт 704 ажилтан байгаагаас 215 буюу 30.5%- ийг эмэгтэйчүүд эзэлж байна. Энэ 42 байгууллагын удирдах албан тушаалд нэг ч эмэгтэй хүн ажилладаггүй байна. Спортын салбарт АББД-д өртөж хохирогч болсон эмэгтэй тамирчид шигшээ багийн тамирчны бүрэлдэхүүнээс хасагдах, уралдаан тэмцээнд оролцох эрхээ алдах, цаашид спортын төрлөөрөө хичээллэх боломжгүй болох вий гэсэн айдас, болгоомжлол зэргээс шалтгаалан тэвчээд чимээгүй өнгөрдөг мөн тамирчдын хууль, эрх зүйн мэдлэг боловсрол хангалтгүй байгаагаар холбоотой гэж үзсэн байна. Цаашид Спортын салбар дахь жендэрийн үзэл баримтлал, жендэрт суурилсан хүчирхийлэл ялангуяа ажлын байран дахь бэлгийн дарамтын эсрэг, урьдчилан сэргийлэх талаар ойлголт мэдлэг өгөх, бодлого, дүрэм журамд нэмэлт зүйл, заалт оруулах, жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг салбарын жендэрийн нэгдсэн бодлоготой уялдуулан боловсруулж хэрэгжүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах шаардлагатай байна гэсэн дүгнэлтийг 2019 оны судалгаагаар гаргажээ (Эмэгтэй удирдагч сан, 2019).
- Сургуулийн орчин дахь бэлгийн дарамтаас улбаалан охид сургуулиасаа гарч, цаашлаад сургууль, байшингийн дээвэр дээрээс үсэрч амь насаа хохироосон тохиолдол гарсан байна. Сургалтын орчноос гадна дараагийн санаа зовоох талбар нь театр, урлаг, спортын газрын бэлтгэл сургуулилалтын үеэр охид, эмэгтэйчүүд бэлгийн дарамтад өртөж авъяас чадвараа олон нийтэд хүргэж чадахгүй орхиход хүрч байгаа, цахим орчин дахь нийгмийн сүлжээгээр 18-24 насны эмэгтэйчүүдийн 25%, эрэгтэйчүүдийн 13% бэлгийн дарамтад өртсөн болохыг АББД-тай тэмцэх ТББ-ын сүлжээний мэдээлэлд тусгажээ (Жендэрийн үндэсний хороо, 2019, х.61).

Бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх гэмт хэрэг:

- Хүчиндэх гэмт хэргийн тоо тасралтгүй өсч байгаа ба ялангуяа сүүлийн 3 жилийн хугацаанд огцом өсч, ойролцоогоор өдөрт 1 хэрэг бүртгэгдэн, цагдаагийн байгууллагад шалгагдаж байна. Хохирогчдын 80 орчим хувь нь 10-29 насны охид, эмэгтэйчүүд, 46.8% нь 8-17 насны охид байна. (Хүйсийн тэгш эрх төв, 2019; Б.Энхболд, С.Гантулга, Б.Мөнхзул, 2019). Насанд хүрээгүй хүүхэд ялангуяа охидын эсрэг

хүчингийн гэмт хэрэг, үүнд ураг төрлийн бэлгийн хүчирхийлэл нэмэгдэж байгаа ч энэ төрлийн гэмт хэрэгт өртөж буй бага насны хүүхэд, ялангуяа охидын эрхийг хамгаалах эрх зүйн орчин дутмаг байна. Ураг төрлийн болон таньдаг хүндээ хүчиндүүлсэн тохиолдолд хуулийн байгууллагад мэдээлдэггүй, мэдээлсэн ч насанд хүрэгчид хоорондоо "тохиролцоод" хүүхэд хохироод үлддэг нь хохирогчийн эрх ашгийг бүрэн төлөөлж чадаж байгаа эсэхэд эргэлзээ төрүүлж байгааг УЕПГ-ын 2019 оны судалгааны үр дүн харуулжээ. Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 30%-иар өссөн албаны статистик байгаа ч ихэнх тохиолдолд хохирогчид хуулийн байгууллагад хандахгүй өнгөрөөх, хандсан ч хэрэгсэхгүй болгох, өргөдлөө татаж авах, тохиролцоо зэргээр асуудал орхигдож байгаа тул НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн UPR III циклд энэ асуудлаар тусдаа бие даасан тайлан илгээсэн байна (Хүйсийн тэгш эрх төв, 2019). Бэлгийн хүчирхийлэл үйлдсэн тохиолдолд үүнийгээ нэг бус хэд хэдэн удаа үйлдэх хандлагатай байна. Хамтрагчийн үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн талаас илүү хувь нь (54.1%) сүүлийн 12 сарын хугацаанд хэд хэдэн удаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн байхад 45.5% нь амьдралдаа хэд хэдэн (2-5) удаа хамтрагчийн бэлгийн хүчирхийлэлд өртжээ. Харин бусдын зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд долоон эмэгтэй тутмын нэг нь (14.0 хувь) амьдралдаа наад зах нь бэлгийн хүчирхийлэлд нэг удаа өртсөн байхад сүүлийн 12 сард 2.6% нь өртсөн байна. Урьд өмнө хамтрагчтай байсан, одоо хамтрагчтай байгаа эмэгтэйчүүдийн 14.0% нь бусдын зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн байгаа нь Ази, номхон далайн бүсийн бусад орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр байна (Үндэсний статистикийн хороо, 2018).

- Хүчиндэх гэмт хэрэг орон нутагт 2017 онд 48.4% , 2018 онд 48.0%- иар өсчээ. Хүчирхийлэл үйлдэгчийг төрж өссөн, боловсрол эзэмшсэн нутаг дэвсгэрээр нь авч үзвэл 70 орчим хувь нь орон нутгийн иргэд байгаа бол Улаанбаатар хотын харьяалалтай хүчирхийлэл үйлдэгчид харьцангуй цөөн байна. Гэмт хэрэг үйлдэгдсэн нутаг дэвсгэрийн хувьд Улаанбаатар хотод 34 буюу 50.0% , баруун бүсэд 3 буюу 4.4%, зүүн бүсэд 13 буюу 19.1% , хангайн бүсэд 2 буюу 2.9% төвийн бүсэд 16 буюу 23.5% тус тус эзэлж байна (Б.Энхболд, С.Гантулга, Б.Мөнхзул, 2019).
- Сүүлийн 2 жилийн хугацаанд нийт малчдын 7.5% нь хэн нэгэн хүн хүчирхийлэлд өртсөнийг мэдсэн байна. Хүчирхийлэлд өртсөн хүний 3.7% нь бэлгийн хүчирхийлэлд өртсөн талаар сонссон байна. Харин таних, мэдэх хэн нэгнээ хүчирхийлэлд өртсөнийг мэдсэн малчдын 83.4% буюу 5 малчин тутмын 4 нь хүчирхийлэлд өртсөн хүнд өөрийн чадах хэмжээнд тусалсан байна. 5 малчин тутмын 4 нь тэдний амьдарч буй орон нутагт хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр ажилладаг байгууллага огт байхгүй гэж үзэж байна (ММСГ, 2017, х.116).
- Хүчирхийллийн нүцгэн үнэн судалгаанд хамтрагчийн үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн тухай мэдээллээ хуваалцсан эмэгтэйчүүд цөөхөн байсан бөгөөд тэдгээрийн дийлэнх нь 35-аас дээш насны эмэгтэйчүүд байжээ. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн дунд ийм төрлийн хүчирхийлэлд өртөх тохиолдол бас илэрсэн байна. Хамтрагч бэлгийн хүчирхийллийг ямагт бие махбодын хүчирхийлэлтэй хамт үйлддэг байна (Үндэсний статистикийн хороо, 2018, х.51).
- Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн судалгаагаар хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн хувьд хүчирхийлэгч нь танихгүй хүн (24%), жирийн нэг таньдаг хүн (24%), жирийн найз (19%), ажлын хүн (6%), хамаатны ах дүү (7%), найз хөвгүүн (7%), хойд эцэг (5%) байжээ (Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо; Хүний эрхийн үндэсний комисс, 2019).



1.2 БОДЛОГЫН ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ: ДЭМЖИЖ БУЙ ЗОХИЦУУЛАЛТ

Гэр бүлийн хүчирхийлэл:

- **"Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль"** (Төрийн мэдээлэл, №5, 2017)-ийн шинэчилсэн найруулгыг 2016 онд баталсан. Хууль батлагдсанаас хойш хуулийн хэрэгжилт сайн гэж дүгнэсэн. Тухайлбал, Хууль зүй, дотоод хэргийн яам, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Зөвлөлд "гэр бүлийн хүчирхийлэл", "хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх" Дэд зөвлөл байгуулагдсан. Хуулийг даган гарах 33 журмаас 31 журам нь батлагдсан. Улсын хэмжээнд нийт 14 Түр хамгаалах байр, 14 Нэг цэгийн үйлчилгээний төв байгуулагдсан байна.
- 2015 оны шинэчилсэн **"Эрүүгийн хууль"**-д (Төрийн мэдээлэл, №7, 2016) **«Байнга»** гэр бүлийн хүчирхийлэл үйлдэхийг гэмт хэрэгт тооцсон. Мөн түүнчлэн заналхийлэх, мөрдөн мөшгих үйлдлийг гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэх болсон.
- **"Зөрчлийн тухай хууль"**-д 2015 оны (Төрийн мэдээлэл, №24, 2017) гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодох, хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадах, бусадтай харилцахыг хязгаарлах, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах үйлдэлд албадан сургалтад хамруулж 7-30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулах, түүнчлэн гэр бүлийн хүчирхийллийн талаарх хуулиар хүлээсэн **"мэдээлэх үүргээ"** биелүүлээгүй, Түр хамгаалах байрны журам зөрчиж нэвтэрсэн, Түр хамгаалах байрны зориулалтыг өөрчилсөн, эсхүл өөр зориулалтаар ашигласан тохиолдолд торгох шийтгэл хүлээлгэхээр зохицуулсан.
- **"Эрүүгийн хэрэг, хянан шийдвэрлэх тухай хууль"**-д 2015 оны (ТМЭ, №23, 2017) эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад **гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах, хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх, хязгаарлалт тогтоох** таслан сэргийлэх арга хэмжээний төрөл, журмыг хуульчилж өгсөн.
- **"Бага, дунд боловсролын тухай", "Дээд боловсролын тухай", "Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль"** тогтоомжид хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүүхдийг илрүүлэх, холбогдох байгууллагад мэдээлэх, хуульд заасан үйлчилгээнд хамруулахад дэмжлэг үзүүлэх, зөрчлийг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх, эрсдэлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, харилцааны ур чадвар олгох зэрэг зохицуулалтыг тусгасан байна.
- **"Прокурорын байгууллагын тухай хууль"**-ийн (ТМЭ, №24, 2017) 15.1.11-т гэр бүлийн хүчирхийллийн улмаас хүний амь нас хохирсон гэмт хэрэгт прокурор яллах дүгнэлт үйлдсэн, эсхүл хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн бол дүгнэлт гаргахаар заасан.
- **"Иргэний хэрэг, шүүхээр хянан шийдвэрлэх тухай хууль"**-д (Төрийн мэдээлэл эмхэтгэл, №8, 2002) гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх урьдчилсан арга хэмжээний төрлийг заасан. Шүүгч захирамж гарган насанд хүрээгүй хүүхэд болон хөдөлмөрийн чадваргүй эцэг, эхийг тэжээн тэтгүүлэх, хүүхдийг эцэг, эхийн хэн нэг дээр байлгах, гэрлэгчдийг тусдаа амьдрахыг даалгах, гэрлэгч хэн нэгийг тэжээн тэтгүүлэх, орон сууц болон хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг өмчлөх эрхийг бусдад шилжүүлэх, худалдах, бэлэглэх, захиран зарцуулахыг хориглох, шүүхийн зардлын зохих хувийг урьдчилгаа болгон төлүүлэх, хохирогчид эвлэрүүлэн зуучлалын журмаар эвлэрэх хугацаа заах г.м арга хэмжээ авч болно.
- **"Монгол Улсын Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"**-ийн (ТМЭ, №42, 2019) 7.2-т гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ерөнхий чиглэлийн хүрээнд хүчирхийллийн бүх хэлбэрийг үл тэвчих, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх орчныг бүрдүүлэх /7.2.8/ арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгажээ.
- **"Нийгмийн халамжийн тухай хууль"**-ийн(ТМЭ, №8, 2012) 18-р зүйлийн 18.1.4-т Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний төрөлд хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан

- байрлуулах үйлчилгээ, мөн хуулийн 19-р зүйлийн 19.2.1-д тэжээн тэтгэх үүрэгтэй этгээд нь тухайн ахмад настны эсрэг хүчирхийлэл үйлдсэн болох нь тогтоогдсон бөгөөд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдах боломжгүй ахмад настныг төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулах зохицуулалт тусгагдсан.
- **"Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль"**-д (ТМЭ, №8, 2011) гэр бүлийн харилцаанд хүйсийн шинжээр шууд ялгаварлан гадуурхсан этгээдийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дагуу зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамруулж болно (26.3).
 - **"Гэр бүлийн тухай хууль"**-д (ТМЭ, №30, 1999) Гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл, дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой хохирол учирч болзошгүй, эсхүл учирсан нь тогтоогдсон бол шүүх эвлэрүүлэх арга хэмжээ авахгүйгээр гэрлэлтийг цуцлахаар зохицуулсан. Гэрлэгчид гэрлэлт цуцлах үед хүүхдээ хэний асрамжид үлдээх, түүнийг болон хөдөлмөрийн чадваргүй эхнэр, нөхрөө тэжээн тэтгэх, хамтран өмчлөх дундын эд хөрөнгөө хуваах тухайгаа харилцан тохиролцоогүй бол хүүхдийн нас, эцэг, эхийн халамж, ахуйн нөхцөл, бололцоо, ёс суртахууны байдал, хүчирхийлэл үйлдсэн эсэхийг нь харгалзан хүүхдийг эцэг, эхийн хэн нэгний асрамжид үлдээх, тэтгэлгийн хэмжээг тогтоох, хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг хуваах асуудлыг шүүх шийдвэрлэнэ. Гэрлэлт цуцалснаас гэр бүлийн гишүүнд оногдох дундын эд хөрөнгийн хэсгийг тодорхойлоход гэрлэгчдийн эрүүл мэндийн байдал, хүүхдийн эрх, ашиг сонирхлын үүднээс, түүнчлэн дундын эд хөрөнгөө зүй бусаар ашигласан, нуусан, гэрлэлт цуцалсан нь түүний буруутай үйлдлээс шалтгаалсан нь гэр бүлийн нэг гишүүнд ногдох хөрөнгийг тогтоохдоо харгалзах үндэслэл болно.
 - **"Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль"**-ийн (ТМЭ, №9, 2016) 28.4-т хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, бүх төрлийн дарамт, мөлжлөгт өртөх, гэмт хэргийн хохирогч болох, гэмт хэрэгт татагдан орох зэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хууль сахиулах, хүүхдийн эрхийг хамгаалах, боловсролын болон төрийн эрх бүхий холбогдох байгууллага хэрэгжүүлнэ. Мөн хуулийн 29.1.2-т хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, дарамтанд өртөх, гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үр дүнтэй арга хэмжээ авах ба 29.1.3-т гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, гэмт хэрэгт өртсөн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд үзүүлэх эрүүл мэнд, хууль зүйн, сэтгэл зүйн болон бусад шаардлагатай үйлчилгээг тэдгээрийн сэтгэл зүй, нас бие, сэтгэхүйн онцлогт нийцүүлэн мэргэшлийн түвшинд чанартай үзүүлэх мөн 29.1.4-т гэрч, хохирогчийг хамгаалах байр нь хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог, хэрэгцээ шаардлагад нийцсэн байна.
 - **"Ахмад настны тухай хууль"** (ТМЭ, №13, 2017) "ахмад настны эсрэг хүчирхийлэл" гэж аливаа этгээд ахмад настны эрх, эрх чөлөөг зөрчиж, түүний амь нас, эрүүл мэнд, бие махбод, сэтгэл санаанд гэм хор учруулсан, эсхүл учруулахаар заналхийлсэн үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно. Ахмад настанд үзүүлэх үйлчилгээ гэр бүлийн хүчирхийллээс хамгаалагдах, шаардлагатай тохиолдолд ахмад настныг холбогдох хуульд заасны дагуу хүчирхийллээс хамгаалах үйлчилгээнд хамруулах гэсэн төрөлтэй байхаар хуульчилжээ.
 - **"Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль"** (ТМЭ, №30, 2013) гэмт хэрэг хянан шийдвэрлэх явцад гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, тэднийг мэдээллээр хангах, дэмжлэг, туслалцаа үзүүлэх эрх зүйн үндсийг тогтоохоор бүрдүүлсэн.
 - **"Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"**-д (УИХ, 2010) Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн гэжээ.



Хүн худалдаалах гэмт хэрэг:

- **"Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль" 2012 онд** (ТМЭ, №23, 2017) батлагдсан. Хуулиар ХЗДХЯ, ГХЯ, ХНХЯ, БСШУСЯ болон Цагдаагийн байгууллага, Гадаадын иргэн харьяатын газар, Мэргэжлийн хяналтын байгууллага, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, бүх шатны Засаг дарга, иргэдийн хуралд тусгайлан үүрэг хүлээлгэсэн байна. Түүнчлэн Эрүүл мэндийн яам, хохирогчид эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, хохирогчийг сэтгэцийн нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулах журмыг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжил олгох журмыг, Хууль зүй, дотоод хэргийн яам, хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх журмыг, мөн Улсын ерөнхий прокурортой хамтран хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журмыг, гадаад улсад байгаа хохирогчийг түр хугацаагаар орон байр, хоол хүнсээр хангах, гадаад паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг олгох, эх оронд нь буцаан авчрах журмыг батлан, хэрэгжилтийг ханган ажиллах үүргийг хүлээсэн.
- Шинэчилсэн **"Эрүүгийн хууль"** – ийн (ТМЭ, №7, 2016) 12.3 дугаар зүйлд "Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулан зорчих эрхийг хязгаарлахгүйгээр бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан бол бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэгт тооцох, мөн хуулийн 13.1-д хүн худалдаалах гэмт хэргийг насанд хүрсэн хүний эсрэг үйлдсэн бол 2-8 жилийн хорих ял, хүүхдийн эсрэг үйлдсэн бол 5-12 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан. Мөн хүн худалдаалах гэмт хэргийг үйлдэхийг завдах, хамтран оролцох, зохион байгуулах буюу удирдах үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан төдийгүй хүн худалдаалах гэмт хэргийг үйлдэхээр завдсан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр тусгагджээ.
- **"Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль"** (ТМЭ, №23, 2017) болон **"Гэрч, хохирогчийг хамгаалах хууль тогтоомж"-ид** (ТМЭ, №30, 2013), хохирогчийн аюулгүй байдлыг хангахын тулд гэмт хэргийн холбогдогчид урьдчилан хариуцлагыг сануулах, түүний талаар тодорхой үйлдлийг хязгаарлах, хохирогчийг биечилсэн хамгаалалтад авах, мэдээллийн нууцлалыг хангах, нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, холбооны хэрэгслээр хангах, аюулгүй газарт түр байрлуулах, нүүлгэн шилжүүлэх, баримт бичгийг солих, гадаад төрхийг өөрчлөх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхээр хуульчилсан.
- **"Зар сурталчилгааны тухай хууль"** (ТМЭ, № 23, 2002)-ийн 6 дугаар зүйлийн 6.5 хэсэгт Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчих үйлдэл, үйл ажиллагаанд хүргэж болох эсхүл хүчирхийлэл, садар самуунд уруу татах, түүнчлэн хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд гэм хор учруулах үйлдэл, үйл ажиллагаанд хүргэж болох зар сурталчилгааг хориглосон байна.
- **"Садар самуунтай тэмцэх тухай хууль"** (ТМЭ, №3, 1998)-ийн 1 дүгээр зүйлд "Энэ хуулийн зорилт нь садар самууныг сурталчлах, биеэ үнэлж явалдахтай тэмцэх болон эротик сурталчилгаа, үйлчилгээг журамлахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино." гэж тодорхойлжээ.
- **"Донорын тухай хууль"** (ТМЭ, №6, 2018)-ийн 1-р зүйлд "хүний эрүүл мэндийг хамгаалах, амь насыг нь аврах зорилгоор сайн дураараа цус, эс, эд эрхтнээ үнэ төлбөргүй өгөх, шилжүүлэн суулгах, цусны аюулгүй байдлыг хангах цогц үйл ажиллагаа болон уг үйл ажиллагааны талаарх төрийн, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэний эрх, үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино." гэж тодорхойлжээ.

Ажлын байран дах бэлгийн дарамт:

- Монгол Улсад анх удаа ажлын байран дахь бэлгийн дарамт гэдэг нэр томъёоллыг 2011 онд **"Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль"**-д хуульчилснаар эрх зүйн орчинд эерэг өөрчлөлт гарсан. Хуулийн хэрэгжилтэд голлох үүрэгтэй Жендерийн үндэсний хороо, Хүний эрхийн үндэсний Комиссын эрх, үүргийг тус тус тусгаж өгсөн. Тухайлбал, ХЭҮК ажлын байран дахь бэлгийн дарамттай холбоотой гомдлыг хүлээн авч, хянан шийдвэрлэх үүрэг хүлээсэн бол Жендерийн үндэсний хороо нь төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх юм.
- **"Төрийн албаны тухай хууль"**-ийн 2017 онд (ТМЭ, №1, 2018) шинэчилсэн найруулгыг баталсан. Уг хуулийн 39 дүгээр зүйлд Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаанд хориглох зүйлийг тусгасан ба ...39.1.4-т албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах, бусдыг бэлгийн болон хувийн ашиг сонирхолдоо нийцүүлэн аливаа хэлбэрээр дарамтлах, хавчин гадуурхах, эрхшээлдээ байлгахыг хориглосон. МУ-ын төрийн албыг төрийн, улс төрийн алба, захиргааны алба, тусгай алба, үйлчилгээний алба гэж дөрөв ангилдаг. Төрийн жинхэнэ алба хаагч гэдэгт төрийн захиргааны болон төрийн тусгай алба хаагч хамаардаг. Эндээс үзэхэд тус хуулийн 39-р зүйлд тусгагдсан төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны хориглох зүйлд улс төрийн, үйлчилгээний албыг орхигдуулан зохицуулжээ. Түүнчлэн хуулийн 48-р зүйлд төрийн жинхэнэ албан хаагчдад сахилгын шийтгэл ногдуулахыг тусгасан ба тус хуулийн 37, 39-р зүйлд заасныг зөрчсөн тохиолдолд сахилгын шийтгэл оногдуулах зохицуулалттай.
- **"Зөрчлийн тухай хууль"** (ТМЭ, №24, 2017)-д 2020 оны 1-р сарын 10-д нэмэлт өөрчлөлт оруулах замаар **"бэлгийн дарамт учруулах"**-г зөрчилд тооцохоор хуульчилсан. Хуулийн 6.26-д **"Бэлгийн дарамт учруулах"** гэдэгт бусдад ажил, албан тушаал, нэр төр, алдар хүнд, эд хөрөнгө, сэтгэл санааны үр дагавар үүсгэж бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийх сэдлээ үг хэлээр, биеэр, өөр хэлбэрээр илэрхийлсэн хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох (1 нэгж 1000 төгрөгтэй тэнцэнэ.) эсхүл албадан сургалтад хамруулж 7-30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулах түүнчлэн ажил олгогч хөдөлмөрийн дотоод журамд ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг барагдуулах хэм хэмжээг тусгах үүргээ биелүүлээгүй бол хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор заажээ.

Бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх гэмт хэрэг:

- **"Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль"** (ТМЭ, №21, 2016)-д бие махбодын ба бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн хохирогчид үзүүлэх эрүүл мэндийн болон сэтгэцийн сэргээн засах тусламж, үйлчилгээний зардлыг тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар тооцож төр санхүүжүүлэх болсон бол **"Эрүүл мэндийн тухай хууль"**(ТМЭ, №21, 2011)-д бие махбодийн ба бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн хохирогчид үзүүлэх эрүүл мэндийн болон сэтгэцийн сэргээн засах тусламж, үйлчилгээний төлбөрийг төр хариуцахаар тусгасан нь хохирогчдод ээлтэй зохицуулалт юм.
- **"Хүүхдийн эрхийн тухай хууль"** (ТМЭ, №9, 2016)-ийн 7.1-д хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй гэж заасан.

1.3 ДЭМЖИХГҮЙ БАЙГАА ЗОХИЦУУЛАЛТ:

Гэр бүлийн хүчирхийлэл:

- **“Эрүүгийн хууль”**-ийн 11.7-д заасан **«Байнга»** гэдгийг нотлоход бэрхшээлтэй, мөн гэр бүлийн хүчирхийллийн зөвхөн нэг хэлбэр “зодох” буюу бие махбодид учруулсан хохирлыг авч үзэж байгаа нь хохирогч хамгаалагдахгүй үлдэх, хүчирхийлэл үйлдэгч ял завших нөхцөлийг бүрдүүлж байна.
- **“Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”**-ийг шинэчлэн баталсантай холбогдуулан хуулийн хэрэгжилтийг хангах зардлыг **улсын төсөвт** тусгайлан батлаагүй байна. Энэ нь хохирогчийн аюулгүй байдлыг хангах зорилго бүхий Нэг цэгийн үйлчилгээний төв болон Түр хугацааны хамгаалах байрны тогтвортой үйл ажиллагаа алдагдах эсрдэлд хүргэж байна. Мөн хуулиар үүрэг хүлээсэн цагдаа, эмч, багш, нийгмийн ажилтан зэрэг мэргэжилтнүүдэд зориулсан сургалтыг нэгдсэн хөтөлбөр, агуулгаар, тодорхой давтамжтай явуулахгүй байгаагаас мэргэжилтнүүд гэр бүлийн хүчирхийлэлд үр дүнтэй хариу үйлдэл үзүүлж чадахгүй байна. Орон нутагт цагдаа, мэргэжлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч дутмаг, мэргэжилтнүүд байнга солигдож байгаа нь гэр бүлийн хүчирхийлэлтэй үр дүнтэй тэмцэхэд хүндрэл учруулж байна. Зарим сумдад мэргэжлийн нийгмийн ажилтан огт байхгүй байна.
- Цагдаагийн байгууллагын зарим ажил, үйлчилгээ, хангалтын жишиг норматив хэрэгжихгүй, өнөөдөр цагдаагийн байгууллагад 4585 орон тоо дутуу байна.
- Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хэрэгжилт хангалтгүй байна. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдээд баривчлагдах шийтгэл хүлээсэн этгээдэд зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хариуцахаар заасан боловч орон нутагт сургалт явуулах мэргэжлийн багш, сургалтын анги танхим, хэрэглэгдэхүүн, сургалт явуулах багш нарт олгох зардал шийдэгдээгүй байна.
- Баривчлах шийтгэлийг ямар нэгэн өөр шийтгэлийн сонголтгүйгээр Зөрчлийн тухай хуульд оруулсан нь гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийн тоог бууруулахгүй, эмэгтэйчүүдийг давхар хохироож байна.
- Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаарх асуудал тусгагдаагүй.
- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль нь Эрүүгийн хэрэг үүсгэхээс өмнө хохирогч, гэрч энэ хуулийн хамгаалалт авах боломжгүй байдлаар хуульчилжээ.

Хүн худалдаалах гэмт хэрэг:

- **“Эрүүгийн хууль”**-ийн 13.1-д Бэлгийн мөлжлөг болон хүн худалдаалах гэмт хэргийн гол ялгаатай шинж нь хохирогчийн зорчих эрхийг хязгаарлахгүй байхаар тогтоосон нь оновчтой биш зохицуулалт юм. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн хувьд зорчих эрх нь шууд хязгаарлагдаагүй, чөлөөтэй байгаа мэт боловч айдас, дарамт болон бусад байдлаас шалтгаалан сэтгэл зүйн хувьд гэмт этгээдээс хараат болох, гэмт хэрэгтнүүдийн эрхшээлд орсон байдаг. Энэ нөхцөлд гэмт этгээдээс зугтаах боломжгүй, хууль хяналтын байгууллагад хандах, гомдол гаргах, бусдад мэдэгдэх зэргээр өөрийгөө хамгаалах чадваргүй болсон байдаг. Гэтэл үүнийг зорчих эрх нь хязгаарлагдаагүй гэж үзэх нь учир дутагдалтай юм.
- **“Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль”**-д заасан биечилсэн хамгаалалт, мэдээллийн нууцлалыг хангуулахаас эхлээд нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангуулах, нүүлгэн шилжүүлэх, баримт бичгийг солих, гадаад төрхийг өөрчлөх

зэрэг илүү өндөр зэрэглэлийн хамгаалалтыг хохирогч “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль”-д зааснаар авах боломжгүй болж байна.

- Түүнчлэн **хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нь** эрүүгийн хэрэгт хохирогчоор тогтоогдоогүй бол “Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль”-ийг дагаж батлагдсан Гэрч, хохирогчид эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журам, Гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хангах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам, Гэрч, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журамд заасан хамгаалалт дэмжлэгийг авах боломжгүй болж байна.

Ажлын байран дах бэлгийн дарамт:

- Ажлын байран дахь бэлгийн дарамтад өртсөн хохирогчид туслалцаа үзүүлэх заалт тусгагдаагүй тул АББД-д өртсөн хохирогч хаана хандах, түүнд нийгмийн ажлын үйлчилгээг хэн үзүүлэх, хохирогчийн ажлын байрны баталгааг хэрхэн хангах зэрэг асуудал нь зохицуулалтгүй байгаа нь хүндрэл үүсгэж, нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгцээ бий болсныг харуулж байна.
- “Төрийн албаны тухай хууль”-ийн 6-р зүйлд ...төрийн алба нь улс төрийн, төрийн захиргааны, төрийн тусгай, төрийн үйлчилгээний албатай байх ба мөн хуулийн 6.2-т төрийн захиргааны алба, төрийн тусгай алба нь төрийн жинхэнэ алба хаагч гэж байхаар хуульчилсан нь тус хуулийн 39-р зүйлд заасан сахилгын шийтгэл оногдуулах субъектэд улс төрийн болон төрийн үйлчилгээний алба хаагчид хамаарахгүй байна.

Бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх гэмт хэрэг:

- 2015 оны шинэчилсэн Эрүүгийн хуулиар “18 насанд хүрсэн хүн хохирогчийг 14 насанд хүрсэн 16 насанд хүрээгүй болохыг мэдэх боломжтой байсан, эсхүл мэдсээр байж бэлгийн харьцаанд орсон” тохиолдолд хүлээлгэх торгуулийн хариуцлагыг 5-22 дахин бууруулсан. Хохирогчийг жирэмсэн болгох, бэлгийн замын халдварт өвчин халдаах нь 2002 оны Эрүүгийн хуулиар хүчиндэх гэмт хэргийн хүндрүүлэх шалтгаанд тооцогдож байсан. Гэтэл энэ нь шинэчилсэн хуулиар хасагдсан ба хүүхдийн бэлгийн эрх чөлөөг хамгаалахад ухралт болжээ.
- Бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогч, шүүхээр хэргээ шийдүүлэх явцад хувийн нууцтай байх, хамгаалагдах эрх зөрчигдөж байна. Бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх гэмт хэргийн хохирогчдыг нөхөн сэргээх, үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээ байхгүйгээс бүх байгууллагаар өөрөө явж үйлчилгээ авах болдог нь санхүү, цаг хугацаа, сэтгэл санааны хувьд давхар хохирол учруулж байна. Монгол Улсад мэргэшсэн, туршлагатай мэргэжилтэн дутмаг, мэргэжилтнүүд сэтгэл зүйд үүссэн цочрол, гэмтлийг тогтоох (trauma-informed systems of care) талаар ойлголтгүй байна.
- Бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх гэмт хэргийн хохирогчдод учирсан хор хохирлыг мөнгөн хэлбэрээр тооцох, сэтгэл санааны хохирол болон нөхөн сэргээх зардлыг тооцож олгодоггүйгээс зөвхөн эрүүл мэндийг нөхөн сэргээхэд зарцуулсан баримтад тулгуурлан хохирлыг шүүх тогтоож байна.
- Шинэчилсэн “Эрүүгийн хууль”-ийн 12.2 дугаар зүйлд “бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах” гэмт хэргийн шинжийг оновчтой бус байдлаар заажээ. “Хохирогчийн зөвшөөрлөөр бэлгийн харилцаанд орох үедээ хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, тохуурхан доромжилж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан бол...” гэж заасан нь бусад нөхцөлд бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасныг гэмт хэрэгт тооцохгүй байдлыг үүсгэж байна. Тухайлбал, бэлгийн харилцаанд орохгүйгээр хүнийг айлган сүрдүүлж, хүч хэрэглэхээр заналхийлж эсвэл хуурч мэхлэн бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан бол хэрхэн зүйлчлэх нь тодорхойгүй. Өөрөөр хэлбэл, хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн (үйлдлийн) дунд зай үлдээд зарим бэлгийн хүчирхийллийн шинжтэй үйлдэл хийсэн гэмт хэрэгтэнд ял завших боломж бий болж байна.

1.4 АСУУДАЛ ҮҮСЭХЭД НӨЛӨӨЛЖ БАЙГАА ХҮЧИН ЗҮЙЛС:

Соёл, уламжлал:

- Эрэгтэй, эмэгтэй хүмүүст оноосон жендэрийн хэвшмэл, уламжлалт ойлголт өнөөг хүртэл хүчтэй хэвээр байгааг бидний тоймлосон судалгаа харуулж байна (Жендэрийн үндэсний хороо, 2019; MMCG, 2017; Үндэсний статистикийн хороо, 2018). Үүнээс улбаалан хүчирхийллийг тэвчих, санал нийлэхгүй ч нөхрийнхөө үгийг дагах, нөхөр шийдвэр гаргах ёстой гэсэн хандлага эмэгтэйчүүдийн дунд түгээмэл байна (Жендэрийн үндэсний хороо, 2019; Үндэсний статистикийн хороо, 2018). Түүнчлэн эмэгтэйчүүдийг буруутгах хандлага ахмад насны эрчүүд болон хөдөө орон нутагт амьдардаг эрэгтэйчүүдэд илүү ажиглагдаж байна. Энэ нь тэдгээр эрчүүдийн гэр бүлийн талаарх уламжлалт ойлголт, хандлагатай шууд холбоотой. Жишээ нь жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааны (2018) бүлгийн ярилцлагад оролцсон эрчүүд хаана амьдарч байгаа, хэдэн настайгаас үл хамааран «эр хүн бол гэрийн эзэн ноён нуруу», «дээр үеэсээ уламжлагдаж ирсэн эцгийн эрхт ёс бий» гэх зэрэг нэр томъёог илүү хэрэглэж байжээ.

Бодлогын орчин:

- Хүчирхийлэл үйлдэгчийг баривчлах, торгох зэрэг арга хэмжээ авах нь хохирогчийг хамгаалахаас илүүтэй хохирогчид улам өширхөх, дарамт шахалт учруулах, гол тэжээгч нь саатуулагдсанаар санхүүгийн хүндрэлд орж, байдал улам дордох зэргээр тэднийг давхар хохироож байгаа тул хүчирхийлэл үйлдэгчид оногдуулах хариуцлагыг оновчтой болгох талаар Хүний эрхийн үндэсний комисс 2014 оны илтгэлдээ гаргаж тавьсан ч уг зохицуулалт хэвээр үлдсэн байна. (Хүний эрхийн үндэсний комисс, 2018).
- Бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогч шүүхээр хэргээ шийдвэрлүүлэх явцад хувийн нууцтай байх, хамгаалагдах эрх зөрчигдөж байна. Бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх гэмт хэргийн хохирогчдыг нөхөн сэргээх, үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээ байхгүйгээс бүх байгууллагаар өөрөө явж үйлчилгээ авдаг нь санхүү, цаг хугацаа, сэтгэл санааны хувьд давхар хохирлыг учруулж байна. Монгол Улсад мэргэшсэн, туршлагатай мэргэжилтэн дутмаг, мэргэжилтнүүд сэтгэл зүйд үүссэн цочрол, гэмтлийг тогтоох (trauma-informed systems of care) талаар ойлголтгүй байна. Бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх гэмт хэргийн хохирогчдод учирсан хор хохирлыг мөнгөн хэлбэрээр тооцох, сэтгэл санааны хохирол болон нөхөн сэргээх зардлыг тооцож олгодоггүйгээс шүүхээс хохирлыг зөвхөн эрүүл мэндийг нөхөн сэргээхэд зарцуулсан баримтад тулгуурлан тогтоож байна (Хүйсийн тэгш эрх төв, 2019). Түүнчлэн хүчиндэх гэмт хэрэгт оногдуулах хорих ялын дээд хэмжээг бууруулж, цаазаар авах ялыг халсан нь 2002 оны Эрүүгийн хуулийн ялын бодлогыг зөөлрүүлсэн явдал болжээ (Б.Энхболд, С.Гантулга, & Б.Мөнхзул, 2019).

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙГ ШИЙДВЭРЛЭХТЭЙ ХОЛБООТОЙГООР (2015-2019) МОНГОЛ
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

МУ-ын Засгийн газрын түвшинд хэрэгжүүлсэн үйл ажиллагааг нэгд бодлогын орчныг сайжруулах чиглэлээр, хоёрт төсөв, гуравт жендэрт суурилсан хүчирхийлэлтэй холбоотой хэргийн шийдвэрлэлт, дөрөвт сургалт, тавд судалгаа гэсэн ангиллаар төрийн холбогдох байгууллагуудаас ирүүлсэн мэдээллийг нэгтгэв. Нийт нэр бүхий 11 газарт мэдээлэл хүссэн албан тоотыг хүргүүлсэн ба үүнээс 10 газар хариу ирүүлсэн. Хүний эрхийн үндэсний комисс ямар нэгэн хариу өгөөгүй байна.

Нэрс	Бодлогын орчинг сайжруулах чиглэлээр			Төсөв			Хэргийн шийдвэрлэлт			Сургалт			Судалгаа					
	ГБХ	XX	АББД	ГБХ	XX	АББД	ГБХ	XX	АББД	БХ, ХГХ	ГБХ	XX	АББД	БХ, ХГХ	ГБХ	XX	АББД	БХ, ХГХ
1 ХЗДХЯ, МУ-д ГХУСАЗЗ	✓	✓	✓	✓	✓	✓	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✓	✗	✗	✗
2 ХНХЯ	✓	✓	✗	✓	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✓	✗	✗	✗
3 ЭМЯ	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗
4 БСШУСЯ	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗
5 ШЕЗ	✓	✗	✗	✗	✗	✗	✓	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗
6 УЕПГ	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗
7 ЦЕГ	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗
8 ГБХЗХГ	✓	✗	✗	✗	✗	✗	✓	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✓	✗	✗	✗
9 ХБХЕГ	✓	✗	✗	✓	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗
10 ЖҮХ	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗
11 ХЗҮК	✗	✗	✗	✓	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✓	✗	✗	✗

ГБХ=Гэр бүлийн хүчирхийлэл, XX=Хүн худалдаалах, АББД=Ажлын байран дахь бэлгийн дарамт,

БХ, ХГХ=Бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх гэмт хэрэг

✓ Тийм ✗ Үгүй



БАРИМТЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН:

Жендэрт суурилсан хүчирхийлэл



Суурь шалтгаан

Нийгэм дэх жендэрийн хэвшмэл ойлголт

- Хохирогчийг буруутгах хандлага хэвээр байна
- ЖСХ-ийн асуудлыг чухлаар авч үзэхгүй байна
- Хүчирхийллийг тэвчих, нөхрийн үгийг дагах, нөхөр шийдвэр гаргах ёстой гэсэн хандлага эмэгтэйчүүдийн дунд түгээмэл байна
- Үйлчилгээнд суурилсан төсөв байхгүй
- Хөтөлбөр хэрэгжих тусгайлсан төсөв баталдаггүй
- Хүний нөөцийн хүрэлцээгүй, чадавхи хангалтгүй
- Урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нөхөн сэргээх үйлчилгээг цогцоор нь төлөвлөдөггүй
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлог хэрэгцээнд тохирсон бодлого болон үйлчилгээ дутмаг байна

Бодлогын зохицуулалт хангалтгүй



Суурь шалтгаанаас үүссэн үр дагавар

- ЖСХ-ийн бүртгэгдсэн тохиолдол нэмэгдсэн боловч шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн хэргийн тоо бага байна
- Гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоо хангалтгүй, хохирогчид нөхөн төлбөр тооцох аргачлал байхгүй
- ЖСХ-ыг шийдвэрлэхэд чиглэсэн улсын төсөв хангалттай биш
- Хууль хоорондын уялдаа холбоо сул
- Хохирогчдод үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмж дутмаг хэвээр байна
- Хөгжлийн бэрхшээлтэй, хөдөөгийн хохирогчид хамгаалагдаж чадахгүй байна



Өнөөгийн тулгамдаж буй асуудал

- Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй холбоотой бодлогын бичиг баримтыг хэрэгжүүлэхэд төсөв яагаад хуваарилдаггүй байна вэ? (Яагаад олон улсын санхүүжилтэд найдаж байна вэ?)
- Салбар хоорондын бодлогын хэрэгжилт яагаад уялддаггүй вэ? Үүнийг шийдвэрлэх ямар боломж, гарц байна вэ?
- Урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нөхөн сэргээх хөтөлбөр, үйлчилгээг цогцоор нь төлөвлөж чадахгүй байгаагийн шалтгаан юу вэ? Ямар арга замаар өөрчлөлтийг хийх боломжтой вэ?



Цаашид гүнзгийрүүлэн судлах асуултууд



2

ЧАНАРЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Баримтын судалгааны үр дүнд үндэслэн чанарын судалгааг дараах асуудлуудыг тодорхойлох зорилгоор хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн орчин, хууль тогтоомжийн уялдаа, хийдэл,
- Жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөн хохирогч хамгааллын өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал
- Хэргийн шийдвэрлэлт, хууль тогтоомжийн хэрэгжилт, цаашид анхаарах асуудлууд.

Судалгаанд шүүх эрх мэдэл болон хууль сахиулах байгууллага, төрийн бус байгууллагын төлөөлөл болох нийт 19 экспертээс ганцаарчилсан ярилцлага авсан.

Эрх зүйн орчин:

- 2013 онд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль батлагдаад 2014 онд Тахарын ерөнхий газрыг байгуулсан. 2016 онд Тахарын ерөнхий газрыг татан буулгаж чиг үүргийг хууль сахиулах байгууллагад шилжүүлсэн. Гэрч, хохирогчдод сэтгэл зүйн хамгаалалт хийх арга хэмжээний талаарх зохицуулалт хангалтгүй байна. Мөн хамгаалалтад авсан гэрч, хохирогчдын нийгмийн хамгааллын асуудлыг зохицуулахад тусгайлсан төсөв, хөрөнгө байдаггүй. Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс нь хамгаалах үүрэг гүйцэтгэдэг. Хянан шалгах ажиллагаа хийдэггүй. Цагдаагийн байгууллагад чиг үүрэг шилжсэнээс хойш гэрч, хохирогчийг хамгаалах хүний тоо өссөн. 2016 онд 40, 2017 онд 51, 2019 онд 130 гэрч, хохирогчийг хамгаалжээ.
- 2015 оны Шинэчилсэн Эрүүгийн хуульд 2020 оны 01-р сарын нэмэлт, өөрчлөлтөөр хуулийн 12.6-р зүйл буюу “Биеэ үнэлэхийг зохион байгуулах” үйлдлийг гэмт хэрэгт тооцсон. Энэ нь бусдыг биеэ үнэлэхэд зуучилсан, татан оролцуулсан бол зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заажээ. Түүнчлэн, биеэ үнэлэх газар байгуулсан, санхүүжүүлсэн, биеэ үнэлэхийг зохион байгуулсан, биеэ үнэлэхэд нь тээврийн хэрэгсэл, орон байр, бусад зүйлээр хангасан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэхээр хуульчилсан. “Зөрчлийн тухай” хуулийн 6.18-ийн 4-т биеэ үнэлэн, бусадтай бэлгийн харьцаанд орсон эсхүл бусдын биеийг үнэлүүлэн бэлгийн харьцаанд оруулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох эрх зүйн зохицуулалтыг тусгасан байна.
- Шинэчилсэн “Эрүүгийн хууль”-ийн зарим зүйл заалтыг нэгтгэх шаардлагатай. Тухайлбал, ЭХ-ийн 13.1 буюу “Хүн худалдаалах”, мөн хуулийн 12.3 буюу “Бэлгийн мөлжлөг” гэсэн зохицуулалтыг нэгтгэх. Учир нь бэлгийн мөлжлөг бол хүн худалдаалах гэмт хэргийн нэг төрөл болдог. Гэтэл зөвхөн зорчих эрхийг хязгаарлах гэсэн нэг л үгийн зөрүүтэй хуулийн зүйл анги юм. Хүний наймааны хохирогчийг бусдын нөлөөнд автахгүй байлгах, хэргийг эцэслэн шийдвэрлэлт тусад нь нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулах нь хамгийн чухал бөгөөд тулгамдсан асуудал болоод байна.
- Хохирогчдод нөхөн төлбөр олгох асуудлыг шийдвэрлэх нь чухал ба “Хүн худалдаалахтай тэмцэх тухай” хуулийн 15-р зүйл болох Хохирол нөхөн төлүүлэх заалтыг бүрэн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

- Бэлгийн халдашгүй байдлыг хангахтай холбоотой эрх зүйн орчинг сайжруулах, ялангуяа энэ төрлийн гэмт хэргийн холбогдогч нарт оногдуулж буй ялын бодлогыг эргэн харж сайжруулах хэрэгтэй. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн үржихүйн эрхэд маш ноцтой халдаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэд энэ төрлийн гэмт хэрэгт өртөх эрсдэл өндөр байна.

Хохирогч хамгаалал, туслалцаа, дэмжлэг:

- Хохирогч хамгаалалын асуудлаарх зохицуулалт хангалтгүй байна. Ажлын байран дахь бэлгийн дарамтад өртсөн хохирогч хаана, ямар байгууллагад эрхээ хамгаалуулах, нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдах асуудал өнөөг хүртэл байхгүй байна.
- Ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг олон нийтэд сурталчлан таниулах чухал шаардлагатай байна.
- Улс төрийн өндөр албан тушаалтан энэ төрлийн гэмт хэргийг ихэвчлэн үйлддэг. Мөн ял завших, хохирогчийг хэргээсээ татгалзах бүхий л нөхцөлийг бүрдүүлж байдаг. Тэдэнд хамгаалалт байдаггүй. Тууштай дэмжих, туслах байгууллага байдаггүй.
- Сэтгэл зүйн үйлчилгээг хөгжүүлэх, мэргэшсэн ажилтан, мэргэжилтнүүдийг нэмэгдүүлэх.

Хэргийн шийдвэрлэлт, хүний нөөц:

- Хүн худалдаалах гэмт хэргийн бэлгийн мөлжлөгийг илрүүлж байгаа боловч, бусад төрөл болох “хөдөлмөрийн мөлжлөг”, “цус эд эрхтний” талаарх зөрчил, гэмт хэргийг илрүүлэхгүй байна. Гэмт хэрэг илрүүлэх ажиллагаа зөвхөн Улаанбаатар хотоор хязгаарлагдаж байна. Тиймээс энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх нэгжийг нэмэгдүүлэх, үндэсний хэмжээнд ажиллах бүтцийг бий болгох;
- Хүний наймаатай холбоотой гэмт хэргийн мөрдөн шалгах тусгай тасаг бий болгох эсхүл мөрдөгчийн тоог нэмэгдүүлэх, улмаар тэднийг мэргэшүүлэх ажлыг эрчимжүүлэх хэрэгтэй байна;
- Бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх гэмт хэргийн хохирогч болсон ялангуяа охидод нэг хаалгаар үйлчилгээ үзүүлдэг цогц үйлчилгээг бий болгох;
- Мэргэжлийн сэтгэл засалчдыг бэлтгэх: сэтгэцийн гэмтэлд суурилсан үйлчилгээ тогтолцоо бий болгох шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ

- **Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх тухай эрх зүй орчин, хууль тогтоомжийн зохицуулалт уялдаагүй, хийдэлтэй хэвээр байна.** Тухайлбал, Эрүүгийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүн худалдаалахтай тэмцэх, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд тусгагдсан хохирогчийг тодорхойлсон ойлголт зөрүүтэй байна. Хууль тогтоомжийн хэрэглээ, ойлголтын талаарх нэгдсэн ойлголтгүйн улмаас гэр бүлийн хүчирхийллийн хэрэг, зөрчил, хүн худалдаалах болон бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх гэмт хэргийг шийдвэрлэхэд хэрэг бүрийн онцлогийг нарийн томъёолсон зарим заалтыг хууль, шүүхийн практикт хэрхэн хэрэглэх талаарх тайлбар гаргах хэрэгцээ бий болжээ.
- **Хохирогч хамгаалал, хэргийн шийдвэрлэлт хангалтгүй хэвээр байна.** “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль”-д гэмт хэрэг хянан шийдвэрлэх явцад, гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, тэднийг мэдээллээр хангах, дэмжлэг, туслалцаа үзүүлэхээр хязгаарласан учир эрүүгийн хэрэг үүсгэхээс өмнөх хохирогч болон гэрч энэ хуулийн хамгаалалтыг авах боломжгүй байхаар зохицуулалтыг тусгаж өгсөн байна. 2017 онд шүүхээр хүн худалдаалах гэмт хэргийн шийдвэрлэлт огт байсангүй. Мөн ажлын байран дахь бэлгийн дарамтад өртсөн хохирогчид туслалцаа үзүүлэх заалт тусгагдаагүй тул АББД-д өртсөн хохирогч хаана хандах, түүнд нийгмийн ажлын үйлчилгээг хэн үзүүлэх, хохирогчийн ажлын байрны баталгааг хэрхэн хангах зэрэг асуудал нь зохицуулалтгүй орхигдсон нь хүндрэл үүсгэж, нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгцээ бий болсныг харуулж байна. Тусгай хэрэгцээт иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээ дутмаг, одоогоор үзүүлж буй үйлчилгээ нь хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд ялангуяа сонсголын бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд дохионы орчуулагч, тулгуур болон тэргэнцэртэй эмэгтэйчүүдэд орох, гарах гарц, харааны бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд хөтөч гэх мэт зайлшгүй хэрэгцээт зүйл байнга дутагдаж байна.
- **Хууль, хуулийг даган гарч буй журам, үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг улсын төсөвт тусгайлан тусгахгүй байна.** Үүнд, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-ийг хэрэгжүүлэх төсөв байхгүй ба зөвхөн олон улсын байгууллагын хандив тусламжийн хүрээнд зохицуулж байна. Тусгайлсан төсөвгүй бол, тухайн төслийн хүрээнд хийсэн үйл ажиллагаа бүгд нэг удаагийн шинжтэй, тогтвортой биш, төсөл дуусахаар хохирогчдод үзүүлэх үйлчилгээ тасрахад хүрэх эрсдэлийг дагуулж байна.
- **Салбар дундын зохицуулалт, уялдаа холбоо сул байна.** Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хүрээнд Үндэсний хөтөлбөр гаргах ба энэ нь одоо хүртэл батлагдан гараагүй байна. Хуулиар үүрэг хүлээсэн салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа сул, хангалтгүй байна. Ялангуяа хохирогчийг нөхөн сэргээх, сэтгэл заслын үйлчилгээнд хамруулах үйлчилгээ, түүний журмын хэрэгжилт хангалтгүй байна.
- **Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил, гэмт хэрэг, хүн худалдаалах гэмт хэргийн бүртгэл, шийдвэрлэлтийн талаарх мэдээллийн нэгдсэн сан байхгүй байна.** Гэр бүлийн хүчирхийллийн хэрэг, зөрчлийг хэрхэн шийдвэрлэсэн талаар цагдаа, прокурор, шүүхээс мэдээлэл гаргах, мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдэхгүй байгаагаас статистик мэдээллийг бүхлээр нь харах боломжгүй байна.
- **Хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын алба хаагчдыг мэргэшүүлэх сургалтыг тогтмолжуулах шаардлагатай байна.** Сургалтаар дамжуулан хэвшмэл ойлголтыг халах, хохирогчийг буруутгах хандлагыг өөрчлөх. Хуулийн байгууллагын бүхий л үе шатанд хохирогчийг буруутгах үзэл хандлага бат оршсоор байна. Өнөөгийн байдлаар олон улсын байгууллагын дэмжлэгээр нэг удаагийн шинж чанартай, сургалт зохион байгуулагдаж байна. Сургалтын үйл ажиллагаа тогтмолжиж чадахгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Бодлогын орчинг сайжруулах чиглэлээр:

1. Салбар дундын зохицуулалтыг сайжруулах: хүн худалдаалахтай тэмцэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх “Дэд зөвлөл”-ийн үйл ажиллагааг өргөтгөж, байнгын үйл ажиллагаатай бүтцийг бий болгох, салбар дундын зохицуулалтыг хангах зорилгоор үйл ажиллагааг нь эрчимжүүлэх;
2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай үндэсний хөтөлбөрийг боловсруулах, тусгай төсвийг улсаас гаргуулах;
3. Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил, гэмт хэрэг, хүн худалдаалах гэмт хэргийн бүртгэл, шийдвэрлэлтийн талаарх мэдээллийн нэгдсэн санг бий болгох;
4. “Монгол Улсын Эрүүгийн хууль”, “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль”, “Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль”-д тусгагдсан хохирогч гэдэг ойлголт, тодорхойлолтыг нэг мөр болгох;
5. Хохирогчийг илрүүлэх нэгдсэн тогтолцоо, механизм бий болгох;
6. Гэмт хэрэгтнүүдэд оногдуулж буй ял шийтгэлийг оновчтой, ял завшихгүй байхад анхаарах;
7. Ажлын байран дахь бэлгийн дарамтад өртсөн хохирогчид туслалцаа үзүүлэх зохицуулалт байхгүй тул АББД-д өртсөн хохирогч хаана хандах, түүнд нийгмийн ажлын үйлчилгээг хэн, хэрхэн үзүүлэх, хохирогчийн ажлын байрны баталгааг хангах талаарх зохицуулалтыг бий болгох, бүрдүүлэх;
8. Хохирогчид нөхөн олговор олгох асуудлаар МУ-д хэрэгжиж буй хуулиудад үнэлгээ хийн, хуулийн хийдэл, давхардлыг илрүүлэх, хохирогчид учирсан нөхөн төлбөр олгох нөхцөлийг тусгасан нэмэлт, өөрчлөлтийг эрүүгийн болон иргэний хууль тогтоомжид оруулах;
9. 2015 оны Эрүүгийн хуулийн зарим зүйл заалтыг нэгтгэх шаардлагатай байна. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 12.3 буюу Бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийг мөн хуулийн 13.1. буюу хүн худалдаалах гэмт хэрэгтэй нэгтгэх;
10. Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тасгийн үйл ажиллагаа, мөн бүтцийг өргөжүүлэх, дагнасан мөрдөн шалгах албыг бий болгох.

Хохирогч хамгаалал, үйлчилгээг сайжруулах чиглэлээр:

1. Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчдод шууд туслалцаа үзүүлэх, нөхөн сэргээх үйлчилгээний тогтолцоог бий болгох, үйлчилгээтэй холбоотой гарах санхүүжилтийг жил бүрийн улсын төсөвт тусгаж байх;
2. Мөн тусгай хэрэгцээтэй иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээ дутмаг, одоогийн үйлчилгээ нь тэдний хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд ялангуяа сонсголын бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд дохионы орчуулагч, тулгуур болон тэргэнцэртэй эмэгтэйчүүдэд орох гарах гарц, харааны бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд хөтчийг бий болгох.
3. Охид, эмэгтэйчүүдийн бэлгийн халдашгүй байдлыг хангах, хамгаалах, тэдэнд үзүүлэх үйлчилгээ, тусламжийг нэг цэгийн үйлчилгээний хэлбэрт шилжүүлэх, эмнэлгийн үйлчилгээ, шүүх шинжилгээний хүрээлэн, байцаалт өгөх, сэтгэл зүйн үйлчилгээ, хууль зүйн туслалцаа үзүүлэх зэрэг бүхий л үйлчилгээг нэг газраас цогцоор нь авах боломжийг бүрдүүлэх;
4. Ажлын байран дахь бэлгийн дарамтад өртсөн хохирогчид туслалцаа үзүүлэх зохицуулалт байхгүй тул АББД-д өртсөн хохирогч хаана хандах, түүнд нийгмийн ажлын үйлчилгээг хэн, хэрхэн үзүүлэх, хохирогчийн ажлын байрны баталгааг хангах талаарх зохицуулалтыг бий болгох, бүрдүүлэх;

Урьдчилан сэргийлэх чиглэлээр:

1. Жендэрт суурилсан хүчирхийллийн асуудалд цогц хандаж, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, нөхөн сэргээх үйлчилгээний аль нэгийг нь орхигдуулахгүй байх;
2. Хөдөлмөрийн мөлжлөг, хилээр гарч буй жирэмсэн эмэгтэйчүүдэд хяналт тавих, уул уурхай дагасан бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийг илрүүлэхэд анхаарал хандуулах;
3. Бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирсон тохиолдолд сэтгэл санааны давхар дарамтад оруулахаас сэргийлэх үүднээс түүнтэй ажиллах арга, тусламж, үйлчилгээний зөв дараалал, жендерийн тэгш байдал, ялгаварлан гадуурхалт, хохирогчийн эрх, хүчирхийллийн шинж тэмдгийг таних зэрэг асуудлаар эмч, багш зэрэг мэргэжилтнүүдэд зориулсан сургалтын модуль боловсруулж, тасралтгүй зохион байгуулах;
4. Шүүх эрх мэдлийн болон прокурор, хууль сахиулах байгууллагын алба хаагчдыг тогтмол мэргэшүүлэн сургах сургалтын тогтолцоог бий болгох;



**ХОЁРДУГААР БҮЛЭГ:
ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИН ДЭХ
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦОО**

ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

- УИХ-д нэр дэвших эмэгтэйчүүдийн тоо 2005 оноос харьцангуй нэмэгдэж, улс төрийн намуудаас нийт эмэгтэй нэр дэвшигчдийн тоо 32%- д хүрч байна. Эмэгтэй гишүүн 1992 оноос эхлэн гурав байснаа 13 болж нэмэгдсэн. Гэсэн ч улс төр, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог 30% болгох Мянганы хөгжлийн зорилго 2015 онд хангаж чадаагүй. УИХ-д сонгогдсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь 2016 онд 17.1% болсон нь түүхэндээ хамгийн өндөр үзүүлэлтэд хүрсэн ч энэ нь дэлхийн дунджаас (2017 онд 23.7%) болон Зүүн Ази, Номхон далайн бүсийн дунджаас (2017 онд 19.7%) доогуур байна. Жендэрийн зөрүүтэй байдлын тайланд /2017 он/ улс төрийн эрх мэдлийн үзүүлэлтээр Монгол Улс 144 орноос 107-д эрэмбэлэгдсэн байна. Төрийн захиргааны шийдвэр гаргах түвшинд ажиллагсдын дунд эмэгтэйчүүд 2005 онд 33.7% байсан байна. Энэ үзүүлэлт 2015 онд бүтэц, орон тооны цомхотголын нөлөөгөөр 25.2% болсон боловч 2016 оны сонгуулийн дараа эргэн өсч, 2017 оны байдлаар 34.3% болсон байна. Төрийн захиргааны тэргүүн түшмэлд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 2012 оноос хойш аажим нэмэгдэж 2017 оны байдлаар 24% болжээ. Төрийн захиргааны эрхэлсэн түшмэлийн түвшинд ажиллаж буй эмэгтэйчүүдийн эзлэх хувь 2012 онд 28.9% байсан бол Засгийн газрын бүтэц, орон тооны өөрчлөлтийн дараа 2016 онд 25.8% болж буурсан байна. Харин 2016 оноос хойш эмэгтэйчүүдийн эзлэх хувь нэмэгдсээр 2019 онд “эрхэлсэн түшмэлийн” түвшинд ажиллагсдын 38.7% байна (Жендэрийн үндэсний хороо, 2019).
- Транспэрэнси Интернэшнл байгууллагаас жил бүр гаргадаг дэлхийн улс орнуудын авлигын төсөөллийн индексээр Монгол Улс 2015 онд 39 оноогоор 72-т, 2016 онд 38 оноогоор 87-д, 2017 онд 36 оноогоор 103 дугаарт жагссанаас харахад Монгол Улсад авлигын нөхцөл байдал улам дордож 3 жилийн хугацаанд 31 байраар ухарсан байна. Дэлхийн эдийн засгийн форумаас гаргасан “Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан”-д 2017-2018 онд Монгол Улс 137 орноос 101-д, үүний дотор институцийн чанараар 108-д, улс төрчдөд итгэх олон нийтийн итгэлийн үзүүлэлтээр 125-д жагсжээ. Эндээс харахад МУ-ын өрсөлдөх чадварт институцийн чанар, түүний дотор улс төрчдийн итгэл даах чадвар хамгийн муу үнэлгээ авсан байна (Шилэн нам авлигын эсрэг түншлэл, 2018).
- 2016 оны аймаг, сум, нийслэл, дүүргийн сонгуулийн үр дүнд сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдийн 26.7%, тэргүүлэгчдийн 27.8%, хурлын даргын 13.8% - д эмэгтэйчүүд сонгогджээ. Харин аймаг, нийслэлийн дарга болон ИТХ-ын даргаар ажилласан нэг ч эмэгтэй байхгүй байна (Жендэрийн үндэсний хороо, 2019).
- Бидний тоймлосон судалгааны материалуудад эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй, бэлгийн цөөнх эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог судалж үзээгүй байна.

Жендэрийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, сайжруулах үндэсний тогтолцооны хувьд:

- Улсын Их Хурлаас 2011 онд “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль” батлагдсанаар Жендэрийн Үндэсний хороо байгуулагдаж, орон нутгийн түвшинд жендэрийн тэгш байдлын асуудлаарх салбар хороо, зөвлөлийн тоо хоёр дахин нэмэгдсэн. Энэ нь нийслэл, 21 аймаг, 9 дүүрэгт салбар хороо, 13 төрийн захиргааны төв байгууллагуудад салбар зөвлөл ажиллаж байна.
- Үндэсний хэмжээнд 2015 оноос эхлэн анх удаа жендэрийн сургагч багш нарыг бэлтгэж, Жендэрийн үндэсний хорооны дэргэд жендэрийн асуудлаар мэргэшсэн Жендэрийн шинжээчдийн бүлэг, хэвлэл мэдээллийн зөвлөл, Жендэр консорциум тус тус байгуулагдан ажиллаж байна.
- Эмэгтэйчүүдийн эрхийн хэрэгжилтийг хянах төрийн бие даасан агентлаг байхгүй ч Ерөнхий сайдын

ахалдаг Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний Хороо яамд, ТББ болон аймаг, орон нутгийн жендэрийн салбар хороо, зөвлөлийн түвшинд эмэгтэйчүүдтэй холбоотой бодлогыг зохицуулж, тэдний эрх ашгийг хамгаалахын төлөө ажиллах үүрэг хариуцлага хүлээж байна.

БОДЛОГЫН ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ: ДЭМЖИЖ БҮЙ ЗОХИЦУУЛАЛТ

- **"Монгол Улсын Үндсэн хууль"**-д 1992 он (ТМЭ, №1, 1992) улс төрийн эрх, эрх чөлөөнд шууд буюу төлөөлөгчийн байгууллагаараа уламжлан төрийн удирдах үйл хэрэгт оролцох, төрийн байгууллагад сонгох, сонгогдох, улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрх, төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх, тайван замаар жагсаал цуглаан хийх эрхийг хуульчилсан.
- **"Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль"**-ийг (ТМЭ, №8, 2011) баталсан. Тус хуулийн 10-р зүйлийн 10.1.1-т томилогдох төрийн улс төрийн албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл Засгийн газар, аймаг, нийслэлд 15%-иас, дүүрэгт 20%- иас, суманд 25%-иас, хороонд 30%-иас доошгүй байна гэсэн нь эмэгтэйчүүдийн тоог шийдвэр гаргах түвшинд нэмэгдүүлэх түр тусгай арга хэмжээ авах квотын хувь хэмжээг баталгаажуулж өгсөн.
- **"Улс төрийн намын тухай хууль"**-д (ТМЭ, №7, 2005) эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийг хангах чиглэлээр төдийлөн ахицтай зүйл байхгүй хэдий ч тус хуулийн 5.1.3-т гишүүддээ намын удирдах байгууллагын төлөөлөлд орох, сонгуульд нэр дэвших, сонгогдоход үндэс, угсаа, арьсны өнгө, нас, хүйс, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаалаар ялгаварлахгүйгээр адил тэгш боломж олгох мөн хуулийн 11.2.8 –т сонгуульд нэр дэвшүүлэх, боловсон хүчнийг шилж сонгох, хүйсийн тэгш байдлыг хангах зарчим баримтлахыг хуульчилжээ.
- **"Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль"** (ТМЭ, №49, 2019) –ийг баталж улмаар тус хуулийн 30.2-т...нам, эвслээс нэр дэвшиж байгаа нийт нэр дэвшигчийн 20-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байна гэжээ.
- **"Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль"** (МУИХ, 2020) батлагдсан ба мөн хуулийн 29.2-т Нам, эвслээс нэр дэвшиж байгаа нэр дэвшигчийн 20-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийн нэр дэвшигч байна гэж хуульчилсан.
- **"Төрийн албаны тухай хууль"** (ТМЭ, №1, 2018)-ийн 31.4-т төрийн тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангасан иргэний төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх эрхийг үндэс, угсаа, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, нам, олон нийтийн бусад байгууллагын харьяалаар ялгаварлаж үл болно.
- **"Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хууль"** (МУИХ, 2020)-ийн 12.9-т Комиссын гишүүнийг томилохдоо жендэрийн тэгш байдлыг харгалзан үзэх бөгөөд 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийн төлөөлөл байхаар тусгасан.
- **"Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль"** (ТМЭ, №9, 2016)-д **"хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлан гадуурхах"** гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын харилцаанд иргэний үндсэн эрх, эрх чөлөөг бусадтай адил тэгш эдлэх, нийгмийн баялгаас тэгш хүртэх, хөгжилд хувь нэмрээ оруулах, тохирох хэрэглэгдэхүүнээр хангагдах боломжийг үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхгүйг ойлгоно гэжээ. Мөн хуулийн 4.1.11-т **"бие даан амьдрах эрх"** гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн **өөртэй нь холбоотой аливаа асуудлаар бие даан шийдвэр гаргах, сонголт хийх, оролцох боломжийг олгох,** хуулийн 6.3-т хөгжлийн бэрхшээлтэй хүний таатай, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, **шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох, улс төрийн эрхээ эдэлнэ.** Түүнчлэн 6.3.6.төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаанд оролцуулахаас татгалзах, зайлсхийх, сонгох, сонгогдох эрхээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэхгүй байх.

- “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” (МУИХ, 19-р тогтоол, 2016) хөтөлбөрийг баталж “нийгмийн хөгжил дэвшилд жендэрийн тэгш оролцоог хангах замаар нийгмийн баялгийн үр шимээс адил тэгш хүртэх таатай орчинг бүрдүүлэх” гэж заасан байна.
- “Засгийн газрын 2016–2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр” (МУИХ, 45-р тогтоол, 2016)-т “жендэрийн тэгш байдлыг хангаж, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ” гэж төрийн бодлого, хууль тогтоомжийг жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн байна.

ДЭМЖИХГҮЙ БАЙГАА ЗОХИЦУУЛАЛТ:

- Сонгуулийн тухай хуулийн 30-р зүйлийн 30.4-т ...намаас нэр дэвшүүлэх асуудлыг тухайн намын Их хурал, эсхүл төлөөллийн төв байгууллага хуралдаанаараа хэлэлцэж, **нууцаар санал хурааж**, олонхийн саналаар шийдвэрлэхээр тусгасан.
- МУИХ-ын Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа эмэгтэйчүүдийн нэр дэвших төлөөллийн квотыг 30 хувь болгохыг дэмжих хүсэл эрмэлзэл байхгүй байна.

АСУУДАЛ ҮҮСЭХЭД НӨЛӨӨЛЖ БАЙГАА ХҮЧИН ЗҮЙЛС:

Соёл, уламжлал:

- Бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл ажиллагаа нь эрэгтэй хүнд хамаатай гэсэн тогтсон уламжлалт хандлага оршоор байна. Жишээ нь, эмэгтэйчүүдийн улс төр дэх оролцоонд тулгардаг бэрхшээлийг судалсан судалгаанд эрэгтэйчүүд илүү шийдвэр гаргадаг, ноён нуруутай, асуудалд илүү нухацтай ханддаг гэсэн ойлголт хандлага хэвээрээ байна. Мөн гэр бүлийн дотор өрхийн тэргүүн, нөхөрт хоол цайны дээжийг түрүүлж аягалах, гэрийн хойморт суулгах, эсвэл хурал цуглааныг эрэгтэйчүүд эхлүүлэх, удирдах ёстой гэсэн тогтсон хуучинсаг хандлага хэвээр байгаа нь эрэгтэйчүүдийг гол шийдвэр гаргагчид гэсэн статус, соёлын хэм хэмжээг улам бататгаж, энэ нь улс төрийн орчинд ч нөлөөлж байна. Улс төрийн намын удирдах албан тушаалыг дийлэнхдээ намын эрэгтэй гишүүд, харин захиргааны, орлогч даргын албыг эмэгтэй гишүүд хашиж байгаагаас нийгэмд эрэгтэйчүүдийн удирдах буюу улс төрд манлайлах чадвар нь илүү гэж үзэх үзэл давамгайлж байна гэжээ. Түүнчлэн эмэгтэйчүүд ар гэрийн ажлыг зохицуулахад илүү үүрэгтэй байдаг ба энэ нь улс төрд идэвхтэй оролцох боломжийг хязгаарлаж байгааг тус судалгаанд дурджээ. Ялангуяа хөдөө, орон нутагт энэ байдал хэвийн үзэгдэл мэт ажиглагдаж байна. Соёлын хувьд, энэхүү эрчүүдийг дээдлэх уламжлалт хандлага нь эмэгтэйчүүдийн өөртөө итгэх итгэлийг бууруулж, сонгуульд өрсөлдөхөд бэлэн эсэхдээ эргэлзэхэд хүргэдгийг тус судалгаанд оролцогчид мөн хэлжээ. (International Republican Institute, 2016). Мөн сонгууль угтан хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд цацагддаг хэлэлцүүлэг мэтгэлцэн зэрэг нэвтрүүлэгт бүх нэр дэвшигчдийг оролцуулах ёстой. Гэсэн ч тухайн ХМХ-ийн нэвтрүүлгийн хөтөлгөч, зохион байгуулагчид нь нэвтрүүлэгт оролцож буй нэр дэвшигч бүрт боломжийг ижил тэгш бий болгодоггүй тул эрэгтэй нэр дэвшигч голлон ярьсаар байгаад цаг дуусдаг гэдгийг тус судалгаанд оролцогчид хэлсэн байна. Мөн эрэгтэй нэр дэвшигчид танил тал ихтэй, хэвлэл мэдээллээр гарах давтамж нь их, үнэ төлбөрийн хувьд тохиролцоо хийх боломжтой байдаг гэжээ (х.17).

Бодлогын орчин:

- Сонгууль болон холбогдох хуулийн зүйл заалтыг зөрчсөн тохиолдолд ямар хариуцлага оноох нь тодорхой бус, эмэгтэйчүүдийг дэмжих бодлогын зохицуулалт байхгүй, мөн бодлогын хэрэгжилтэд тавих хяналт сул байгаагаас эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого үр дүнтэй хэрэгжихгүй байна. Жишээ нь: “Сонгуулийн тухай хууль”-д 2016 оны 5 дугаар сарын 5-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулж Нам, эвслээс нэр дэвшигчийн 20-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийн нэр дэвшигч байна гэж заасан. Нам, эвслээс нэр дэвшигч эмэгтэйчүүдийн квотыг олон улсын тэргүүн туршлагад тулгуурлан 30 хувиар тогтоосон боловч нэр дэвших эмэгтэйчүүд хангалттай бус гэсэн шалтгаанаар 2012, 2016 онд сонгуулийн өмнө өөрчилж 20% болгосон. Кампанит ажил явуулах

хуулиар олгогдсон эрхийн хүрээнд эмэгтэйчүүдэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарахад ямар нэгэн хориг байхгүй ч нөгөө талаар ямар нэгэн давуу эрх олгогддоггүй байна. (International Republican Institute, 2016). Монгол Улсад улс төрийн намын санхүүжилтийн эрх зүйн орчинг судалсан судалгаанд нэр дэвшигчдийн намдаа өгдөг дэнчингийн мөнгө хуулиар тогтоосон хандивын хязгаарыг хэд дахин давснаар хууль тогтоомжийн үр нөлөөг үгүйсгэн хийдэл үүсгэж байгааг гаргасан байна. Улс төрийн дэнчингийн хандив мөнгө нь ийм өндөр байгаа нь эдийн засгийн боломж, танил талын сүлжээ дутмаг байдаг эмэгтэйчүүд, залуучуудын хувьд улс төрд оролцоход нэн их саад бэрхшээл болдог. Төрөөс олгож буй санхүүжилтэд намын залуу болон эмэгтэй гишүүдийн шийдвэр гаргах түвшинд, сонгуульд оролцох оролцоог дэмжихэд зарцуулах тухай заагаагүйг онцолсны зэрэгцээ одоогийн тогтолцоонд эрх зүйн талаас дутагдалтай зүйлс их, хяналтын чиг үүрэг бүхий байгууллагууд нь хамрах хүрээ, эрх үүргийн хувьд хязгаарлагдмал байна гэж үзжээ (Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн; Нээлттэй нийгэм форум, 2018).

Улс төрийн намын дотоод зохион байгуулалт:

- Улс төрийн намууд жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр бодитой алхам хийхгүй байна. Жишээ нь сүүлийн хэдэн удаагийн сонгуулиас харахад намууд жендэрийн квотыг зөрчөөгүй боловч эмэгтэй нэр дэвшигчийг, сонгогдох магадлал багатай тойрогт өрсөлдүүлдэг нь бодит байдалд жендэрийн тэгш байдлыг хангах улс төрийн хүсэл зориг дутаж буйн илрэл болсон гэж судлаачид үзжээ. (Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн; Нээлттэй нийгэм форум, 2018, х.16). Сонгуульд нэр дэвшиж байсан эмэгтэйчүүд ч мөн ижил байр суурьтай байна. Жишээ нь, улс төрд эмэгтэйчүүдийн оролцоог судалсан судалгаанд оролцогчид намууд цаанаасаа бодлогоор хүчтэй эмэгтэй нэр дэвшигчдийг нэг тойрогт хуваарилж хооронд нь өрсөлдүүлэх хандлага ажиглагддаг тухай ярьсан байна. Жишээ нь, хоёр эмэгтэй нэр дэвшигчийн нэг нь л сонгогдох тул тэдэнд өгөх санал хуваагдаж, эрэгтэй нэр дэвшигч сонгогдох магадлал нэмэгдэж, харин хоёр хүчтэй эмэгтэй нэр дэвшигч ялагдах нөхцөлийг бий болгодог байна. Мөн намууд эмэгтэй нэр дэвшигчдээ сонгогдох ямар ч боломжгүй тойрогт хуульд заасан квотыг л биелүүлэх зорилгоор хуваарилдаг болохыг мэдээлсэн байна (International Republican Institute, 2016, х.15).
- Улс төрийн намууд дүрэмдээ намын шийдвэр гаргах удирдах байгууллагад эмэгтэйчүүдийн төлөөллийг 20-40% байхаар тусган ажиллаж байна. Тухайлбал Ардчилсан Намын Үндэсний зөвлөлдөх хорооны 154 гишүүний 51 нь эмэгтэй, Монгол Ардын Намын Бага хурлын гишүүд болон Удирдах зөвлөлийн гишүүдийн 20% нь эмэгтэй, Иргэний Зориг Ногоон Намын Удирдах зөвлөлийн гишүүдийн 50% нь эмэгтэй байхаар тус тус намын дүрэмдээ тусгасан байна. Эдгээрээс үзэхэд Улсын Их Хурлын эмэгтэй гишүүдийн тоо өссөн, намууд энэ чиглэлээр санал санаачлагатай ажиллаж байгаа ч шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд учирч буй саад бэрхшээлийг арилгахад чиглэсэн улс төрийн намуудын хүсэл зориг чухал хэвээр байна.
- Намууд намын удирдлагаар дэмжигдсэн, олонд танигдсан, намын хэрэгцээ шаардлагад нийцсэн, чадварлаг эсвэл намдаа санхүүгийн дэмжлэг үзүүлж чадах нэгнийг нам дотроо удирдах албан тушаалд томилох, сонгуульд нэр дэвшүүлдэг ба эдгээр шалгуурууд эмэгтэйчүүдийг мухардалд оруулдаг байна. Түүнчлэн сонгуулийн үеэр намын эрэгтэй гишүүд нэр дэвшиж, эмэгтэй гишүүд ихэвчлэн арын албыг хариуцах явдал түгээмэл байдаг байна (International Republican Institute, 2016, х.13).

Нийгмийн хүчин зүйлс:

- Албан ба албан бус нийгмийн олон үйл ажиллагаанд эмэгтэйчүүдээс илүү эрэгтэйчүүд оролцвол нийгэм энгийнээр хүлээн авдаг уг тэнцвэргүй байдал хөдөө орон нутагт илт мэдэгдэх ба эмэгтэйчүүд олон нийтийн сөрөг гүтгэлгээс зайлсхийхийн тулд томчууд оролцсон олон нийтийн уулзалт арга хэмжээнд очихоос хааяа татгалздаг гэж эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоонд тулгамдаж байгаа асуудлыг судалсан судалгаанд оролцогчид мэдэгджээ (International Republican Institute, 2016). Эрэгтэйчүүд чөлөөт цагийг илүү ашиглах аргаар танилын хүрээгээ тэлэх боломж нээлттэй байхад эмэгтэйчүүдийн хувьд энэ боломж хязгаарлагдмал байдаг (х.10), эмэгтэй нэр дэвшигчид хов жив, цуу ярианд өртөмтгий байдаг гэсэн нийгмийн хандлага сонгуульд өрсөлдөх хүсэлтэй эмэгтэйчүүдийн зоригийг мохоож энэ нь цаашлаад улс төрийн манлайлагч болох магадлалтай эмэгтэйчүүдийн тоог бууруулах нэг хүчин зүйлд болдог (х.16), эмэгтэй нэр дэвшигчид ихэвчлэн эрэгтэй өрсөлдөгчидтэй харьцуулахад олон нийтэд бага танигдсан байдгаас гадна өөрийгөө олон нийтэд таниулах гэж бартаатай зам туулдаг тул энэ байдал нь тэдэнд илүү цаг хугацаа, санхүүгийн бэрхшээл болдог байна.

Эдийн засаг:


- Эмэгтэйчүүд ихэнхдээ төрийн үйлчилгээний салбарт буюу боловсрол, эрүүл мэндийн чиглэлээр түлхүү ажиллаж байхад эрэгтэйчүүд бизнес, уул уурхай, дэд бүтэц зэрэг салбарт давамгайлж байна. Ихэнх улс төрийн намууд нэр дэвшигчдэд санхүүгийн туслалацаа үзүүлдэггүй, нэр дэвшигчид өөрсдийгөө санхүүжүүлэх ёстой гэж үздэг. Ийм тохиолдолд бага цалинтай, эдийн засгийн чадавх сул эмэгтэйчүүд банкнаас зээл авах шаардлагатай болж санхүүгийн хувьд эрх чөлөөтэй эрэгтэйчүүдтэй өрсөлдөх болдог байна (International Republican Institute, 2016, х.9) Улсын хэмжээний сонгуульд танил тал ихтэй, санхүүгийн боломжтой эрэгтэй нэр дэвшигчид ялах магадлал өндөр байдаг бөгөөд уг судалгаанд хамрагдсан бараг бүх оролцогчид санхүүгийн бэрхшээлээс шалтгаалан кампанит ажлын үеэр хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглаж чаддаггүй гэсэн байна (х.17). Монголын улс төрийн системд тулгамдаж буй бас нэг асуудал нь эмэгтэйчүүд, залуучуудын хувьд улс төрд тэгш нөхцөлд оролцож өрсөлдөх боломж хязгаарлагдмал, сонгуульд нэр дэвшихийн тулд эмэгтэйчүүд, залуучууд янз бүрийн бэрхшээлтэй тулгардаг ба түүний дотор эдийн засгийн нөөц боломж хомс байдаг нь гол бэрхшээл болж байна (Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн; Нээлттэй нийгэм форум, 2018).

ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИН ДЭХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХТАЙ ХОЛБООТОЙГООР 2015-2019 ОНД МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

МУ-ын Засгийн газрын түвшинд хэрэгжүүлсэн үйл ажиллагааг нэгд бодлогын орчныг сайжруулах чиглэлээр, хоёрт төсөв, гуравт сургалт, дөрөвт судалгаа гэсэн ангиллаар төрийн холбогдох байгууллагуудаас ирүүлсэн мэдээллийг нэгтгэв. Нийт нэр бүхий 11 газарт мэдээлэл хүссэн албан тоотыг хүргүүлсэн ба үүнээс 10 газар нь хариу ирүүлсэн. Хүний эрхийн үндэсний комисс ямар нэгэн хариу өгөөгүй байна.

	Нэрс	Бодлогын орчинг сайжруулах чиглэлээр	Төсөв	Сургалт	Судалгаа
1	ХЗДХЯ, МУ-д ГХУСАЗЗ	✗	✗	✗	✗
2	ХНХЯ	✗	✗	✗	✗
3	ЭМЯ	✗	✗	✗	✗
4	БСШУСЯ	✗	✗	✗	✗
5	ШЕЗ	✗	✗	✗	✗
6	УЕПГ	✗	✗	✗	✗
7	ЦЕГ	✗	✗	✗	✗
8	ГБХЗХГ	✗	✗	✗	✗
9	ХБХЕГ	✗	✗	✗	✗
10	ЖҮХ	✓	✓	✓	✓
11	ХЭҮК	Мэдээлэл ирүүлээгүй			

✓ Тийм ✗ Үгүй



БАРИМТЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН:

Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо



2

ЧАНАРЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Баримтын судалгааны үр дүнд үндэслэн бид чанарын судалгааг дараах асуудлуудыг тодорхойлох зорилгоор хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Одоогийн эерэг тогтолцоог (хууль эрх зүйн орчин болон намын дүрэм) бодит болгоход учирч байгаа бэрхшээл юу вэ? Түүнийг яаж шийдвэрлэх вэ?
- Намын шийдвэр гаргах түвшний эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд юу чухал вэ?
- Нэр дэвшигч эмэгтэйчүүдэд ямар дэмжлэг хэрэгтэй байдаг вэ? Тэрхүү дэмжлэгийг хэрхэн баталгаажуулах боломжтой вэ?

Чанарын судалгаанд улс төрийн намын удирдах албан тушаалтнууд, УИХ, ИТХ-д нэр дэвшиж байсан эмэгтэйчүүд, улс төр судлал болон жендэр судлалын чиглэлээр судалгаа, шинжилгээний ажил хийдэг экспертүүд оролцсон ба нийт 17 ганцаарчилсан ярилцлага, 2 фокус бүлгийн ярилцлага зохион байгууллаа.

Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зорилго бүхий бодлогын хэрэгжилтэнд тулгамдаж байгаа бэрхшээл, цаашид авах арга хэмжээ:

- “Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль”-ийн 10 дугаар зүйлд эмэгтэйчүүдийн улс төр болон шийдвэр гаргах түвшин дэх оролцоог нэмэгдүүлэхийн тулд тодорхой квотуудыг хэрэгжүүлэх талаар заасан байдаг. Гэвч тус хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа бөгөөд хуулийн хэрэгжилтийг үнэлэх мониторинг, түүний дагуу хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах ажлыг тогтмол хийх шаардлагатай болохыг судалгаанд оролцогчид илэрхийлж байлаа. Ялангуяа орон нутгийн түвшинд улс төрийн нам харгалзахгүйгээр 4 жилийн хугацаатай тус хуулийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулах, түүнийгээ хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.
- Түүнчлэн олон нийт болон төрийн байгууллагын албан хаагчдын дунд жендэрийн тэгш байдлын талаарх ойлголт, мэдлэг хангалтгүй учир хуулийн хэрэгжилт хангалтгүй байна гэж судалгаанд оролцогчид үзэж байна. Хэдийгээр энэ төрлийн сургалт хийдэг боловч иргэдэд хүрдэггүй тул эмэгтэйчүүдийг нийгэмд ч, улс төрийн нам болон төрийн байгууллагад ч дэмжихгүй байна. Иймд жендэрийн хэвшмэл ойлголтыг халах, жендэрийн тэгш байдлын ач холбогдол, утга учрыг таниулах олон нийтэд чиглэсэн кампанит ажлыг зайлшгүй хийх шаардлагатай гэж судалгаанд оролцогчид үзэж байна.
- Монгол Улсын жендэрийн үндэсний тогтолцоо нь “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль”-ийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий байгууллага, нэгжүүдийн үйл ажиллагааны нэгдэл юм. Энэхүү тогтолцоог үндэсний аймаг, нийслэлийн, сум, дүүргийн гэсэн түвшингээр ангилан үзэх боломжтой. Үүнд:
 1. Үндэсний түвшинд УИХ, УИХ дахь эмэгтэй гишүүдийн бүлэг, ХЭҮК, ТАЗ, ҮСХ болон Засгийн газар, ЖҮХ түүний ажлын алба, яамдууд;
 2. Аймаг, нийслэлийн түвшинд аймаг, нийслэлийн ИТХ, засаг захиргаа, орон нутгийн салбар зөвлөл, жендэрийн мэргэжилтнүүд, орон нутгийн ИНБ-ууд;
 3. Сум дүүргийн түвшинд сум, дүүргийн ИТХ, засаг захиргаа, салбар хороод, жендэрийн мэргэжилтнүүд, ИНБ-ууд юм.
- Жендэрийн Үндэсний Хороо 2005 онд байгуулагдан, ажиллаж ирсэн. Хороог Монгол Улсын Ерөнхий сайд даргалан ажиллаж байна. “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль”-ийн 18 дугаар зүйлийн 18.1-д зааснаар “Жендэрийн үндэсний хороо нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах

бодлогыг хэрэгжүүлэхэд төр, олон нийтийн тэнцүү оролцоог хангаж, тогтвортой ажиллах баталгааг бүрдүүлсэн орон тооны бус байгууллага мөн. Жендэрийн үндэсний хороо ажлын албатай байна” гэж заасан бөгөөд тус хуулийн 18 дугаар зүйлд хорооны чиг үүргийг тодорхойлсон. ЖҮХ-ны ажлын алба нь 2020 оныг хүртэл 8 хүний орон тоотой ажиллаж байсан нь салбар дундын зохицуулалт хийх, хуулийн болон Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавьж мониторинг хийхэд хүний нөөц, ур чадвар, зохион байгуулалт нь хангалттай бус байсан байна.

- Монгол Улсын Засгийн газраас 2020 оны 4 дүгээр сард Засгийн газрын 80 дугаар тогтоолоор орон тоо 8 хүн байсныг 14 хүн болгон нэмэгдүүлжээ. ЖҮХ-ны дэргэд 2013 оноос Жендэрийн үндэсний шинжээчдийн баг байгуулан ажиллаж байна. Гэхдээ шинжээчдийн багийн үйл ажиллагааг дэмжих, өргөжүүлэх, мэргэжлийн түвшинд хүргэхэд төсөв, санхүүжилт хангалтгүй байгаагийн зэрэгцээ шинжээчдийн багийн бүрэлдэхүүнийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.
- “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль”-д, төрийн албанд тусгайлсан жендэрийн хариуцсан мэргэжилтэн байна гэж заасан. Гэтэл өнөөг хүртэл жендэрийн асуудлыг төрийн захиргааны мэргэжилтэн хавсран гүйцэтгэж байна. Энэ нь төрийн албанд жендэрийн эрх тэгш байдлыг бий болгох, энэ талаарх ойлголт, мэдлэгийг түгээх, төлөвшүүлэхэд саад болж байна.
- ЖҮХ нь гадаадын донор байгууллагын дэмжлэгтэй хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн хүрээнд сургалтын бааз, техник технологи, аргачлалаа сайжруулахаар сургагч багш нарыг үе шаттай бэлтгэж байна.

Улс төрийн намын орчинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд тулгамдаж буй асуудал болон шийдэл:

- Улс төрийн намуудын хувьд “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль”, “Жендэрийн тэгш байдлын талаарх Үндэсний хөтөлбөр”-ийн зүйл заалтыг баримтлах талаар тэр бүр нарийн тодорхой ойлголтгүй байна. Зөвхөн УИХ-ын сонгуулийн хугацаа ойртмогц УИХ-ын “Сонгуулийн тухай хууль”-ийн дагуу 76 нэр дэвшигчийн 20% нь эмэгтэй нэр дэвшигч байх заалтыг биелүүлэхийг эрмэлздэг. Нэр дэвшүүлэх үйл явц нь улс төрийн намуудын өөрсдийн дотоод дүрэм, журмаар шийгдэгддэг тул үүнд баримтлах нийтлэг нэг зарчим байхгүй байна. Энэ нь эмэгтэйчүүдэд илүү хохиролтой байгаа нь харагдаж байна.
- Улс төрийн намууд дотоод журмандаа намын удирдах байгууллагад эмэгтэйчүүдийн сонгогдох квотыг тусгасан байна. МАН-ын Бага хурлын нийт гишүүдийн 30%- д нь эмэгтэйчүүд байх, АН-ын Үндэсний бодлогын хороонд нийт 280 гишүүний 51 нь эмэгтэй суудал байх дүрэмтэй байна. Бусад намуудын дүрэм, журмыг сайтар судлан харьцуулалт хийх шаардлагатай нь уг судалгаагаар харагдлаа.
- Улс төрийн намуудын тогтоосон квот нь зөвхөн намын удирдах түвшний хүйсийн харьцааг тогтоож байгаа бөгөөд намын бусад албан тушаал, бүтцэд хамаарахгүй байгаа нь нам дотроо жендэрийн тэгш байдлыг хангах хүсэл зориг байхгүй, намын дотоод ардчилал хангалтгүй байгааг илэрхийлж байна.
- Мөн эмэгтэйчүүдийг дэмжих санхүүгийн болон хүний нөөц хангалтгүй нь ажиглагдлаа. Иймээс Сонгуулийн хуулийн зүйл заалтыг хэрэгжүүлэх бүтцийг намуудын бүтцэд оруулах, мөн улс төрийн намын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахад анхааран ажиллах шаардлага байна. 2020 - 2030 он хүртэл ТХЗ-ын 5-д хүргэх зорилтыг хангахад дахин УИХ-ын “Сонгуулийн тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулж, эмэгтэйчүүдийн нэр дэвших квотыг 30%, бүр цаашилбал **“суудал хадгалах квот”**-ын талаар санал дэвшүүлж лобби хийн ажиллах шаардлага байна.

Эмэгтэйчүүдэд шаардлагатай байгаа дэмжлэгүүд:

1. Санхүүжилтийн талаарх дэмжлэг

- Улс төрийн намын анхан шатнаас дунд түвшин хүртэл эмэгтэйчүүд илүү идэвхтэй ажилладаг. АН болон МАН-ын нийт гишүүдийн 50 гаруй хувийг эмэгтэйчүүд эзэлж байгааг ярилцлаганд оролцсон намын удирдлагууд онцолсон. Намын дотоод удирдлага, шийдвэр гаргах шат шатны түвшинд эмэгтэйчүүд оролцох хүсэл эрмэлзэл байдаг ч намын дэнчин, татвар нь эмэгтэйчүүдэд давхар ачаалал үүсгэж, оролцоог хязгаарлаж, шилэн хана бий болгосоор байна. Монгол Улсад 2008 оноос хойш улс төрийн намууд сонгуулийн тогтолцоо, нэр дэвших процессыг улс төрийн бизнес болгож байна.
- Намын дүрэм журамд тухайн намд гишүүн элсүүлэх, нэр дэвшигчийг сонгох, нэр дэвшүүлэх журам, шийдвэр зэрэг нь хаалттай, ихэнх нь тодорхой бус байна. Улс төрийн намын удирдлагуудын дийлэнх нь эрэгтэйчүүд байгаагаас эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэхдээ хайнга ханддаг нь ажиглагдсан байна.
- Улс төрийн намууд эмэгтэйчүүдийг дэмжих, тэдний оролцоог нэмэгдүүлэх ач холбогдлыг төдийлөн сайн ухамсарлахгүй зөвхөн квотоор хязгаарлаж байна.

2. Эмэгтэйчүүдийн ур чадварыг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг хөгжүүлэх

- Эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшний оролцоог нэмэгдүүлэхэд эмэгтэйчүүдийг бэлтгэх, тэдний улс төрийн манлайллыг дэмжих шаардлагатай бөгөөд энэ талаарх туршлага дутмаг, өнөөгийн хэрэгцээ шаардлагад төдийлөн нийцэхгүй байгааг ярилцлагад оролцогчид онцолсон.
- Улс төрийн намуудын дэргэдэх эмэгтэйчүүдийн байгууллагуудад эмэгтэйчүүдийг улс төрд гаргах системтэй бодлого байхгүй байна. Жендэрийн хэвшмэл ойлголтоос үүдэн бий болсон нэг асуудал нь эмэгтэйчүүд чадвар, чадамжтай хэдий ч албан тушаал горилох, нэр дэвших хүсэл эрмэлзэл бага байдгийг судалгаанд оролцогчид хэлж байв. Эмэгтэйчүүд өөрсдөө хүчин чармайлт гаргахгүй байх, эрх мэдэлд очсон эмэгтэйчүүд нэгдэж хамтран ажиллах тал дээр учир дутагдалтай байгаа нь эмэгтэйчүүдийн бодит оролцоог нэмэгдүүлэхэд саад болж байна.
- Улс төрийн намын нэг чиг үүрэг нь бодлогоор хүний нөөцөө бэлтгэх явдал юм. Иймд намын хүний нөөцийн бодлогоор эмэгтэйчүүд, залуучуудаа бэлтгэж, мэдээллийн сан бүрдүүлэх нь намын цаашдын хөгжилд эерэг нөлөө үзүүлэх болно. Намуудын дэргэд судалгааны байгууллага ажиллаж байгаа ч Тинк Танкийн боломж, чадавх нь хангалтгүй байна.
- Эмэгтэйчүүдийг улс төрийн манлайлалд тодорхой үе шат бүхий сургалтын хөтөлбөрийн дагуу сургах, бэлтгэх, зохион байгуулах нь үр дүнтэй. Жишээ нь: намын анхан шатны болоод сум, дүүргийн ИТХ-д нэр дэвшиж сонгогдон ажиллах, нийслэл, аймгийн намын дунд шатны, болон аймаг, нийслэлийн ИТХ-д нэр дэвших, засаг захиргааны байгууллагад томилогдох, УИХ-ын сонгуульд нэр дэвшихийн өмнө буюу дараах гэсэн байнгын сургалт хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь эмэгтэйчүүдийг шийдвэр гаргах оролцоог нэмэгдүүлэхэд маш чухал нөлөө үзүүлнэ.
- Эмэгтэйчүүд, улс төр, нийгэм, эдийн засгийн асуудлыг илүү судалгаа шинжилгээнд суурилан боловсруулах, санал бодлоо илэрхийлэх ур чадварыг эзэмших шаардлагатай байна. Мөн эмэгтэйчүүдийг дэмжих баг тасралтгүй ажиллуулах, эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, эргэх холбоо үүсгэх нь амжилтад хүргэх нэг алхам болно.
- Сонгогдсон эмэгтэйчүүдийн төлөөлөл, эмэгтэйчүүдийн хүний эрхийн байгууллагууд хамтран ажиллах, эгэх холбоог бий болгох нь зүйтэй.

ДҮГНЭЛТ:

1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд тусгагдсан квотыг хэрэгжүүлэх механизм хангалтгүй байна.
2. Улс төрийн намын шатлал бүрт эмэгтэйчүүдийг дэмжих хандлага, дэмжлэгийн тогтолцоо сул мөн намын шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо бага байна. Иймд улс төрийн намын зүгээс эмэгтэйчүүдийг тогтвортой дэмжих бодлого, боломжийг бүрдүүлэх шаардлагатай байна.
3. Эмэгтэй нэр дэвшигчид нь санхүүгийн чадамж болон бусдын дэмжлэг бага байна.
4. Эмэгтэйчүүдийг улс төрд оролцох чадвар багатай гэж үзэх үзэл, эрэгтэй улс төрчидтэй харьцуулан жиших олон нийтийн хандлага, жендэрийн хэвшмэл ойлголт өөрчлөгдөөгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Бодлогын орчинг сайжруулах чиглэлээр:

1. “УИХ-ын сонгуулийн тухай хууль”-д тусгагдсан 20 хувийн квотыг нэмэгдүүлэн 30 хувь болгох, суудал хадгалах квотын талаар нөлөөллийн ажил хийх;
2. Улс төрийн намын тухай хуульд жендэр, эмэгтэйчүүдийг дэмжих бүлэг заалтыг тусгах;

Мэргэшүүлэх чиглэлээр:

1. Эмэгтэйчүүдийн мэдлэг, ур чадварыг сайжруулах сургалтын тусгай хөтөлбөр боловсруулан, байнгын тасралтгүй сургалтыг мэргэжлийн түвшинд зохион байгуулах;
2. Эмэгтэйчүүдийн нэр хүнд, үнэ цэн, оролцооны үнэлэмжийн талаар хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах, сэтгүүлчдийн мэргэшсэн баг бий болгох;

Үндэсний тогтолцоог сайжруулах чиглэлээр:

1. ЖҮХ-ны Гишүүдийн үүрэг, хариуцлагыг тодорхой тусгах;
2. ЖҮХ-ны ажлын албаны бүтэц, зохион байгуулалтыг бие даасан Засгийн газрын төр захиргааны статустай болгох;
3. Жендэрийн хүний нөөцийг системтэй бэлтгэх бодлоготой болох;
4. ЖҮХ-ны салбар, зөвлөл хороодын үйл ажиллагааг үнэлэх, жендэрийн мониторинг, аудитыг тогтмол хийх
5. ЖҮХ-ны салбар, зөвлөл, хороодын жендэрийн үйл ажиллагааг дэмжих санхүү төсвийг нэмэгдүүлэх, жендэрийн мэдрэмжтэй төсөв бий болгох
6. ЖҮХ-ны дэргэд “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль”-д заасан тусгайлсан түр арга хэмжээг авах, шийдвэр гаргах түвшний эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр мэргэшсэн баг байгуулан ажиллах
7. Эмэгтэйчүүдийг улс төрд оролцох чадвар сул гэж үзэх үзэл, эрэгтэй улс төрчидтэй харьцуулан жиших олон нийтийн хандлага, жендэрийн хэвшмэл ойлголт өөрчлөгдөөгүй байна. Иймд олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны талаарх эерэг хандлагыг төлөвшүүлэх.



ГУРАВДУГААР БҮЛЭГ:
ХӨДӨӨГИЙН ЭМЭГТЭЙЧҮҮД

ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ:

Орон нутагт амьдарч буй эмэгтэйчүүд:

- Дэлхийн банкнаас тодорхойлсон хөгжлийн үзүүлэлтээр Монгол Улс эхийн эрүүл мэнд, нөхөн үржихүйн байдлаар бүс нутагтаа төдийгүй дэлхийн хэмжээнд сайн байна. Монгол Улс олон улсын холбогдох гэрээ конвенцод нэгдэж, Үндсэн хуулиндаа эх хүүхдийн эрүүл мэндийг тусган, ЖЭТБХТХууль болон Засгийн газрын эрүүл мэндийн талаарх бодлого хөтөлбөрт тусгах зэргээр эхийн эрүүл мэндийг дэмжих эрх зүйн хүчирхэг орчин бүрдүүлснээр эхийн эндэгдлийг бууруулж чадсан байна. Монгол эхчүүд жирэмслэлт, төрөлт болон төрсний дараах эрүүл мэндийн үйлчилгээг үнэ төлбөргүй авах боломжтойн дээр хөдөө орон нутагт эрсдэлтэй байж болошгүй жирэмсэн эхчүүдэд зориулсан амрах газруудыг бий болгож теле-анагаах ухааны үйлчилгээг нэвтрүүлсэн нь давуу талтай байна. Гэвч ЭМЯ олон улсын түншлэгчидтэй хамтран хэрэгжүүлж байгаа өсвөр үе, залууст ээлтэй клиник байгуулах, бэлгийн эрүүл мэндийн талаар залуучуудад зориулсан хөтөлбөр боловсруулах зэрэг санаачилга хэрэгжиж байгаа ч алслагдсан хөдөө орон нутгийн хүүхэд залууст хүртээмжгүй байна (Жендэрийн үндэсний хороо, 2019). Түүнчлэн нүүрсний олборлолт, тээвэрлэх үйл ажиллагаатай холбоотой үүссэн тоосжилтоос шалтгаалан жирэмсний үеийн хүндрэл гарах нь ихэссэн ба эрүүл мэндийн ажилтны хүрэлцээгүй байдлаас үүдэн эх барих эмч, сувилагч нарын ачаалал их, амралт, нойр дутуу байх, үйлчлүүлэгчид бухимдах зэрэг асуудал үүсдэг байна. Мөн жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд тэмбүү өвчний илрэл нэмэгдэж байгааг уг судалгаанд онцолжээ (Бодлогын судалгааны хүрээлэн, 2018). Үүнээс харахад нөхөн үржихүйн тусламж үйлчилгээг орон нутгийн иргэдийн хэрэгцээнд нийцүүлэх шаардлагатай байна.
- Орон нутагт хүүхдэд боловсрол эзэмшүүлэхтэй холбоотой зарим нэг асуудал тулгамдаж байна. Жишээ нь хүүхдийг 6 наснаас сургуульд суралцуулахтай холбоотойгоор гэр бүл тусдаа амьдрах явдал түгээмэл байна. 1200 хүнээс авсан судалгаанд оролцогчдын дийлэнх нь 6 настай хүүхэд сургуульд орох болсноор хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, сурлага хүмүүжлээс гадна өрхийн санхүү, гэр бүлийн харилцаанд сөрөг нөлөөтэй гэж хариулсан байна (Жендэрийн үндэсний хороо, 2019). Ядуурлын улмаас хүүхдийнхээ хувцас, хичээлийн хэрэгслийг худалдан авч чадахгүй байгаа өрхийн тоо өсч, хөдөө орон нутагт ядуу өрх хүүхдийнхээ байр, хоолны зардлыг төлж дийлэхгүй зэрэг хүндрэл бэрхшээлүүд байна (Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, 2018, х.29). Мөн охид, хөвгүүдийн бие засах газрыг тусдаа болгох талаар чамгүй ажил хийгдэж байгаа ч хөдөөгийн сургууль, дотуур байрууд гадаа бие засах газартай байгаа нь охидын эрүүл ахуйн хэрэгцээнд нийцэхгүйгээс гадна ялангуяа гэрэлтүүлэггүй бол хүчирхийлэлд өртөх эрсдлийг бий болгож байгааг бодлого төлөвлөлтөд анхаарч тусгах шаардлагатай ажээ (Жендэрийн үндэсний хороо, 2019, х.43).
- Хөдөөгөөс хотыг чиглэсэн шилжих хөдөлгөөн үргэлжилсээр, хөдөө орон нутгийн зарим хэсэгт хүн ам хэт цөөрч, шилжин ирэгсдийн дунд хөдөлмөрийн насныхан, залуус, ялангуяа залуу эмэгтэйчүүд дийлэнх байгаа нь хот хөдөөгийн хүн амын нас, хүйсийн тэнцвэрийг алдагдуулах үр дагавартай байна (Жендэрийн үндэсний хороо, 2019, х.38). Шилжих шийдвэр гаргахад эмэгтэйчүүд тухайн өрхийг тэргүүлж байгаа эсэхээс үл хамааран гол үүрэгтэй оролцдог байна. Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагаас гаргасан судалгаанд 2017 оноос нийслэлд байнга оршин суух шилжилт хөдөлгөөнийг зогсоосон нь бүртгэлгүй оршин суугчдын тоог нэмэгдүүлэхэд нөлөөлж байгааг судлаачид тэмдэглэсэн байна (х.38). Түүнчлэн 2005 - 2018 онд хангайн, төвийн болон зүүн бүсүүдэд гэрлэлтийн тоо буурч байгаа нь хөдөө орон нутаг эзгүйрэх чиг хандлагыг харуулж байна (х.38). Зарим газар хүн ам цөөрч байхад уул, уурхай дагасан бүсэд хүн амын төвлөрөл ихэссэн ба түүнийг дагасан

асуудлууд хөндөгдөж байна. Жишээ нь Цогтцэций сумын иргэдээс авсан асуулгын судалгаанаас үзэхэд иргэдийн дийлэнх нь хүн амын өсөлтийн улмаас нийгмийн үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаанд нэмэлт ачаалал үүсч, хүртээмж буурсан гэж үзэхийн зэрэгцээ 41% нь хулгайн гэмт хэрэг ихэссэн гэж үзсэн ба олонх иргэд охид, эмэгтэйчүүдийн аюулгүй байдалд санаа зовних болсон байна (Бодлогын судалгааны хүрээлэн, 2018, х.45). Ахлах сургуулийн сурагчидтай хийсэн ярилцлагаар Цогтцэций сумын төвөөр дайран өнгөрч буй, ойролцоо ажиллаж буй хөдөлгөөнт хүн ам их байдаг нь охидод эрсдэл үүсгэж байгааг онцолжээ. Оройн цагаар согтууруулах ундаа хэрэглэсэн үл таних хүмүүс их байдаг. Ганц нэгээрээ явж буй охид, эмэгтэйчүүдийг дуудах, айлгах ичээх зэрэг тохиолдол гардаг. Үүнтэй холбоотой өөрийн болон гэр бүлийнхээ гишүүдийн аюулгүй байдалд санаа зовних байдал ихэссэн байна. Түүнчлэн нүүрс тээвэрт олон хоногоор ажиллах, ажлын нөхцөл, ачааллаас сэтгэлзүйн хямралд орох, архи хэтрүүлэн хэрэглэх, амрах хугацаандаа архи уудаг зэрэг шалтгаанаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх явдал нэмэгдэх эрсдэл байна гэж тус судалгаанд дурджээ (х.52).

- Хөдөөд нийт хүн амын 30.8% нь ядуу байгаа нь хот суурин газрын ядуурлын хамралт (27.2%)-иас бага зэрэг өндөр байна. Ядуурлын түвшин хот суурин газар, хөдөөд ялгаатай байхын зэрэгцээ газар зүйн байршлаар мөн ялгаатай байна. Улаанбаатар хотод аймгийн төвүүдтэй харьцуулахад, сумын төвд хөдөө нутгийнхтай харьцуулахад ядуурлын хамралт бага байна (Үндэсний статистикийн хороо, Дэлхийн Банк, 2019).
- Орхон, Сэлэнгэ аймагт газар тариалан эрхлэгч эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдтэй хийсэн бүлгийн ярилцлагаас газар тариалан эрхлэлтийг дэмжих сангийн дэмжлэг эмэгтэйчүүд болон залуучуудад хүртээмж багатай байгаа нь харагдсан байна. Эмэгтэйчүүдийн бизнес илүү жижиг, эргэлт багатай, цөөн ажилчинтай мөн эдгээр бизнес нь дэд бүтэц буюу ус, ариун цэврийн төхөөрөмж, цахилгаан, халаалтаас ихээхэн хамааралтай, гэтэл хотын гэр хороолол болон хөдөөд эдгээр нь хязгаарлагдмал байна. Түүнчлэн газрыг эрэгтэйчүүдийн нэр дээр бүртгэх, эрэгтэйчүүдэд өвлүүлэх хандлага ялангуяа хөдөөд түгээмэл байна. 2013 онд хот, хөдөөгийн 800 өрхийг хамруулан хийсэн үнэлгээгээр газрын зөвхөн 27.2 хувийг эмэгтэйчүүд өмчилж байгаа нь тогтоогджээ. Нийт ЖДҮ-ийн 80 хувь нь бичил бизнес бөгөөд талаас илүү нь нийслэлд төвлөрч, харин хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрийн салбарт ажиллаж буй ЖДҮ-ийн эзлэх хувь бага, 15 хувиас хэтрэхгүй байна. Мал аж ахуй эрхлэгчдийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 2012 оноос хойш буурсаар 2018 онд 42.8% болжээ (Жендэрийн үндэсний хороо, 2019, х.29).
- Монголд интернет хэрэглэгчдийн тоо 2005 онд хүн амын 0.8% байсан бол 2018 онд 92.9% болжээ. Үүрэн утасны бүртгэлтэй хэрэглэгчдийн тоо мөн хугацаанд 9.5 дахин өссөн байна. Хөдөөгийн оршин суугчид үүрэн утсаар ярих төдийгүй олон нийтийн сүлжээнд идэвхтэй орох болсон байна. Энэ нь ялангуяа хөдөөгийн эмэгтэйчүүдэд гэр орны ажлаа эрхлэнгээ мэдээллээс хоцрохгүй, нийгмийн амьдралын бүх хүрээнд оролцох, шаардлагатай мэдээллийг цаг алдалгүй авах боломж олгосон ахиц дэвшил юм. Жишээлбэл ОБЕГ-аас цаг агаарын ноцтой үзэгдлийн талаарх сэрэмжлүүлгийг гар утсаар бүх хүнд хүргэж байгаа нь гамшгаас сэргийлэх боломжийг өрхийн бүх гишүүнд олгодог байна (Жендэрийн үндэсний хороо, 2019, х.33).

Малчин эмэгтэйчүүд:

- Малчдын (15-аас дээш насны) 36.2% буюу 5 малчин тутмын хоёр нь сүүлийн 12 сарын хугацаанд (2017 оны 8-р сарын байдлаар) эрүүл мэндийн асуудалтай байжээ. Эрүүл мэндийн асуудал үүссэн малчдын 47.9% нь эрэгтэй, 52.1% нь эмэгтэй малчид байна (ММСГ, 2017, х.27). Малчин эмэгтэйчүүдийн хувьд жирэмсний үед үүсэх эмгэг болон даралт ихсэхэд эмнэлэгт хандаж эрүүл мэндийн үйлчилгээ авдаг. Харин эрэгтэй малчид гэмтэл хордлого, гадны шалтгаант эмгэг болон хоол боловсруулах тогтолцооны өвчнөөр эмнэлэгт ханддаг байна. Малчид эрүүл мэндийн асуудал тохиолдоход дунджаар 35.5км (хамгийн багадаа 1 км, хамгийн ихдээ 700 км зам) туулж эмнэлгийн үйлчилгээ авч байна. Малчдын 26.0% нь эрүүл мэндийн байгууллагын үйлчилгээг муу гэж үнэлж байна. Эрүүл мэндийн байгууллагын эмчийн мэдлэг, ур чадвар муу (28.4%), ажилтнууд харилцааны

соёлгүй (20.0%) байдаг учраас муу гэсэн үнэлгээг малчид өгчээ (х.28). Ерөнхийдөө хөдөө амьдарч буй малчид нийслэл, аймгийн төв, сумын төвтэй харьцуулахад эрүүл мэндийн үйлчилгээ хүртэхэд харьцангуй хол буюу сумын эмнэлгээс 29.9км, аймгийн нэгдсэн эмнэлгээс 123.5км зайтай амьдарч байна. Түүнчлэн малчид малын өвчний талаар бүрэн бус мэдээлэлтэй, өвчний шинж тэмдгийг төдийлөн сайн мэддэггүй, өвчнөөс хамгаалах халдвар хамгааллын дэглэм барьдаггүй, малын сэгийг хэрхэх талаар ойлголт багатай байна (Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт, 2018, х.61). Мөн малчин өрхүүдийг халуун ус, боловсон жорлон, угаалгын машин, интернэттэй болгох шийдлийг олох нь ялангуяа залуу малчин эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, амьдралын чанарыг дээшлүүлэхэд амин чухал болох нь хөдөө аж ахуйн салбарын мэргэжилтнүүдийн бүлгийн ярилцлага, хэлэлцүүлгээр илэрсэн байна. Үүний дотор говь, хангайн бүсийн онцлогт нийцсэн эко ариун цэврийн байгууламж, зөөврийн ариун цэврийн төхөөрөмжүүд нэн тэргүүнд хэрэгтэй байна гэж үзжээ (Жендэрийн үндэсний хороо, 2019, х.32).

- Малчдын 18-аас дээш настай 62.8% буюу 5 малчин тутмын 3 нь суурь болон бүрэн дунд боловсролтой байна. Малчдын боловсролын түвшин хүйсээр ялгаатай бөгөөд 18-аас дээш настай эрэгтэй малчдын 36.9%, эмэгтэй малчдын 54.5% нь бүрэн дундаас дээш түвшний боловсролтой байна. Харин 20-29 насны малчдын 20.6% нь дээд боловсролтой байна (ММCG, 2017). Малчдын аж байдлын судалгааны (2018) үр дүнгээс харахад 30-34 насны малчдын дунд боловсрол эзэмшээгүй малчдын эзлэх хэмжээ харьцангуй өндөр (10.6 хувь) байна. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн 6-15 насны 425 хүүхдийн 97.9% нь сургуульд хамрагдсан бол 2.1% нь сургуульд хамрагдаагүй байна. Энэ үзүүлэлтийг байршлаар авч үзэхэд нийслэлээс судалгаанд хамрагдсан малчдын дунд сургуульд хамрагдаагүй хүүхэд байхгүй, аймгийн төвийн малчдын 1.3%, сумын төвийн малчдын 7.1% нь хүүхдээ сургуульд хамруулаагүй байна. Харин хөдөөгийн малчдын 98.3% нь хүүхдээ сургуульд хамруулсан бол 1.7% нь сургуульд хамруулаагүй байна. Сургуульд хамрагдаагүй хүүхдүүдийг хүйсээр авч үзвэл бүгд эрэгтэй хүүхэд байна. 6-15 насны хүүхдийн сургуульд хамрагдаагүй шалтгааныг тодруулахад 25.0% нь өвчний улмаас /хөгжлийн бэрхшээлтэй/, 16.7% нь өрхийн аж ахуйд туслахаар, 16.7% нь өөрөө суралцах хүсэлгүй, 16.7% нь сургуульд орох насанд хүрээгүй (сар дутуу), 8.3% нь эцэг эх нь сургах хүсэлгүй, 8.3% нь санхүүгийн боломжгүй, 8.3% нь бусад шалтгаанаар сургуульд хамрагдаагүй байна. Насанд хүрэгчдийн тухайд, сүүлийн 12 сарын хугацаанд шинээр мэргэжил болон ур чадвар олгох сургалтад хамрагдсан талаар тодруулахад 8.7% нь тийм гэж хариулсан бол 91.3% нь үгүй гэж хариулсан байна. Сумын төв болон нийслэлд амьдардаг малчид илүү их сургалтад хамрагддаг. Харин хөдөөд амьдардаг малчдын 4.9% нь сургалтад хамрагддаг гэсэн бол 95.1% нь ямар нэгэн сургалтад хамрагдаагүй гэжээ.
- Жилийн туршид эмэгтэйчүүдийн ажлын ачаалал өдөрт 11.1 цаг байгаа бол эрэгтэйчүүдийнх 9.2 цаг байна. Хэдийгээр эмэгтэйчүүд илүү цаг зарцуулдаг боловч гэр бүлийн ихээхэн хэмжээний худалдан авалт болон зарлага гаргахад эрэгтэйчүүдийн шийдвэр давамгайлж байна. Түүнчлэн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох, манлайлах боломж эмэгтэйчүүдэд бага байна. Өмчийн хувьд ихэвчлэн нөхрийн эзэмшил/өмчлөл буюу нөхрийн нэр дээр бүртгэлтэй байна (Swiss Agency for Development and Cooperation SDC, 2015).
- Малчин өрх, ундны усаа ихэвчлэн хамгаалагдаагүй болон механикжсан худгаас авч байна. Хавар, зун, намрын улиралд 10 малчин өрх тутмын 6 нь хамгаалагдаагүй гар худгаас ундны усаа авдаг байна. Өвлийн улиралд нэг ундны эх үүсвэрийг дунджаар 16 малчин өрх хувааж хэрэглэдэг байна. Харин хавар болон зун нэг ундны эх үүсвэрийг дунджаар 14 малчин өрх, намрын улиралд дунджаар 13 малчин өрх хуваан хэрэглэдэг ажээ (ММCG, 2017, х.30).
- Гэр бүл болоход үндэс угсаа нөлөөлж, Хамниган, Баяд, Дөрвөд, Үзэмчин, Мянгад, Урианхай, Казак, Захчин, Торгууд, Хотон, Тува, Дархад, Халимаг, Узбек, Монголын харьяат (Орос, Хятадаас бусад) гадаад, Цаатан гэсэн үндэс угсаатанд огт гэр бүл болоогүй хүн амын эзлэх хувь улсын дунджаас дээгүүр байна (Жендэрийн үндэсний хороо, 2019, х.39). Гэр бүлийн харилцаатай холбоотой бас нэгэн асуудал нь гэр бүлийн хүчирхийлэл бөгөөд 2015 онд хийсэн судалгаагаар малчин өрхийн 15 хувь гэр бүлийн хүчирхийллийн асуудалтай, тэдний дунд 35-49 насны гэр бүл зонхилж байна. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгчдөд чиглэсэн тусламж үйлчилгээг нүүдлийн мал ахуй эрхлэгчдийн,

түүний дотор малчин эмэгтэйчүүдийн онцлог нөхцөл байдалд нийцүүлэх шаардлагатай гэж үзсэн байна (х.58). Түүнчлэн өрх толгойлсон эмэгтэйчүүдийн 73.6% нь хөдөө орон нутагт байдаг ба эмэгтэй тэргүүнтэй малчин өрхийн 45.4% нь бэлэвсэн, 31.5% нь батлуулсан гэр бүлтэй байна (ММСГ, 2017, х.23). Өрхийн тэргүүн нь эмэгтэй малчин өрхийн жилийн дундаж орлого малчин өрхийн жилийн дундаж орлогоос 32.2%-иар бага байгааг тус судалгааны тайланд дурьджээ (х.69).

- Монголын эмэгтэйчүүдийн сангийн Архангай, Завхан аймагт хэрэгжүүлж буй “Эмэгтэйчүүдийн эрх ба байгаль орчин” төслийн хэрэгжүүлэгч багуудын зүгээс 95 малчин эмэгтэйг оролцуулсан “Уурхайн олборлолт явагдаж буй газар нутагт хийсэн жендэрийн үр нөлөөний үнэлгээ”-г (2018) хийж гүйцэтгэсэн. Уг судалгааны үр дүнгээс харахад уурхайн үйл ажиллагаа эхлэхийн өмнө нутгийн иргэдээс санал авдаггүй байна. Түүнчлэн нутгийн захиргааны зүгээс олборлолт явуулах байгууллагад зөвшөөрөл олгох явцад иргэдээс санал авдаггүй, тухайн байгууллагатай хийсэн гэрээг иргэдэд танилцуулдаггүй байна. Уурхайн олборлолттой холбоотой эмэгтэйчүүд өөрсдийн дуу хоолой, үзэл бодол, байр сууриа илэрхийлэх ямар боломж, нөхцөлөөр хангагдсаныг тодруулахад 85% нь тийм боломж байгаагүй гэж хариулжээ. Малчид олборлолт явагдах гэж байгаа тухай мэдээллийг хөрш, саахалт айл болон найз нөхдөөсөө авч байна. Уурхайн олборлолт явагдсанаар хур тундас багасах, усны нөөц хомсдох, хуурайшилт, тоосжилт, цөлжилт, ургамлын төрөл, гарц буурах зэрэг сөрөг нөлөө бий болж байна. Ингэснээр мал хариулахад илүү цаг зарцуулах, бэлчээрийн маргаан гарах, малчин иргэдийн дунд үл ойлголцол бий болох зэрэг асуудал үүсэж байна. Түүнчлэн эрэгтэйчүүд өөр аймаг, суманд очиж малаа оторлодог байна.

БОДЛОГЫН ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ: ДЭМЖИЖ БАЙГАА ЗОХИЦУУЛАЛТ

- “Монгол Улсын Үндсэн хууль”-д 2019 оны 11-р сарын 14-д нэмэлт өөрчлөлт оруулсан ба уг өөрчлөлтөөр хуулийн 6-р зүйлийн 6.2-т иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй гэж тусгасан.
- “Монгол Улсын Үндсэн хууль”-ийн 16-р зүйлийн 7-д .. сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно... гэжээ. Энэ нь иргэн бүр газар зүйн байрлалаас үл шалтгаалах, улмаар суралцах, боловсрох эрх нь нээлттэй гэж ойлгоно. Харин **“Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль”**-ийн 13.6-д Орлого багатай, алслагдмал нутгийн хүн ам болон үндэстний цөөнхийн хүүхэд төрүүлэх, хүүхдээ асрах эрхийг хангах ба түүнд шаардлагатай туслалцаа, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах арга хэмжээ авна. Мөн хуулийн 43.2.8-д хөдөөгийн сумдын захиалга-гэрээний дагуу багш мэргэжлээр суралцаж байгаа оюутан, магистрантад **“Боловсролын зээлийн сан”**-гаас хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл, тэтгэлэг олгох замаар ажиллах хүчнийг бэлтгэх таатай орчныг бүрдүүлжээ. Боловсролын зээлийн сан нь нь Засгийн газрын тусгай 22 сангийн нэг бөгөөд уг сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, удирдлага, зохион байгуулалт болон хяналт тавих харилцаа нь **Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн** хүрээнд зохицуулагддаг юм. Тус хууль нь 2019 онд шинэчлэн найруулан батлагдсан 6 бүлэг, 287 зүйлээс бүрддэг. Мөн түүнчлэн төрийн бодлогын хүрээнд харилцаа холбооны зайлшгүй шаардлагатай үйлчилгээг **алслагдсан орон нутагт болон үйлчилгээ хүрээгүй хүн амд бодит үнээр хүргэх, шинээр сүлжээ байгуулах**, харилцаа холбооны орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, өргөтгөх, шинэчлэх зориулалттай **“Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан”** хуульчилсан. Үүгээр алслагдсан орон нутагт төрийн үйлчилгээг хүргэхийг зорьсон байна.
- **“Эрүүл мэндийн тухай хууль”** нь төрөөс хүн амын эрүүл мэндийн талаарх баримтлах бодлогыг тодорхой болгож, улмаар “Монгол Улсын Үндсэн хууль”-д заасны дагуу иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн зарим төрлийн тусламж, үйлчилгээний төлбөрийг төр хариуцах зохицуулалтыг тусгаж өгсөн.
- **“Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль”** (ТМЭ, № 27, 2002) 2003 оноос эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Хууль хэрэгжиж эхэлснээс хойш нийт 7 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан. МУ-ын иргэнд үнэ төлбөргүй газар өмчлүүлэх, ялангуяа гэр бүлийн хэрэгцээнд дундаа

хамтран газар өмчлөх эрхийн хугацааг 5 жил байсныг 10 жилээр буюу 2028 онд хүртэл сунгахаар болсон. Энэ нь гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар Монгол Улсын иргэнд газрыг нэг удаа үнэгүй өмчлүүлэх эрхийг сунгасан юм. Үүгээр гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газрыг үнэгүй өмчлүүлэх боломжийг бүрдүүлж байна.

- **"Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль"** (ТМЭ, №26, 2011)-р иргэн, хуулийн этгээд нь хүний эрх, эрх чөлөө, үндэсний аюулгүй байдал, байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хууль тогтоомжид нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад мэдээллийг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагуудаас авах эрхтэй болсон. Үүгээр нийтийн эрх ашгийг зөрчүүлэхгүй байх, зөрчсөн эрхийг сэргээхэд шаардлагатай мэдээллийг гаргуулан авах боломжийг бүрдүүлсэн.
- МУИХ-аас **"Захиргааны ерөнхий хууль"** (ТМЭ, №28, 2015) батлагдаж, 2016 онд хуулийг хүчин төгөлдөр даган мөрдөж эхэлсэн. Энэ хүрээнд нийтийн эрх зүйн хүрээнд, гүйцэтгэх мэдлийг хэрэгжүүлэн захиргааны байгууллагаас захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт гаргах, захиргааны гэрээг батлан гарахын өмнө эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдэд захиргааны шийдвэр гаргахад ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар тайлбар, санал гаргах боломжийг хуульчилсан байна. Үүгээрээ иргэн, хуулийн этгээдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх алхам болсон давуу талтай юм.
- **"Засгийн газрын 2016–2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"** (МУИХ, 45-р тогтоол, 2016)-т мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээл, хөрөнгө оруулалт, даатгал, татварын уян хатан бодлогоор дэмжих, малын гаралтай түүхий эдийн үнэ ханшийн уналтаас хамгаалах, малчдад ирж байгаа хүндрэлийг багасгахад чиглэгдсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих тусгай санг өргөжүүлж, малчин өрхийн орлого, амьжиргааны баталгааг хангах чиглэлээр зорилт дэвшүүлсэн. Мөн хөтөлбөрийн 2.67-д хоёрдогч ашигт малтмал ашиглах эрх зүйн орчинг бий болгож, уурхайн нөхөн сэргээлт, хаалтыг олон улсын жишигт хүргэх ба хөтөлбөрийн 4.1.5-т уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох стратеги боловсруулан хэрэгжүүлэх, байгаль орчин, уур амьсгалын санг байгуулж, үндэсний чадавхыг бэхжүүлнэ гэжээ.
- **"Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр"** (МУЗГ, 50-р тогтоол, 2018)-ийн 3.1.2-т иргэдийн хэрэгцээ шаардлагад тулгуурласан зорилтот бүлэгт тухайлбал, харааны болон сонсголын бэрхшээлтэй иргэн, өндөр настан, хүүхдэд ээлтэй, тэдгээрийн нас, сэтгэхүйн онцлог, нийтлэг болон тусгай хэрэгцээ шаардлагад нь тохирсон эрх зүйн боловсролын агуулгыг хүний эрхэд суурилсан хандлага, арга зүйд нийцүүлэн боловсруулах бол 3.2.5-т хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан, хүүхдэд эрх зүйн мэдээлэл, зөвлөгөө, туслалцаа үзүүлэх хүний нөөц (дохионы хэлний хэлмэрч, сэтгэлзүйч)-ийг бэлтгэхээр тусгасан байна.
- **"Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр"** (2017-2021)-т малчин эмэгтэйчүүдийн талаар баримтлах бодлогыг тодорхойлсон. Үүнд малчин, тариаланч өрхийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих бодлого, арга хэмжээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийж, холбогдох байгууллага, шийдвэр гаргагчид зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавина /3.1.5/ гэжээ.
- **"Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого"** (2016-2025)-ийн 3.2.2-т "хүн амын шилжилт хөдөлгөөнийг зохистой түвшинд байлгах" чиглэлийн хүрээнд орон нутагт хүн тогтвор суурьшилтай ажиллаж, амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлж, хөдөө рүү чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг урамшуулах замаар хөдөөгийн хүн амын нийт хүн амд эзлэх хувийг нэмэгдүүлж, хүн амын байршлын зохистой харьцааг хот, хөдөөд тэнцвэртэй болгоно.
- **"Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр"** (2016-2020)-т хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нөхөн үржихүйн эрүүл мэнд, жендэрт суурилсан хүчирхийллээс сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломжийн талаар сургалт зохион байгуулах, баррель үсгээр сурталчилгааны материал боловсруулж түгээх /3.4.1.5/ талаарх тусгасан байна.

- **“Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль”**-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд 2019 онд Засгийн газраас **“Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр”** (2018-2020)-ийг батлан гаргажээ. Энэ хөтөлбөрийн хүрээнд хөдөө орон нутгийн иргэдийн бизнес, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор “Нэг суурин-Нэг бүтээгдэхүүн” аяныг зохион байгуулж, орон нутагт брэнд бүтээгдэхүүнийг бий болгох, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн бие даасан, бүтээлч байдлыг нэмэгдүүлэх юм.
- Монгол Улсын хүн ам 2019 оны байдлаар 3.2 саяд хүрч үүнээс нэг сая гаруй нь 15-34 насны залуучууд эзэлж байна. Залуучуудын бүлэг нийт хүн амын 33.7 хувийг, хөдөлмөрийн насны хүн амын 46.5 хувийг бүрдүүлж байна. Иймээс **“Залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”**-ийг 2019 онд Засгийн газрын 171-р тогтоолын хавсралтаар батлуулсан бөгөөд хөтөлбөрийн гол зорилго нь залуучуудын нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын амьдралд идэвхтэй оролцож, хөгжилд бодитой хувь нэмэр оруулах таатай орчинг бүрдүүлэх замаар эх оронч үзэлтэй, тусгаар тогтнол, түүх, хэл, өв соёлоороо бахархдаг, байгаль орчноо хайрлан хамгаалдаг, өөрийн, гэр бүлийн болон нийгмийн өмнө хүлээх хариуцлага, хуулиар олгогдсон эрх, үүргээ ухамсарладаг өрсөлдөх чадвартай иргэн болоход нь дэмжлэг үзүүлэх юм. Түүнчлэн залуучууд нас, **хүйс**, арьс өнгө, боловсрол, иргэний харьяалал, үндэс угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, бэлгийн чиг хандлага, хүйсийн баримжаа, илэрхийлэл, оюун ухаан, бие махбодын чадвараар ялгаварлан гадуурхагдахаас ангид байх нөхцөлийг бүрдүүлж, тэдний эрхийг хүндэтгэн хамгаалахад төрийн бодлогыг чиглүүлэх зарчмыг баримтлан ажиллах болсон.
- **“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал –2030”**-д нэг хүнд ногдох үндэсний нийт орлого 17500 америк долларт хүрч, нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүргэх, ядуурлын бүх төрлийг эцэс болгох, орлогын тэгш бус байдлыг багасгаж, нийт хүн амын 80 хувь нь дундаж болон чинээлэг дундаж давхаргын ангилалд багтаах, Монгол хүний дундаж наслалтыг 78-д хүргэх, хүний хөгжлийн өндөр үзүүлэлт бүхий эхний 70 орны нэг болох, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалж, ногоон эдийн засгийн үзүүлэлтээр дэлхийн эхний 30 орны нэг болох, бизнес эрхлэлтийн үзүүлэлтээр дэлхийн эхний 40, өрсөлдөх чадварын үзүүлэлтээр эхний 70 орны нэг болох, хөгжлийн бодлогоо бүх түвшинд хэрэгжүүлэх чадвартай, авлигаас ангид, иргэдийн оролцоог хангасан, мэргэшсэн тогтвортой засаглал төлөвшсөн байхаар зорилт дэвшүүлсэн байна.
- 2018 онд Засгийн газар **“Гурван тулгуурт хөгжлийн бодлого”** баталж, бодлогод Монгол Улсын хөгжлийн үндэс нь сайн төр, монгол хүн, монголын баялаг гэж үзэн “Нэгдмэл зорилготой Монгол Улс” үзэл баримтлалын дор “Олон тулгуурт эдийн засгийн хөгжлийн бодлого”, “Шударга ёсыг дээдэлсэн, сахилга, хариуцлагатай тогтвортой засаглал”, “Хүн төвтэй нийгмийн бодлого” гэсэн гурван тэргүүлэх чиглэлийг байгаль орчинд ээлтэй байдлаар төлөвлөж, энэ хүрээнд хэрэгжүүлэх 27 зорилтыг боловсруулсан байна.

3.3 ДЭМЖИХҮЙ БАЙГАА ЗОХИЦУУЛАЛТ

- “Монгол Улсын Үндсэн хууль”-д 2019 оны 11-р сарын 14-д нэмэлт өөрчлөлт орсон ба уг өөрчлөлтөөр 6-р зүйлийн 6.2-т Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан **төрийн нийтийн өмч**. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний **үр өгөөжийн дийлэнх нь** ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно гэсэн заалтыг 2020 оны 05-р сарын 25-наас эхлэн дагаж мөрдөхөөр болсон. Гэтэл энэ зүйлд орсон **«төрийн нийтийн өмч», «газрын хэвлийн баялгийн үр өгөөж», «үр өгөөжийн дийлэнх»** гэдэг томьёолол нь учир дутагдалтай бөгөөд ирээдүйд байгаль орчин хамгааллын эсрэг зохицуулалт болох магадлал байгааг харуулж байна.
- **“Засгийн газрын тусгай сангийн тухай хууль”**-д тусгагдсан 22 сангийн нэг нь “Хөдөө аж ахуйг дэмжих сан” юм. Тус сан нь газар тариалан, мал аж ахуй эрхлэх үйл ажиллагааг дэмжих зориулалттай бөгөөд энэ талаар мэдээллийг хөдөө орон нутгийн иргэд, эмэгтэйчүүд мэддэггүй.

- **"Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль"**-ийн зорилго нь жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, тэдгээрийн эдийн засагт эзлэх хувь оролцоог дээшлүүлэх чиглэх бөгөөд хуулийн 4.1.1-т "жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч" гэдэгт 200 хүртэл ажилтантай, жилийн 2.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байна гэж хуульчилсан байна.
- **"Боловсролын тухай хууль"**-ийн 31.1.12-т аймаг, нийслэлийн боловсролын газрын сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийг томилох, тэднийг үр дүнгийн гэрээний хэрэгжилт болон аймаг, нийслэлийн боловсролын газрын саналыг үндэслэн чөлөөлөх гэж 2018 онд нэмэлт өөрчлөлт орж улмаар 2020 оны 07-р сарын 01-нээс эхлэн даган мөрдөнө. Энэ нь улс төрийн томилгоо болсон бөгөөд энэ босоо тогтолцоо нь төрийн хувьд мэргэшсэн төрийн алба хаагчдыг ажиллуулахгүй байх эрсдэлтэй байдаг.
- Иргэн бүр эрүүл мэндийн чанартай үйлчилгээг, цаг хугацаа алдалгүй хаанаас ч бүрэн авах боломжтой хэдий ч алслагдсан орон нутагт амьдарч байгаа хөдөөгийн эмэгтэйчүүд эрүүл мэндийн тусламж авч чадахгүй байх тохиолдол элбэг байна. Тухайлбал, **"Эрүүл мэндийн тухай хууль"**-ийн **43.1.2-т өрхийн эмчээ сонгон бүртгүүлэх нь хөдөөгийн иргэдийн хувьд хэрэгжих боломжгүй заалт юм.**
- **"Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль"**-д иргэний өмчийн газрыг дайчлан авах тухай заалт нь иргэний хөрөнгийг үнэгүйдүүлэх зохицуулалт гэж үзэж байна. Хуулийн 34.3-т дайчлан авсан газрыг эргүүлэн өгөх боломжгүй болсон тохиолдолд өмчлөгчид нь уг газрын үнэ, хохирлыг тухайн үеийн зах зээлийн ханшаар тооцож нөхөн төлөх буюу дайчлан авсан газраас төлөв байдал, чанарын хувьд дордохооргүй өөр газрыг өмчлүүлж учирсан хохирлыг нөхөн төлнө.

АСУУДАЛ ҮҮСЭХЭД НӨЛӨӨЛЖ БАЙГАА ХҮЧИН ЗҮЙЛС:

Соёл, уламжлал:

- Өрхийн тэргүүний нэр дээр өмч хөрөнгө бүртгэгдэх ёстой гэсэн уламжлалт хандлага хүчтэй байгаагаас гадна ялангуяа хөдөөд хүүгээ гэрлүүлж буй эцэг эхчүүд залуу хосын амьдрах сууцыг нь бэлтгэх уламжлал, өмч хөрөнгийн эзэмшилд жендэрийн ялгаа гарахад нөлөөлдөг байна. Түүнчлэн Монгол Улсад эмэгтэйчүүдийн бизнес эрхлэлт нь гэр бүл, түүний дотор нөхөр, хамтран амьдрагчаасаа ихэвчлэн хамааралтай байгаа нь бүлгийн ярилцлагаас харагджээ. Жендэрийн хэм хэмжээ өөрчлөгдөөгүй тохиолдолд зөвхөн эмэгтэйчүүдийн бизнес эрхлэлтийг дэмжихэд эрэгтэйчүүдийн оролцоо бага байгаа үед гэр бүлийн харилцаанд сөргөөр нөлөөлсөн туршлага бий тул өрхийн үйлдвэрлэл, бичил үйлдвэрлэлийн түвшинд бизнесийн өмчлөл, үйл ажиллагаанд нэг гэр бүлийн эмэгтэй эрэгтэйчүүдийг хамтран оролцохыг дэмжих нь зүйтэй гэж судлаачид үзжээ (Жендэрийн үндэсний хороо, 2019, х.30)
- Хэдийгээр эрх зүйн орчин бүрдэж, олон нийтийн ойлголт сайжирч байгаа ч хүчирхийллийг тэвчих хандлага эмэгтэйчүүдийн дунд байсаар байна. Энэ хандлага хөдөөд илүү, мөн эмэгтэйчүүдийн нас ахих тусам ихэсч, харин боловсролын түвшин дээшлэх тусам багасч байгааг судалгаа харуулжээ (Жендэрийн үндэсний хороо, 2019, х.58)
- Эмэгтэйчүүд орон нутаг, олон нийтийн ажилд оролцож чадахгүй байгаа нь гэр орны ажил болон хүүхэд, ахмад настнаа асрах ажилд анхаардагтай холбоотой байна. Үүн дээр нэмээд жолоо барих чадваргүй байх, эмэгтэйчүүдийн оролцоог дэмждэггүй нийгмийн хэвшмэл хандлага, түүнчлэн цагийн боломж, амьдарч байгаа зай зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна.

ХӨДӨӨГИЙН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХИЙГ ХАНГАХТАЙ ХОЛБООТОЙГООР 2015-2019 ОНД МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

МУ-ын Засгийн газрын түвшинд хэрэгжүүлсэн үйл ажиллагааг нэгд бодлогын орчныг сайжруулах чиглэлээр, хоёрт төсөв, гуравт сургалт, дөрөвт судалгаа гэсэн ангиллаар төрийн холбогдох байгууллагуудаас ирүүлсэн мэдээллийг нэгтгэв. Нийт нэр бүхий 11 газарт мэдээлэл хүссэн албан тоотын хүргүүлсэн ба үүнээс 10 газар нь хариу ирүүлсэн. Хүний эрхийн үндэсний комисс ямар нэгэн хариу өгөөгүй байна.

	Нэрс	Бодлогын орчинг сайжруулах чиглэлээр	Төсөв	Сургалт	Судалгаа
1	ХЗДХЯ, МУ-д ГХУСАЗЗ	✗	✗	✗	✗
2	ХНХЯ	✓	✗	✗	✗
3	ЭМЯ	✗	✗	✗	✗
4	БСШУСЯ	✗	✗	✗	✗
5	ШЕЗ	✗	✗	✗	✗
6	УЕПГ	✗	✗	✗	✗
7	ЦЕГ	✗	✗	✗	✗
8	ГБХЗХГ	✗	✗	✗	✗
9	ХБХЕГ	✗	✗	✗	✗
10	ЖҮХ	✗	✗	✗	✗
11	ХЭҮК	Мэдээлэл ирүүлээгүй			

✓ Тийм ✗ Үгүй



БАРИМТЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН:

Малчин эмэгтэйчүүдэд тулгамдаж буй асуудал

 <p>Суурь шалтгаан</p>	 <p>Суурь шалтгаанаас үүссэн үр дагавар</p>	 <p>Өнөөгийн тулгамдаж буй асуудал</p>	 <p>Цаашид гүнзгийрүүлэн судлах асуултууд</p>
<p>Нийгэм дэх жендэрийн хэвшмэл ойлголт</p>	<ul style="list-style-type: none"> • Өрхийн болон орон нутгийн түвшинд шийдвэр гаргахад оролцох оролцоо хангалтгүй • Эмэгтэй хүний хөрөнгө эзэмших эрх нь хязгаарлагдмал • Хөдөлмөрийн хуваарилалтад нөлөөлдөг бөгөөд эмэгтэйчүүдийн ажлын ачаалал их • Малчдын эдийн засгийн чадавч сайжрахгүй хэвээр байна • Эрүүл мэнд боловсролын үйлчилгээг хүргэх хүний нөөцийн дутагдал • Малчин эмэгтэйчүүдийн хэрэгцээ, шаардлага тодорхойгүй • Түүнийг бодлогын баримт бичигт хэрхэн тусгах нь тодорхой бус • Эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ ялгаатай байдаг • Хур тунадас багасах, усны нөөц хомсдох, хуурайшилт, тоосжилт, цөлжилт, ургамлын төрөл, гарц буурах. Ингэснээр мал хариулахад илүү цаг зарцуулах, бэлчээрийн маргаан гарах, малчин иргэдийн дунд үл ойлголцол бий болох зэрэг асуудлууд үүсдэг 	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэнд, боловсролын үйлчилгээг чанартай, хүртээмжтэй авч чадахгүй байна • Ядуурал ба эмзэг байдал • Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн зөрчил • Хөгжлийн үйл явцад оролцох оролцоо бага 	<ul style="list-style-type: none"> • Малчдын эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлж, ядуурлыг бууруулах, ядуурахаас хамгаалахын тулд тэдэнд тохирсон ямар зохицуулалт байх ёстой вэ? • Өнөөгийн төрийн үйл ажиллагаа, үйлчилгээг (эрүүл мэнд, боловсрол) төлөвлөх болон хүргэх тогтолцоог малчдын амьдралын онцлогт тохируулахын тулд юуг, хэрхэн өөрчлөх хэрэгтэй вэ? • Малчдын орон нутгийнхаа шийдвэр гаргах үйл явцад оролцоход тулгамдаж байгаа идэвх оролцоо бага байдаг, гэр орны ажлаа зохицуулах боломжгүй байдаг, жолоо барих чадваргүй, гэх мэт асуудлыг хэрхэн шийдвэрлэж, тэдний оролцоог хэрхэн нэмэгдүүлж болох вэ?
<p>Бодлогын зохицуулалт</p>			
<p>Судалгаа, шинжилгээ</p>			
<p>Газар зүйн байршил</p>			
<p>Уул уурхайгаас үүдсэн байгаль орчны нөлөөлөл</p>			

2

ЧАНАРЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Баримтын судалгааны үр дүнд үндэслэн бид чанарын судалгааг дараах асуудлуудыг тодорхойлох зорилгоор хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Малчдын эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлж, ядуурлыг бууруулах, ядуурахаас хамгаалахын тулд тэдэнд тохирсон ямар зохицуулалт байх ёстой вэ?
- Өнөөгийн төрийн үйл ажиллагаа, үйлчилгээг (эрүүл мэнд, боловсрол) төлөвлөх болон хүргэх тогтолцоог малчдын амьдралын онцлогт тохируулахын тулд юуг, хэрхэн өөрчлөх хэрэгтэй вэ?
- Малчдын орон нутгийнхаа шийдвэр гаргах үйл явцад оролцоход тулгамдаж байгаа асуудлыг хэрхэн шийдвэрлэж, тэдний оролцоог хэрхэн нэмэгдүүлж болох вэ?

Чанарын судалгаанд малчин эмэгтэйчүүд, сумын болон багийн засаг даргаар ажиллаж байсан төлөөлөгчид, малчид болон хөдөө орон нутгийн хөгжлийн асуудлаар судалгааны ажил хийдэг экспертүүд оролцсон ба нийт 3 фокус бүлгийн ярилцлага, 12 ганцаарчилсан ярилцлага зохион байгуулсан.

Малчдын эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэхэд тулгамдаж буй асуудал, түүний шийдэл:

- Судалгаанд оролцогчдын мэдээллээс харахад малчдын онцлог, хэрэгцээнд нийцсэн, тэдний оролцоотой ядуурлыг бууруулах, ядууралд өртөхөөс урьдчилан сэргийлэх тусгайлсан бодлого, арга хэмжээ хэрэгждэггүй бөгөөд түүнд зориулан төсөвлөсөн санхүүжилт байхгүй байна.
- Төрийн бодлого, арга хэмжээнд малчдыг нэг цул гэж үзэхээс гадна халамжлах шаардлагатай, боловсрол багатай хүмүүс гэдэг байдлаар хандах, нүүдэлчин мал аж ахуйг хувийн өмч гэж үзэх хэвшмэл ойлголт бий болсон байна. Гэтэл малчдын амьдралын чанарт амьдарч байгаа орон нутаг, малын хэмжээ, ам бүлийн тоо, амьжиргааны түвшин гэх мэт олон хүчин зүйлс нөлөөлж байна.
- Түүнчлэн малчин эмэгтэйчүүдийн мэдээллээр хангагдах эрх, мэдээллийг амьдралын чанараа сайжруулахад ашиглах эрх талаас авч үзвэл малчин эмэгтэйчүүд мэдээллийн хүртээмжгүй байдлаас үүдэн ядууралд өртөж байна. Малчид мэдээлэл хүлээж авах, авсан мэдээллээ боловсруулах, ашиглах ур чадвар сул байна. Мөн малчдад хүрч байгаа мэдээллийн чанар, хугацаанд анхаарах шаардлагатай бөгөөд малчин эмэгтэйчүүд ихэвчлэн албан бус эх үүсвэрээс мэдээлэл авдаг нь боломжоос хоцрох, зайлшгүй авах үйлчилгээгээ авч чадахгүй үлдэх, эсвэл чанаргүй үйлчилгээ авах нөхцөл болж байна.
- Уул уурхайн бизнесээс болоод бэлчээрийн талбай хашигдаж байгаа нь усандаа хүрэх, сум орон нутаг хүрч төрийн үйлчилгээ авахад өмнөхөөс илүү зардал гаргахад хүргэдэг байна. Энэ нь эдийн засгийн хувьд төлөвлөгдөөгүй зардал үүсэх эрсдэлийг бий болгож байна.
- Малчид жилийн турш зөвхөн хоёр удаа л бэлэн мөнгөтэй болдог (хавар ноолуур худалдах, намар мал худалдах) бөгөөд энэ нь өрхийн болоод эмэгтэйчүүдийн наад захын хэрэгцээнд тэр бүр хүрэлцдэггүй гэж судалгаанд оролцогчид хариулжээ.

Эрүүл мэнд, боловсрол зэрэг нийгмийн үйлчилгээний хүртээмж, чанар:

- Малчин эмэгтэйчүүд эрүүл мэндийн хангалттай үйлчилгээ авч чадахгүй байгаагийн зэрэгцээ наад захын эрүүл мэндийн үйлчилгээ ч тэдэнд хүртээмжгүй байна. Эрүүл мэндийн аливаа эрсдэл тохиолдоход гэрийн орчинд таамгаар эм хэрэглэж намжаах явдал түгээмэл байгаа бөгөөд урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах, оношлуулах, өвчин хүндрэхээс өмнө эмчлүүлэх явдал малчдын дунд хангалтгүй байна. Үүнд нүүдлийн мал аж ахуй, өрхийн өмч амьжиргааны эх үүсвэрээ хамгаалалтгүй удаан орхих боломжгүй байдал нөлөөлж байна. Өвчин хүндэрсэн үед албан ёсны эмнэлгийн үйлчилгээ авдаг нь угаас ядуу, хомс өрхийн эдийн засгийг улам хүндрүүлэх нөлөөтэй нь нийтлэг байна.
- Малчин эмэгтэйчүүдэд нөхөн үржихүй, гэр бүл төлөвлөлтийн талаар шаардлагатай мэдлэг олж авах, тэдэнд энэ төрлийн мэдээлэл хүргэх үйлчилгээ хомс хэвээр байна. Хөдөөгийн эмэгтэйчүүд өөрсдийн эрүүл мэнд төдийгүй өвчтөн асрах, эмийн зохистой хэрэглээний талаар мэдлэгтэй байх шаардлага байгаа ч энэ үйлчилгээг төрөөс авч чадахгүй байна. Хөдөө орон нутгийн эмийн сангийн үйлчилгээ энэ хэрэгцээг ашиглан өвчин намдаах чиглэлийн төрөл бүрийн эмийг эмчийн жоргүй олгож байгааг үргэлжлүүлэн судлах шаардлагатай. Энэ талаар одоогоор судалгаа байхгүй байна.
- МУ-ын хувьд малчин эмэгтэйчүүд% эрэгтэй малчдаас суурь боловсрол эзэмшсэнээрээ харьцангуй илүү байна. Харамсалтай нь малчдад зориулсан амьдрах ухааны болон бусад сургалт байхгүй байна. Хөдөөгийн эмэгтэйчүүдэд албан бус амьдрах ухааны, нийгмийн хөгжлийн ололт амжилтаас шинэ мэдлэг, ур чадвар эзэмших, хөдөлмөр хөнгөвчилсөн, амьдралын чанараа сайжруулах шинэ техник технологи нэвтрүүлэх түүнд суралцах, хамтын бүлэг нөхөрлөл байгуулах арга зүйд суралцах хэрэгцээ маш их байна. Нүүдлийн соёл, олон цагийн хөдөлмөр эрхэлдэг болон тэдний онцлог хэрэгцээнд нь тохирсон сургалтын арга хэлбэр бий болгох зайлшгүй шаардлагатай байна.
- Малчин эмэгтэйчүүд хэдийгээр орлого хомс ч маш их эрсдэл үүрч, асар их хичээл зүтгэлээр хүүхдээ их дээд сургуульд сургаж байгаа ч эргээд дээд сургууль төгссөн хүүхэд нь эзэмшсэн мэргэжлээрээ бие дааж амьдарч чадахгүй байгааг олон малчид ярьж байна. Иймд малчин гэр бүлийн албан болон албан бус боловсролоор дамжуулж чанартай амьдрах, боловсролын хүртээмжийн асуудлыг судлах шаардлагатай.

Малчдын шийдвэр гаргах үйл явцад оролцох оролцоо:

- МУ-д хөгжлийн аливаа асуудлаар шийдвэр гаргах үйл явцад иргэдийг оролцуулах нь учир дутагдалтай, бүрэн хэрэгжээгүй байна. Монголчууд өргөн уудам нутагтаа тархай бутархай суурьшин, нүүдэлчин амьдралтай, хоёр нарны хооронд хөдөлмөрлөж амьдралаа авч яваа эмэгтэйчүүдийн оролцоог хангах гэдэг бол тусгай хөтөлбөрт ажил юм.
- Судалгаанд оролцсон эмэгтэйчүүд дунд орон нутгийн ИТХ-д оролцдог ч, энэ нь тогтмол бус байна. Шийдвэр гаргах үйл явцад оролцох оролцоо хязгаарлагдмал байгааг малчин эмэгтэйчүүд ахуйн ажил ихтэй, хүүхэд харах хүнгүй, хурлаар хэрэгтэй зүйл хэлэлцэж, малчдыг сонсохоос илүүтэйгээр олон цагаар мэдээлэл сонсох болдог учир оролцохыг хүсдэггүй, олон нийтийн дунд үзэл бодлоо илэрхийлэх ур чадвар дутдаг зэрэг шалтгаантай холбон тайлбарлаж байна.
- Малчин иргэд төрийн шийдвэр гаргах үйл явцад өөрсдийн дуу хоолойг хүргэх хүсэлтэй, бөгөөд үүнийг ойрхон амьдардаг малчдын дунд бүлэг үүсгэн түүнийгээ ээлжлэн удирдах, малчдыг ирүүлэхээс илүү малчдад хүрч очих (утас, цахим гэх мэт арга байж болно), ИТХ-д малчдын квотыг тусгайлан заах зэрэг шийдэл байж болно гэж судалгаанд оролцогчид үзэж байна.


ДҮГНЭЛТ:

- **Хот хөдөөгийн хүн амын амьжиргааны түвшинг харьцуулахад хөдөө орон нутагт ядуурал илүү их байна.** Монгол Улсын нийт хүн амд хөдөөгийн хүн амын эзлэх хувь бага ч хөдөөд ядуурлын түвшин 10.1 пунктээр өссөн байна. Ядуурал сумдын түвшинд, түүний дотор малчдын дундах ядуурал өндөр, мөн эмзэг байдалтай байна.
- **Хөдөөгийн эмэгтэйчүүдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилт туйлын эмзэг байдалд байна.** Хөдөөгийн эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг үндэсний аж үйлдвэрийн түүхий эд бэлтгэгч, стратегийн хүнс үйлдвэрлэгчийн хэмжээнд авч үздэггүй (агаарын болон хөрсний бохирдол, ундны ус, нийгмийн аюулгүй байдал баталгаажуулаагүй, гэр бүлийн хүчирхийлэл, хэт олон цагийн үнэлгээгүйгүй хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэндийн тусламж хамгаалал түүний дотор нөхөн үржихүйн эрүүл мэнд болон бэлгийн дарамт, хүчирхийлэл гэх мэт).
- **Хөдөөгийн эмэгтэйчүүдийн хөгжлийн аливаа асуудлаар шийдвэр гаргахад оролцох оролцоог баталгаажуулаагүй.** Нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг 18 цагийн хөдөлмөр, өргөн уудам газар нутаг, тархай бутархай засаг захиргааны нэгжийн хуваарилалтын үндэсний онцлогтоо нийцсэн, засаглалд эмэгтэйчүүдийн оролцох боломж, сонголтыг дэмжсэн эрх зүйн зохицуулалт, тогтолцоо байхгүй байна.
- **Хөдөөгийн эмэгтэйчүүд, гэр бүлийн гишүүдийн чанартай боловсрол эзэмших түүний үр дүнгээр чанартай амьдрах боломж хангалтгүй.** Сурч хөгжих, насан туршийн боловсрол олж чадавхжих замаар өрхийн бизнесээ хөгжүүлэх, үр хүүхдээ чанартай боловсрол эзэмшүүлэх боломж, сонголтыг дэмжсэн зохицуулалт байхгүйгээс боловсрол эзэмших эрхээ эдлэх, түүгээр чанартай амьдрах боломж тун бага байна.
- **Хөдөөгийн эмэгтэйчүүдийн хөгжилд оруулах хувь нэмэр, хөгжлөөс хүртэх хувь маш бага байна.** Амьдралын чанарын ялгаатай байдал нь хөгжлөөс хувь хүртэх хэмжээ, чанар, нийгмийн хөгжилд тэдний оруулах хувь нэмэр “халамжлуулах статус”-аар үнэлэгддэг. Энэ нь эмзэг бүлгийн эмэгтэйчүүдэд, үндэсний цөөнхөд, ахмадууд, өрх толгойсон эмэгтэйчүүдэд хамгийн хүндээр тусдаг бөгөөд тэднийг дэмжих тусгайлсан бодлого, арга хэмжээ, төсөв хүртээмжгүй байна. Үзэл бодлоо илэрхийлэх, эрх ашгаа хамгаалах оролдлого хийж буй хөдөөгийн эмэгтэй хүний эрх хамгаалагчид, активистууд эрсдэлд орох магадлал өндөр, төрийн болон нийгмийн хамгаалалт байхгүй байна.



ЗӨВЛӨМЖ:

- Малчин эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн онцлог, уламжлалт соёлын онцлогийн давуу тал нь олон ажлыг зэрэгцүүлэн амжуулах уян хатан нөхцөл боломжид тохируулан малын түүхий эдээ анхан шатны боловсруулалт хийх, зарим эцсийн бүтээгдэхүүн болгох ур чадварт сургах тусгай бодлого хөтөлбөр хэрэгжүүлэх;
- Сум хөгжүүлэх сан, ЖДҮ-ийн сан зэрэг одоогийн байгаа сангуудын 20 хүртэл хувийг малчин эмэгтэйчүүдийг дэмжих зорилгоор квот тусгах;
- Малчин бүр тамгатай өрхийн үйлдвэрлэгч тул үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний эцсийн хариуцлагыг хөөн тогтоох тогтолцоог бий болгох;
- Малчдын нүүдэллэн амьдрах онцлог, тархай бутархай байршил, малчин эмэгтэйчүүдийн хоёр нарны хоорондох хөдөлмөрийн цагийн хуваарь, ажлын нөхцөлд тохирсон мэдээлэл хүргэх тогтолцоо, арга механизм бий болгох. Төр, ОУБ, ТББ-аас малчин эмэгтэйчүүдийн уулзалт зөвлөгөөн сургалтыг зохион байгуулахдаа эрхэд суурилсан хандлагаар хандаж зорилтот бүлгийн малчин эмэгтэйчүүдийг татан оролцуулах арга барил, хандлагадаа эрс шинэчлэл хийх;
- Нийгмийн болон эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийх эрх зүйн орчныг бий болгох;
- Нүүдлийн мал аж ахуй эрхэлж хөдөлгөөнтэй/суурин бус/ хүн амд тохирсон явуулын үйлчилгээний тогтолцоог бий болгох;
- Хамгийн бага нөөцтэй гүний цэвэр усаа хайрлах, хамгаалах арга хэмжээ авах; гүний усаар олборлолт явуулдаг алттай шороо угаадаг технологийг зогсоох;
- Байгалийн гамшиг, уур амьсгалын өөрчлөлт, отор нүүдэл, уул уурхайн нөлөөллийн бүсийн малчин эмэгтэйчүүдэд тулгарч байгаа гэр бүл, нийгэм, улс төрийн асуудлыг судлагдахуун болгон авч үзэж шийдвэр гаргагчид, судлаачдын анхааралд хүргэх, асуудлыг дэвшүүлэх;
- Орон нутгийн эдийн засагт үр өгөөжгүй, байгаль дэлхий сүйтгэж усны хомсдол үүсгэж байгаа уул уурхайгаас татгалзахад малчид иргэд оролцох.



**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ:
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХ**

ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ:

- Үндэсний статистикийн хорооны мэдээллийн сангаас харахад 2019 оны 4-р улирлын байдлаар нийт ажиллах хүч болох 1,293,579 мянган хүнээс 594,368 нь эмэгтэй хүн байна. Хөдөлмөр эрхэлж буй эмэгтэй хүн 49.7 хувь нь байна. Мөн ажилгүйдлийн түвшиний 6.6 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Дундаж цалин улсын хэмжээнд 2019 оны 3-р улирлын байдлаар 1,287,600₮ байгаа ба хүйсээр харьцуулж үзэхэд эмэгтэйчүүдийн хувьд 1,040,200₮ буюу 19.3%-аар доогуур байна (Үндэсний статистикийн хороо, 2020).
- Ажиллах хүчний оролцооны хувьд 2014, 2015, 2016 оны дүнгээс харахад эрэгтэйчүүд 68.6, 68.1, 67.3 байхад эмэгтэйчүүд 56.2, 55.4, 54.2 буюу оролцоо байнга доогуур байгаа төдийгүй буурах хандлагатай байна. 2016 оны мэдээллээс харахад эмэгтэйчүүд эдийн засгийн хямралд илүү өртсөн нь ажиглагдаж байна. Тэдний ажиллах хүчний оролцооны түвшин 2010 оноос хойш 2 хувиар буурч, 2016 онд 54.2 хувьд хүрчээ. (ҮСХ, Ажиллах хүчний оролцооны түвшин, 2004-2016, 2016)
- “Жижиг, дунд үйлдвэр дэх хөдөлмөрлөх эрхийн зарим асуудал: худалдаа үйлчилгээ, ноос ноолуурын салбар” судалгааны тайланд (2017) дурдсанаар хөдөлмөрийн гэрээний нэг хувийг ажилтанд өгөх байдал 61,1% байна (Худалдааны салбар 56,7%, ноос ноолуурын салбар 70,9%). Уг үр дүнг хүйсээр ангилж үзээгүй боловч тус судалгаанд оролцогчдын 27% нь эрэгтэй, 73% нь эмэгтэй байжээ. Нийт оролцогчдын 14%-д нь хөдөлмөрийн гэрээ байгуулахаас өмнө хэсэг хугацаанд туршилтын байдлаар ажиллуулдаг дүр зураг байна. Туршилтын хугацаанд цалин олгохгүй байх тохиолдол ч байна (Хүний эрхийн үндэсний комисс, 2017, хх.66-68). Түүнчлэн “удирдлагын зүгээс үзүүлдэг ажлын байран дахь дарамт” бодитой оршин байгаа төдийгүй, хүйсийн хувьд эмэгтэйчүүд, насны хувьд 18-30 насны залуучууд мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэд илүү өртөж байгааг уг судалгааны үр дүн харуулжээ (х.71).
- Хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн асардаг шалтгаанаар эдийн засгийн идэвхгүй байгаа эмэгтэй 2015 онд 87 мянга гаруй байсан бол 2018 онд 110 мянга орчим болж нэмэгдээд байна (“Бүлгийн эрхийн нөхцөл байдал” НҮБ-ын ХЭХ-нд илгээсэн 3 дахь тайлан, 2019)
- Хөдөлмөр эрхэлж байгаа эмэгтэйг эрэгтэйчүүдтэй харьцуулахад гэрийн ажил, гэр бүлийн гишүүдээ асрах үүргийг илүү үүрч байна. Ийм тэгш бус байдал нь тус улсын эдийн засгийн өсөлт, нийгмийн хөгжил, бүтээмжид нөлөөлж, хугацаа өнгөрөх тутам улам даамжирч байна. (Олон улсын хөдөлмөрийн байгууллага, 2019)
- Хувиараа, худалдаа наймаа хийдэг 100 эмэгтэйн дунд хийсэн судалгаагаар 31.5% нь хөдөлмөрийн гэрээгүй, 31.4% нь ажилд орохдоо бичиг баримт, хөрөнгийн барьцаа өгсөн гэж хариулсан нь Олон улсын хөдөлмөрийн байгууллагын тодорхойлсон албадан хөдөлмөрийн хэлбэр байгааг харуулж байна (Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих холбоо, 2019a; Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих холбоо, 2019b)
- Эмэгтэйчүүд эдийн засгийн боломжоос тэгш хүртэж чадахгүй байна. Үндэсний статистикийн хорооноос гаргасан хамгийн өндөр болон хамгийн бага цалин хөлстэй тус бүр 5 салбарын ажилчдыг хүйсээр авч үзэхэд ашиг орлоготой салбарт эрэгтэйчүүд 70% орчим оролцоотой байхад хамгийн бага цалин хөлстэй салбарт эмэгтэйчүүд 70% орчмыг эзэлж байна. (НҮБ-ын ХЭХ-нд илгээсэн Бүлгийн эрхийн нөхцөл байдал илтгэл)

- Ажил олгогч нь адил хөдөлмөр эрхэлж байгаа эрэгтэй, эмэгтэй ажилтанд адил цалин хөлс олгох, хууль эрх зүйн заалтыг ёсчлон дагаж мөрдөх үүрэгтэй. Харин, ижил үнэлэмжтэй ажилд ижил цалин хөлс олгох тухай ойлголт хуулинд тусгагдаагүй байна. (Олон улсын хөдөлмөрийн байгууллага, 2019, х.29)
- Үнэлгээгүй ажилд зарцуулж буй цаг буурахгүй байна. Дундаж үзүүлэлт 2011 онд 4.8-аас 2015 онд 4.3 болж буурсан буюу маш хангалтгүй байна. (ҮСХ, Цаг ашиглалтын судалгаа, 2015). Залуу эмэгтэйчүүд хөдөлмөрийн зах зээлд эхэлж болон эргэн ороход илүү саад бэрхшээлтэй тулгарч байна. Залуу эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин залуу эрэгтэйчүүдийнхээс өндөр байгаа бөгөөд энэ нь жилээс жилд өсөх хандлагатай байна. Залуу эмэгтэйчүүдийн цалин хөлс залуу эрэгтэйчүүдийнхээс 1.4 дахин бага, харин цалин хөлсгүй ажилд эмэгтэйчүүд зонхилж байна. (НҮБХАС, 2016)
- Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй 103.6 мянган иргэн буюу нийт хүн амын 3.3%-ийг эзэлж байгаагийн 46.3 мянга буюу 44.6% нь эмэгтэйчүүд байна. (Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Жайка олон улсын хамтын ажиллагааны байгууллага, 2017) Хөгжлийн бэрхшээлтэй хөдөлмөрийн насныхны 19% нь хөдөлмөр эрхэлж байна.
- Монгол Улсын хөдөлмөрийн хяналтын байцаагчийн түвшин 2017 оны 5 сарын байдлаар 0.826 байсан нь 10,000 ажилтан тутамд хөдөлмөрийн хяналтын найман байцаагч ногдож байна гэсэн үг юм. Хүний нөөцийн хувьд ийм дутагдалтай байгаагаас ажлын байранд тавих хяналт сул, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаггүй, гомдол, саналыг шийдвэрлэхгүй өнгөрдөг. (Олон улсын хөдөлмөрийн байгууллага, 2019, х.38)
- Монгол Улс тогтвортой хөгжил, жендэрийн тэгш байдал, бүрэн, бүтээмжтэй хөдөлмөр эрхлэлт зэрэг зохистой хөдөлмөрийн асуудлаарх бодлого хөтөлбөр хангалттай сайн боловч хэрэгжилт нь хангалтгүй байна. Энэ нь улс төрийн хүсэл эрмэлзэл, засаглалын чадавч сул, хүйсээр задалсан тоо мэдээлэлд жендэрийн дүн шинжилгээ хийж, бодлого төлөвлөлт, төсвийн хуваарилалт зэрэгт хэрхэн ашиглах мэдлэг, туршлага дутмаг байгаатай холбоотой. (Олон улсын хөдөлмөрийн байгууллага, 2019, х.57)

БОДЛОГЫН ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ: ДЭМЖИЖ БАЙГАА ЗОХИЦУУЛАЛТ

- Монгол Улсын төрөөс хэрэгжүүлж буй үндэсний бодлогын баримт бичигт **эмзэг бүлгийн эмэгтэйчүүд ялангуяа ахмад настай, амьжиргааны түвшингээс доогуур орлоготой** хүний хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудлыг дараах байдлаар тусгажээ. Үүнд **"Монгол Улсын Засгийн газрын 2016–2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"**-ийн 3.3.26-д ахмад настны асаргаа үйлчилгээ, сэргээн засах болон сувилахуйн үйлчилгээг өргөжүүлж, хувийн хэвшлийн асрамжийн газар байгуулахыг дэмжинэ. Мөн **"Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого (2016–2025)"**-ын 4.5.1-т байнгын ажлын байрыг нэмэгдүүлэх, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрийн чадамжид тохирсон ажлын байр бий болгохыг урамшуулах; 4.5.5. Эмэгтэйчүүд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлнэ гэжээ.
- Хүүхдийн эрх, хамгааллын тухай хуулийн зорилтыг хангах үүднээс Засгийн газраас хэд хэдэн үндэсний бодлогын баримт бичигт **хүүхэд асрах үйлчилгээний талаарх зохицуулалтыг** бий болгосон. Тухайлбал, **"Монгол Улсын Засгийн газрын 2016–2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"**-т боловсролын үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, амьдралд нийцтэй болгоно. Хот суурин газарт хүүхэд бүр цэцэрлэгт суралцах боломжтой болж, сурагчид гэр сургуулийнхаа хооронд нийтийн тээвэрт үнэгүй зорчиж, сургууль 3 ээлжгүй болно. Хөдөөд малчны хүүхэд 6-8 насандаа сонголттойгоор суралцах боломжтой болж, дотуур байрны орчин нөхцөлийг сайжруулахын зэрэгцээ **"Хүүхэд бүр цэцэрлэгт"** хөтөлбөрийг хэрэгжүүлж хот суурин газарт хүүхэд бүр цэцэрлэгт хамрагдах боломжийг бий болгоно гээд **"Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"**-ийн зорилтод Хүүхэд бүрийг стандартын шаардлага хангасан сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулж, монгол хэл, сэтгэлгээний үндсийг эзэмшүүлэхийг дэвшүүлсэн. Түүнчлэн сургуулийн өмнөх

боловсролын тогтолцооны төрөл хэлбэрийг өргөтгөж, хүртээмж, чанарыг сайжруулан сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд сургуулийн өмнөх насны нийт хүүхдийн 70 хувийг хамруулах нөхцөл бүрдүүлэхийг зорин ажиллахаа тунхагласан байхад **"Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр"**-т Эмэгтэйчүүдэд хөдөлмөр эрхлэхийн зэрэгцээ хүүхэд төрүүлэх, өсгөн бойжуулах боломжийг сайжруулж, жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй, өрх толгойлсон, ганц бие эмэгтэйчүүдийг шалтгаангүйгээр ажлаас халах, цалин хөлсийг бууруулах явдлаас сэргийлсэн эрх зүйн механизмыг хүчтэй болгохоор шинэчилсэн хөтөлбөрт тусгасан чухал алхам болсон.

- Монгол Улсын Засгийн газраас **бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг бодлогын орчинд хэрхэн дэмжин ажиллахаа Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр**, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрт тодорхой заалтыг тусгасан байна. Үүнд: **"Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"**-т Эрх бүхий байгууллагуудаас үндэсний аж ахуйн нэгжүүдэд тавигдсан татварын актын хүү, торгууль, алданги, үндсэн татварын нөхөн төлбөр төлөх хугацааг сунгах, хаалгасан дансыг нь нээх зэргээр бизнес эрхлэгчдээ дэмжих (1.15), 5-аас доошгүй жил тасралтгүй үйл ажиллагаа эрхэлж, байнгын ажлын байр шинээр бий болгосон хөнгөн, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлээр дэмжих (1.17) зохицуулалттай байхад **"Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр"**-ийн 4.1.6.-д жижиг, дунд үйлдвэрийн менежментийн үйл ажиллагааг дэмжих, өрсөлдөх чадварыг бэхжүүлэх, гарааны бизнесийг хөгжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлэх; 4.5.2.-т дотоодын болон олон улсын бизнесийн боломжийг судлахад дэмжлэг үзүүлэх, мэдээллээр хангах, цахим худалдааг хөгжүүлэхэд анхаарахаар тусгасан.
- Монгол Улсын **"Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай"** хуулийн 5-р зүйлд заасны дагуу **"хүн амын амьжиргааны доод түвшин"**-г бүс нутгаар нь тодорхойлж эхэлсэн. Тус хуулийн 3 дугаар зүйлд хүн амын амьжиргааны доод түвшин гэж хэрэглээний доод хэмжээг мөнгөн хэлбэрээр илэрхийлснийг, хэрэглээний доод хэмжээ гэж хүний нэн тэргүүний зайлшгүй хэрэгцээг хангах хүнсний болон хүнсний бус хэрэглээний сагсаар тодорхойлсон бараа, үйлчилгээний шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоосон тоо, хэмжээг ойлгоно гэж заасан.
- Эмэгтэйчүүд ядууралд өртөх эрсдэл өндөр бөгөөд эмзэг бүлгийнхэн байдаг. Энэ ч үүднээс төрөөс дараах баримт бичигт ядууралд өртөж байгаа эмэгтэйчүүдийн эрхийг хангах, хамгаалах чиглэлээр хэд хэдэн тодорхой зохицуулалтыг тусгажээ. **"Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"**-ын 3.2.1.9-т Дотоодын хөдөлмөрийн зах зээлээ хамгаалж, иргэдээ ажлын байраар найдвартай хангах замаар ядуурлыг арилгах тууштай бодлого хэрэгжүүлнэ гээд **"Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"**-т Өрхийн орлого, зарлага, ядуурлын түвшинг тогтоох шалгуур үзүүлэлт, аргачлалыг сайжруулж, бодит амьдралд нийцүүлнэ. (3.3.2) Мөн **"Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого (2016-2025)"**-ын 4.5.6-т орон гэргүй, тэнэмэл, ажилгүй, ядуу хөдөлмөрийн чадвартай иргэдийг мэргэжлийн боловсролын сургалтад хамруулж, ажил хөдөлмөрт татан оролцуулж, байнгын ажил, орлоготой болгох;
- **"Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"**-д 1-р үе шат буюу 2016-2020 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт ядуурлыг бууруулах хөтөлбөр хэрэгжүүлж, нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлж, иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулан, хөдөлмөр эрхлэх нөхцөлийг бүрдүүлж, ядуурлын түвшинг 18 хувь хүртэл бууруулахыг зорьсон.
- "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль"-ийн /2016 он/ 4.1.1-д **"хөгжлийн бэрхшээлтэй хүн"** гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг ойлгоно гэж заажээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо нэмэгдэхийн хэрээр тэднийг хамгаалах ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдийн эрхийг хангах асуудал чухал байдаг. Энэ ч үүднээс МУ-ын Засгийн газраас дараах бодлогын баримт бичгүүдэд **хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэй** холбоотой зохицуулалтыг тусгажээ. **"Хөдөлмөрийн тухай хууль"**-д 25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулах, мөн хөгжлийн бэрхшээлтэй ажилтны ажлын цагийг богиносгох, ээлжийн амралтыг уртасгах, аж ахуйн

нэгжид хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулах квот тогтоох, биелүүлээгүй тохиолдолд торгууль төлбөр ногдуулах; **"Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль"**-д хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байрыг бий болгох чиглэлээр хөгжлийн бэрхшээлтэй иргэнд өөрт нь болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангасан ажил олгогчид санхүүгийн тусламж, урамшуулал олгох ажлыг зохион байгуулахаар тус тус тусгасан байдаг. Үндэсний бодлогын баримт бичиг болох **"Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр"**-ийн 3.1.8 олон хүүхэдтэй болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй, бага орлоготой, өрх толгойлсон эцэг (эх)-ийн амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн жендэрийн мэдрэмжтэй бодлогыг дэмжих; **"Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"**-д Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэх, нийгмийн үйлчилгээнд эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлэх. **"Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого (2016-2025)"**-т 4.3.8 олон хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй болон өрх толгойлсон эцэг, эх бүхий гэр бүл, ганц бие ахмад настанд дэмжлэг үзүүлж амьдралын түвшинг дээшлүүлэх; **"Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"**-д зорилтот бүлгийн залуучууд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх, чиг баримжаа олгох, зуучлах ажлыг тогтвортой хэрэгжүүлэхээр (5.3.15) тусгагджээ. МУ-ын Засгийн газраас **"Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр"**. 2017 онд батлан гаргажээ. Тус хөтөлбөрийг 2018-2020 онд хэрэгжүүлэх бөгөөд гол зорилго нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудлаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, тэднийг нийгмийн бүхий л харилцаанд бүрэн дүүрэн оролцох, ая тухтай амьдрах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх ойлголт, хандлагыг олон нийтэд төлөвшүүлэх, тэдэнд ээлтэй нийгмийн орчинг бүрдүүлэхэд чиглэсэн ба тус хөтөлбөр нь үндсэн 8 зорилтыг дэвшүүлжээ.

- **Малчин эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үүднээс дараах 3 хөтөлбөрт тусгайлан зохицуулсан байна.** "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-ын (5.2.11) малчин залуучуудад аж ахуй эрхлэх, мал маллах уламжлалт арга барил эзэмшүүлэх, амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн мэдлэг, чадвар, чадамжийг хөгжүүлэх, насан туршийн боловсролын үйл ажиллагааны чанар, хүртээмжийг сайжруулах; **"Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр"**-т (3.1.5) малчин, тариаланч өрхийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих бодлого, арга хэмжээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийж, холбогдох байгууллага, шийдвэр гаргагчид зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавих; мөн тус хөтөлбөрийн 3.2.7-т залуу малчин эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн нөхцөл байдалд жендэрийн судалгаа, дүн шинжилгээ хийж, үр дүнг үндэсний хэмжээнд хэлэлцүүлж, гарсан зөвлөмжийг бодлого, төлөвлөлтөд тусгуулах арга хэмжээ авах; **"Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого (2016-2025)"**-ын 4.2.4-т малчин өрх, хот айл, жижиг, дунд тариалан эрхлэгчдийн аж ахуй эрхлэлтийг дэмжин орчин үеийн техник, технологи, эрчим хүчээр хангаж, үйлдвэрлэл тогтвортой эрхлэх санхүү, эдийн засаг, эрх зүйн нөхцөлийг бүрдүүлэхээр тусгажээ.
- Монгол Улсын Үндсэн хуульд иргэн бүр **"ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй"** гэж үндсэн эрх эрх чөлөөг баталгаатай эдлэхийг хуульчилсан. Энэ ч үүднээс аливаа ажилд орох, хөдөлмөр эрхлэхэд ямар нэгэн хэлбэрийн ялгаварлан гадуурхалтад өртүүлэхгүй байхыг үндэсний баримт бичгүүдэд баталгаажуулсан байдаг. Тухайлбал, **"Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"**-д иргэдийг үндэс угсаа, шашин шүтлэг, үзэл бодлоор ялгаварлан гадуурхах, нутгархах үзлийг дэврээх, энэ шалтгаанаар хүний эрх, эрх чөлөөг зөрчих, улмаар үндэсний эв нэгдлийг сарниулж, дотоодын тогтворгүй байдалд хүргэж болох илрэлтэй хатуу тэмцэл хийнэ (3.3.3.4). **"Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр"**-ийн 3.1.1-т хөдөлмөрийн мөлжлөг, ажлын байран дахь ялгаварлан гадуурхалтын аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг үл тэвчих орчныг бүрдүүлэх асуудлыг төр, хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжийн хөдөлмөрийн дотоод журамд тусгуулан хэрэгжилтийг үнэлэх үзүүлэлтийг тодорхойлж нэвтрүүлэх. **"Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого (2016-2025)"**-т хүнийг үндэс угсаа, арьс өнгө, нас, хүйс, шашин шүтлэг, нутаг ус, нийгмийн болон эрүүл мэндийн байдал, бэлгийн чиг хандлагаар үл ялгаварлах (2.1.3) тусгажээ.

- Эмэгтэйчүүдийн эрхийг хангах зорилгоор Засгийн газраас эмэгтэйчүүдийн эрхлэхийг хориглосон ажлын байрны жагсаалтыг хүчингүй болгосон. Энэ нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэхэд саад учруулахын зэрэгцээ уул уурхайн салбарт ажиллах хүсэлт сонирхолтой эмэгтэйчүүдэд сөрөг зохицуулалт болж байлаа. Мөн Монгол Улсын Засгийн газраас **Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрт** улирлын шинжтэй ажил, хөдөлмөр эрхлэгч, гар аргаар ашигт малтмал олборлож байгаа иргэн, малчид болон нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийг эрсдэлээс хамгаалах үйл ажиллагаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийх (3.1.11) мөн **"Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"**-д Ил тод, хариуцлагатай уул уурхай, эрдэс баялгийн салбарыг хөгжүүлж, түүнээс олох орлогыг ойрын болон дунд хугацаанд эдийн засгийн бие даасан хөгжлийг хангах олон тулгуурт бүтцийг бий болгох, хүний хөгжлийг дэмжиж, боловсрол, эрүүл мэнд, нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд зарцуулахаар /3.2.1.3/ тусгажээ.
- Хөдөлмөр эрхлэлт болон тэтгэврийн хувьд эрх тэгш боломжийг хангахын тулд эмэгтэйчүүдийн тэтгэврийн насыг эрэгтэйчүүдийнхтэй адил болгож сунгах чиглэлээр үндэсний хууль тогтоомж болох 2012 оны **"Нийгмийн халамжийн тухай хууль"**-д зааснаар 60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэй нийгмийн халамжийн тэтгэвэр авах эрхтэй. Мөн хуулийн дагуу 18 хүртэлх насны 4-өөс дээш хүүхэдтэй 45-аас дээш насны өрх толгойлсон эхчүүд (эсвэл 50-иас дээш насны өрх толгойлсон эрэгтэйчүүд) нийгмийн халамжийн тэтгэвэрт хамрагдах боломжтой гэж тусгажээ. Мөн 1994 оны "Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль"-д Улсын Их Хурлаас 2018.02.02-ны өдөр Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн зүйл заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуулийн 61 дүгээр зүйлд зааснаар өндөр насны тэтгэврийг өөрийн хүсэлтээр эрэгтэй 60 нас, эмэгтэй 55 насандаа тогтоолгох даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих доод хугацааг 2038 он хүртэл жил бүр 3 сараар нэмэгдүүлэхээр өөрчилсөн.
- Бодлогын хувьд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хамгаалах, эмэгтэйчүүдийн ажилгүйдлийг бууруулахад доорх хөтөлбөрүүдэд тусгалаа олжээ.
- **"Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"**-т Хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөрийн зах зээл дэх тэгш оролцоог хангах, зохистой хөдөлмөр эрхлэлтийг өндөр түвшинд байлгах; мөн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, хөдөлмөрийн насны хүн амын эдийн засгийн идэвхтэй байдлыг 66 хувьд, ажилгүйдлийн түвшинг 6 хувд хүргэх амлалтыг тусгасан байхад **"Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого (2016-2025)"**-ын 4.5.2. хөдөлмөр эрхлэх хүсэлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэх, хувийн бизнес эрхлэхэд нь гарааны дэмжлэг үзүүлж зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар хөдөлмөрийн насны хүн амын эдийн засгийн идэвхтэй байдлыг 68 хувьд, ажилгүйдлийн түвшинг **4 хувьд хүргэх** анхаарахаар тусгайлан зохицуулжээ.
- **"Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр"**-ийн 2.2.6.3-т эмэгтэйчүүдэд хөдөлмөр эрхлэхийн зэрэгцээ хүүхэд төрүүлэх, өсгөн бойжуулах боломжийг сайжруулж, жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй, өрх толгойлсон, ганц бие эмэгтэйчүүдийг шалтгаангүйгээр ажлаас халах, цалин хөлсийг бууруулах явдлаас сэргийлсэн эрх зүйн механизмыг хүчтэй болгоно гэжээ. **"Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр"**-т гэр бүл төлөвлөлт нь эрүүл мэндийн зардлыг бууруулахаас гадна **эмэгтэйчүүдийн эрхийг дэмжиж, тэдний боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх** замаар гэр бүлийн сайн сайхан байдлыг дэмжихээр /4.2.3/ заасан.
- Ажлын байран дахь ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг дараах үндэсний бодлогод, тухайлбал, **"Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого (2016-2025)"** хүнийг үндэс угсаа, арьс өнгө, нас, хүйс, шашин шүтлэг, нутаг ус, нийгмийн болон эрүүл мэндийн байдал, бэлгийн чиг хандлагаар үл ялгаварлах; **"Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал баримт бичиг"**-ийн 2.1.2-т залуучууд нас, хүйс, арьс өнгө, боловсрол, иргэний харьяалал, үндэс угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, бэлгийн чиг хандлага, хүйсийн баримжаа, илэрхийлэл, оюун ухаан, бие махбодын чадвараар ялгаварлан гадуурхагдахаас ангид байх нөхцөлийг бүрдүүлж, тэдний эрхийг

хүндэтгэн хамгаалахад төрийн бодлогыг чиглүүлэх; мөн **"Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр"**-т Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц зэрэг Монгол улсын олон улсын гэрээнүүдийг гуйвалтгүй биелүүлж, энэ талаар НҮБ-ын зүгээс өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлыг Засгийн газар анхааралдаа авна. Түүнчлэн эмэгтэйчүүдийн эсрэг хүч хэрэглэх явдлыг устгах тухай тунхаглал зэрэг эмэгтэйчүүдийн эрхийг хөхиүлэн дэмжих талаар байгуулагдсан бүх хэлэлцээрт нэгдэх арга хэмжээ (2.2.6.б.) гэж онцгойлон тусгажээ.

- Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой хэвшмэл ойлголтыг бууруулах чиглэлээр **"Монгол Улсын жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль"**-д тусгагдсан байдаг. Хуулиас гадна хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор үндэсний хөтөлбөрийг боловсруулан гаргаж улмаар уг хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын чиглэл гардаг. Иймээс хэвшмэл ойлголтыг бууруулах, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх ажлыг хүрээнд: "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр"-ийн 6.3.5-т хэвлэл мэдээллийн байгууллага нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах, жендэрийн ялгаварлан гадуурхалт, хүчирхийллийг үл тэвчих, жендэрийн хэвшмэл ойлголт, хандлагыг арилгах чиглэлээр олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулна. **"Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр"**-т хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нөхөн үржихүйн эрүүл мэнд, жендэрт суурилсан хүчирхийллээс сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломжийн талаар сургалт зохион байгуулах, баррель үсгээр сурталчилгааны материал боловсруулж түгээх (3.4.1.5) **"Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого (2016-2025)"**- д бүх салбарт жендэрийн эрх тэгш байдлыг хангах /2.5.1/ зарчмыг тусгасан байдаг.

ЗӨРЧИЛДӨЖ БАЙГАА ЗОХИЦУУЛАЛТ:

1. УИХ-аас 17 бүлэг, 17 зүйлтэй **"Зөрчлийн тухай хууль"**-ийг 2017 онд баталсан ба уг хуулийн зорилго нь хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх юм. Зөрчлийн тухай хуулийн 10.16-р зүйлд **"Хөдөлмөрийн тухай хууль"** зөрчсөн тохиолдолд хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. Нэг нэгж нь 1000 төгрөгтэй тэнцэнэ. Энэ хуульд ажлын байран дахь ялгаварлан гадуурхалт гэдгийг тусгаагүй түүнчлэн зөрчилд тооцохгүй байна.
2. Хөдөлмөр эрхлэлтийн бодлого үйл ажиллагаа нь эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрхийг хангахад чиглэхгүй, өөр хоорондоо зөрүүтэй ойлголттой байна. ЭАБХУТухай Конвенцын 11 дүгээр зүйлийн 1,2,3-т заасан зохистой арга хэмжээг авах ёстой. Гэтэл Хөдөлмөрийн тухай хуулийн 7.2, ЖЭТБХТХ-ийн 11.1-д тусгасан ялгаварлан гадуурхахгүй байх төрийн үүргийг эрэгтэй, эмэгтэй хүйсийн аль нэгэнд давуу эрх олгохгүйгээр ижил бодлого баримтална хэмээн ХНХЯ үзэж байгаа нь ялангуяа нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд төрийн дэмжлэг, зохистой арга хэмжээ авагдахгүй байгаа үндсэн шалтгаан болж байна.

АСУУДАЛ ҮҮСЭХЭД НӨЛӨӨЛЖ БАЙГАА ХҮЧИН ЗҮЙЛС:

Соёл уламжлал:

- Эмэгтэйчүүд, бизнес эрхлэхэд тулгарч буй бэрхшээлийн талаар сүүлийн судалгаа шинжилгээнд гаргасан дүгнэлтүүдэд бизнесийн болон удирдлагын арга туршлага, мэдээлэл, танилын сүлжээ дутмаг, цагийн хомсдол их, эмэгтэйчүүд хувийн хэвшилд манлайлахад соёлын хэм хэмжээ садаа болж байгаагаас гадна барьцаа, үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө байхгүйгээс санхүүгийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байна гэж үзэж байна. (Жендэрийн үндэсний хороо, 2019)

Хууль эрх зүйн зохицуулалт:

- Хэдийгээр макро түвшний бодлогын үр дүнд эдийн засгийн үзүүлэлт сайжирсан ч хариуцан хэрэгжүүлэгч байгууллагын бодлогын төлөвлөлтийн алдаа, ажлын зохион байгуулалтгүй муугаас үндсэн чиглэлийн зарим арга хэмжээ зорилтот түвшиндээ хүрдэггүйг харж болно. (МУ-ын Эдийн засаг, нийгмийн 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт: Аудитын ерөнхий дүн, х.4, 2018)
- **“МУ-ын Тогтвортой хөгжлийн үндэсний баримт 2030”**-ын үе шат бүрд хүрсэн байх эдийн засгийн идэвх, ажилгүйдлийн түвшинг тодорхойлсон байхад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр гарсан 6 хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтэд эдийн засгийн идэвхийг нэмэгдүүлсэн, ажилгүйдэл буурсан үзүүлэлтийг тусгаагүй байгаа нь бодлогын хэрэгжилтийг хэмжихэд тодорхойгүй байдал бий болгохоор байна. (ТХЗ-ийн хэрэгжилтийн бэлэн байдал ИНБ-ын тайлан, х.27, 2019)
- Монгол Улс нь жендэрийн тэгш байдлыг хангах талаар хууль эрх зүйн орчин харьцангуй сайн боловч, хэрэгжилт нь хангалтгүй байна. Энэ нь жендэрийн мэдрэмжтэй бодлого хөтөлбөр боловсруулдаггүй, засаглалын чадавх сул, хүйсээр ангилсан мэдээлэл дутмаг, улмаар түүний хэрэглээ сул, бодлогын төлөвлөлт, төсвийн хуваарилалтад жендэрээр илэрхийлсэн дүн шинжилгээ, тоо мэдээллийг ашигладаггүй зэрэг олон зүйлээс шалтгаалж байна. (Олон улсын хөдөлмөрийн байгууллага, 2019, х.74)
- Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт баримтлах жендэрийн бодлого баталсан ч хэрэгжүүлээгүй, салбарын мэргэжилтнүүд жендэрийн мэдрэмж сул, бодлого хэрэгжүүлэх арга зам тодорхойгүй байна. Эмэгтэйчүүд бага насны хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй болон ахмад настныг асарч үйлчилдэг гэсэн шалтгаанаар эдийн засгийн идэвхгүй болж, хөдөлмөр эрхлэх боломж хумигдаж, ажил орлогогүй болох нь нэмэгдэж байна. Үүний улмаас эмэгтэйчүүд өөрийн орлогогүй, санхүүгийн эрх мэдэлгүй болж, улмаар гэр бүлийн, эдийн засгийн хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй байна. (Хүний эрхийн ТББ-уудын Форум, 2020, х.6)

Нийгмийн хүчин зүйлс:

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн бодлого, хөтөлбөр байгаа ч “хүүхдээ харсан, гэр бүлийн хэн нэгнийг асарсан” шалтгаанаар ажил хөдөлмөр эрхлээгүй эмэгтэйчүүдийн тоо жил бүр нэмэгдсээр байна. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд шууд нөлөөлөх цэцэрлэг, яслийн хүрэлцээ, хүртээмж, хүүхэд харах үйлчилгээ, зайнаас ажиллах боломж, ажлын цагийн уян хатан хэрэгцээг тооцон зохицуулах шаардлага байна. (ТХЗ-ийн хэрэгжилтийн бэлэн байдал ИНБ-ын тайлан, х.27, 2019, х.40)
- Эмэгтэй, эрэгтэй хүмүүст нийгэм эдийн засгийн салбарт эн тэгш хөдөлмөрлөх, тэдний эрхэлж буй ажил нийгэмд эн тэнцүү үнэлэгдэх боломжийг бүрдүүлэхийн тулд охид хөвгүүдийн мэргэжил эзэмшихэд төдийгүй “насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэйчүүдийн боловсролын түвшний зөрүүг багасгахад чиглэсэн боловсрол нөхөн олгох албан ба албан бус сургалтад хамрагдах, тасралтгүй боловсролын үйлчилгээг хүртэх тэгш боломж, нөхцөлөөр хангагдана» гэсэн заалтыг хэрэгжүүлэх шаардлагатай байна. (Жендэрийн үндэсний хороо, 2019, х.45)

Эдийн засгийн хүчин зүйлс:

- Хөдөлмөрийн бүтээмжийн жилийн дундаж өсөлт эрчимтэй нэмэгдэж 2012 онд 11.2% -д хүрч байсан ч уналтад орж 2015 он гэхэд -1.8% болтлоо буурсан. Төр засгаас авч хэрэгжүүлсэн хүчин чармайлтын үр дүнд 2016 он гэхэд хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт 1.2% болж нэмэгдсэн ч хямралын өмнөх жилүүдийнх шиг сэргэж чадаагүй байна. (Олон улсын хөдөлмөрийн байгууллага, 2019, х.31)

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХИЙГ ХАНГАХТАЙ ХОЛБООТОЙГООР 2015-2019 ОНД МОНГОЛ
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

МУ-ын Засгийн газрын түвшинд хэрэгжүүлсэн үйл ажиллагааг нэгд бодлогын орчныг сайжруулах чиглэлээр, хоёрт төсөв, гуравт сургалт, дөрөвт судалгаа гэсэн ангиллаар төрийн холбогдох байгууллагуудаас ирүүлсэн мэдээллийг нэгтгэв. Нийт нэр бүхий 11 газарт мэдээлэл хүссэн албан тоотын хүргүүлсэн ба үүнээс 10 газар нь хариу ирүүлсэн. Хүний эрхийн үндэсний комисс ямар нэгэн хариу өгөөгүй байна.

	Нэрс	Бодлогын орчинг сайжруулах чиглэлээр	Төсөв	Сургалт	Судалгаа
1	ХЗДХЯ, МУ-д ГХУСАЗЗ	✗	✗	✗	✗
2	ХНХЯ	✗	✓	✗	✓
3	ЭМЯ	✗	✗	✗	✗
4	БСШУСЯ	✗	✗	✗	✗
5	ШЕЗ	✗	✗	✗	✗
6	УЕПГ	✗	✗	✗	✗
7	ЦЕГ	✗	✗	✗	✗
8	ГБХЗХГ	✗	✗	✗	✗
9	ХБХЕГ	✗	✗	✗	✗
10	ЖҮХ	✗	✗	✗	✗
11	ХЭҮК	Мэдээлэл ирүүлээгүй			

✓ Тийм ✗ Үгүй



БАРИМТЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН:

Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэнд тулгамдаж буй асуудал



2

ЧАНАРЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Баримтын судалгааны үр дүнд үндэслэн дараах судалгааны асуудлуудыг тодорхойлох зорилгоор чанарын судалгаа хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрх зөрчигдөхөд Монгол Улсын бодлого, эрх зүйн орчин хэрхэн нөлөөлж байна вэ?
- Эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрхийг хамгаалах, идэвх, оролцоог нэмэгдүүлэхийн тулд хэн, юу хийх хэрэгтэй вэ (ямар шийдэл байж болох вэ)?

Дээрх зорилгоор хөдөлмөрийн харилцааны асуудлаар мэргэшсэн судлаач, зөвлөх, төрийн байгууллагын мэргэжилтэн, ажил олгогч, ажилтан нарыг оролцуулан нийт 5 бүлгийн ярилцлага, 5 ганцаарчилсан ярилцлага хийв.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН:

Эрх зүйн орчны хувьд:

- Манай улсад эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрхийг хангахдаа хөдөлмөрийн салбарт жендэрийн тэгш байдлыг хангах бодлогыг баримталж байна. Эмэгтэй ажиллах хүчний оролцоо, гүйцэтгэж буй ажил үүрэг, гэр бүл нийгэмд үнэлэх тооцоолол зэрэг судалгааны ажил манай улсын хувьд сул байгааг эдийн засгийн салбарын судлаач онцолж байна. Түүнчлэн албан бус эдийн засгийн салбарт ажиллаж байгаа иргэдэд чиглэсэн бодлого, хөтөлбөр хангалтгүй байгааг судалгаанд оролцогчид бүгд илэрхийлж байв.
- Хэдийгээр хөдөлмөр эрхлэлтийн салбарт тэгш байдлыг хангах бодлого баримталж байгаа ч жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт хэрэгжиж чадаж байгаа эсэхийг судалгаагаар үнэлэх, өмнө хийсэн судалгааны үр дүн, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх бодлого боловсруулахдаа ашиглах хэрэгцээ шаардлага байна.
- Малчин эмэгтэйчүүд тэр дундаа хөлсөөр ажиллаж байгаа малчин эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг гүнзгийрүүлэн судлах шаардлагатай байна.
- Эмэгтэйчүүдийн ур чадварыг нэмэгдүүлэх, үнэлэмж ихтэй ажил, хөдөлмөр эрхлэх боломжийг тэдэнд олгохыг дэмжин ажиллах хэрэгтэй байна.
- Албан бус салбарт ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн асуудлыг судлах, тэдэнд хөдөлмөрлөх эрх, эдийн засгийн тэгш боломж олгохын тулд ялангуяа хүүхэд харах үйлчилгээг өргөжүүлэх, ажил хийж байгаа эмэгтэйг илүү урамшуулж, хүүхэд харах тэтгэмж, дэмжлэгийг таслахгүй байхын зэрэгцээ тэдний нийгмийн баталгаа буюу нийгмийн даатгалын шимтгэл холбогдох дэмжлэгийг шийдвэрлэх тусгай үйл ажиллагаа үгүйлэгдэж байна.
- Нийгмийн халамжийн бодлогоор эмэгтэйчүүдийг дэмжих бус харин эдийн засгийн оролцоонд суурилсан ажил эрхлэлтийг бий болгох замаар тэдний эрхийг хангах, бодитоор дэмжих шаардлагатай байна.
- ДНБ-д эмэгтэйчүүдийн давхар оролцоог тодорхой болгох шаардлагатай байна. Дэлхийн дахинд ДНБ-д эмэгтэйчүүдийн бий болгож байгаа бараа, үйлчилгээг оруулан тооцох шаардлагатай гэсэн үзэл хандлага гарч байна. Үүнтэй уялдуулан хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг нийцүүлэх, сайжруулах

хэрэгтэй.

- Хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх тогтолцоог сайжруулах, хяналтыг бий болгох. Ингэхдээ ажил олгогч, ажилтны төлөөллийг оролцуулах. Маргаан гарахаас урьдчилан сэргийлэх, хөдөлмөрлөх эрх, зохистой хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийг өргөнөөр сурталчлан таниулах хэрэгтэй байна.
- Ижил үнэлэмжтэй ажилд ижил цалин хөлсийг олгох зохицуулалт шаардлагатай.

"ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ"

ОНЛАЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Онлайн асуумжаар 2020 оны 4 сарын 3-10-ны хооронд авсан судалгаанд 718 (энэ тоонд зорилтот малчин болон бага насны хүүхэдтэй, ажлаа хийж буй нийт 58 эмэгтэйн мэдээлэл багтсан) эмэгтэй оролцсон байна.

Нийт оролцогчдын 570 нь буюу 79% нь 0-3 насны хүүхэдтэй, 18-25 насны 14.3% , 26-40 насны 70.8% , 41-54 насны 7.7% хувь байна. Улаанбаатараас 411, аймгаас 183, сумаас 98 хүн оролцжээ.

Эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрхтэй холбоотой онлайн судалгаанаас дараах үр дүн гарчээ:

- Хөдөлмөр эрхлэхэд тулгардаг бэрхшээлийн хувьд хүүхэд асрах хүн байхгүй 74.4% (n=502), цэцэрлэг болон ажлын цаг давхцдаг 42.2% (n=285), өндөр өнжүүлэх төв хүртээмжгүй 30% (n=221) гэж тус тус хариулсан байна.
- Судалгаанд оролцогчдын (n=666) 28.2% нь ажил олгогчтойгоо хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй байна. Мөн 12.4% нь хөдөлмөрлөх эрхтэй холбоотой гомдлыг ажил олгогчдоо гаргаж байжээ.
- Нийт судалгаанд оролцогчдын 51.7% (n=371) нь албан, 8.9% нь сайн дурын нийгмийн даатгалд хамрагдаж үлдсэн 36.2% нь нийгмийн даатгалд хамрагдаагүй байна.
- Нийт оролцогчдын 159 буюу 5% -д нь жирэмсэн байхад ажлаас гарах шаардлага ирсэн бөгөөд тэдний 68.2% буюу 107 эмэгтэй шаардлагыг хүлээн авсан бол 31.8% нь зөвшөөрөөгүй байна.
- Ажлын байрны дарамт, хамт олны зүгээс ирэх ялгаварлан гадуурхалт зэрэгт нийт 266 оролцогч тийм, 400 оролцогч үгүй гэж тус тус хариулсан байна. Удирдах албан тушаалтнаас ямар нэг хэлбэрээр ялгаварлан гадуурхалтыг үзүүлэх, цалин урамшуулал нэмэхгүй байх мөн бага насны хүүхэдтэй гэж гадуурхах дарамт ирдэг гэж судалгаанд оролцогчид хариулсан байна.

ДҮГНЭЛТ:

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын орчинг сайжруулах чиглэлээр Монгол Улсын Засгийн газар тодорхой бодлого хэрэгжүүлж байна. Гэвч эдгээр бодлого нь өөр хоорондоо уялдаа сул, зохицуулалт нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд ямар нөлөө үзүүлж байгаа нь тодорхой бус бөгөөд цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлагатай байна.
2. Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах мөн Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд тус хуулийг нийцүүлэх хэрэгцээ байна. Хөдөлмөрийн харилцаанд оролцогчдод нэгдсэн ойлголтыг бий болгох шаардлагатай байна.
3. Ажлын байрны дарамт, ялгаварлан гадуурхалтад эмэгтэйчүүд өртөж байгаа бөгөөд хөдөлмөрийн харилцаан дахь ялгаварлан гадуурхалтын эсрэг эрх зүйн орчныг бий болгох, бүрдүүлэх хэрэгтэй байна.
4. Хөдөлмөрийн харилцаатай холбоотой маргааныг хянан шийдвэрлэх тогтолцоо, механизм оновчтой

бус байгаагаас гомдол шийдвэрлэгдэхгүй байна.

5. Эмэгтэйчүүд ажил хөдөлмөр эрхлэхэд хамгийн хүндрэлтэй асуудал нь хүүхэд харах үйлчилгээний хүртээмжгүй байдал байна.

ЗӨВЛӨМЖ:

1. 1999 оны “Хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулга”-ыг яаралтай батлах, ингэхдээ Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд нийцүүлэх.
2. Хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх тогтолцоог сайжруулах, хяналт бий болгох.
3. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн оролцоонд тэгш байдлыг төрийн бодлогоор дэмжих дараах зохистой арга хэмжээг авах. Үүнд:
 - а. Хүүхэд төрүүлж өсгөнгөө эмэгтэйчүүд ажил хийж, цалин орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэх, хүүхэд харах үйлчилгээ, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хүүхэд асарсны мөнгийг зөвхөн ээжид бус хүүхэд асарсан хүнд олгох (эмээ, өвөө, ах, эгч гэх мэт)
 - б. Хүүхэд төрүүлж, өсгөн гэртээ байгаа ээжүүдийн хөдөлмөрийн ур чадварыг алдагдуулахгүй байхад анхаарах
4. Хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг цогцоор харах буюу нийгмийн халамж, нийгмийн даатгалын тогтолцоо нь хөдөлмөр эрхлэлтийг дэмждэг байх, “халамжаас хөдөлмөр эрхлэлт рүү” зарчимд нийцүүлэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгай хөтөлбөрүүдийг шинэчлэн баталж, хэрэгжүүлэх
5. Зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эмэгтэйчүүдэд ээлтэй ажлын байр, ажиллах орчныг бий болгох. Үүнд:
 - а. Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуй нь эмэгтэйчүүдэд ээлтэй байхаас гадна ажлын орчныг бүрдүүлэх
 - б. Ажил амралтын тэнцвэрт байдлыг хадгалахад хувийн хэвшлийн хариуцлагыг нэмэгдүүлэх, ажлын цаг уян хатан, зайнаас ажиллах, ажлын гүйцэтгэлийг цагаар бус хийснээр үнэлдэг болох
6. Хөдөлмөрийн харилцаанд эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхаж буй хэлбэрүүдийг устгах зорилгоор тусгайлсан бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, бүрдүүлэх







ТАВДУГААР БҮЛЭГ:
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХИЙН БУСАД АСУУДЛУУД
(ЭРҮҮЛ МЭНД, БОЛОВСРОЛ, ГЭРЛЭЛТ, ГЭР БҮЛ)

ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ:

Нөхөн үржихүйн эрүүл мэнд:

- Монгол Улсын 2018 оны эрүүл мэндийн үзүүлэлтээс харахад эх, хүүхдийн эндэгдэл, үр хөндөлт сүүлийн 10 жилийн хугацаанд буурсан байна. 2018 оны байдлаар үр хөндөлт хийлгэж буй эмэгтэйчүүдийг насны бүлгээр авч үзэхэд 20-иос доош насных 5.5% байгаа ба өмнөх онтой харьцуулахад тухайн насны бүлэгт үр хөндөлтийн түвшин 0.3%- иар өссөн байна. (Эрүүл мэндийн хөгжлийн төв, 2019). Цагдаагийн ерөнхий газраас ирүүлсэн мэдээллээс харахад улсын хэмжээнд 2018 онд насанд хүрээгүй үедээ жирэмсэн болсон тохиолдол өмнөх оноос 466-аар буюу 31.7%- иар, үр хөндүүлсэн охид 73-аар буюу 35.7%- иар, хүүхэд төрүүлсэн охид 393-р буюу 44.4%- иар тус тус өссөн үзүүлэлттэй байгаагаас харахад насанд хүрээгүй охидын жирэмслэлт, үр хөндөлт, төрөлт эрс ихэссэн бөгөөд цаашид өсөх хандлагатай, энэ зорилгод бүлэг рүү чиглэсэн ажил хийх хэрэгтэй талаар санал өгсөн.
- Жирэмслэлтээс сэргийлэх орчин үеийн аргын хэрэглээ 2015 онд нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэйд 540.6, 15-49 насны эмэгтэйчүүдийн 54.1% байсан бол 2018 онд нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэйд 550, 15-49 насны эмэгтэйчүүдийн 55.0% байна. Жирэмснээс сэргийлэх орчин үеийн арга хэрэгслийн хэрэглээг байршлаар нь авч үзвэл нийслэл Улаанбаатар хотод 49% байхад багийн түвшинд 11.4% байна. Түүнчлэн жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэглэдэг эмэгтэйчүүдийн хувь 40%- д хүрэхгүй байгаа Булган, Увс, Ховд, Хэнтий аймаг анхаарал татаж байна. 2018 онд бүртгэгдсэн БЗДХ-ын нийт тохиолдлын 57.4% нь эмэгтэй, 42.6% нь эрэгтэйчүүд байна. Насны бүлгийн хувьд 12.5% нь 15-19 нас, 26.7% нь 20-24 нас, 23.3% нь 25-29 нас, 15.3% нь 30-34 нас, 9.2% нь 35-39 нас, бусад насныхан 13%-ийг тус тус эзэлж байна. (Эрүүл мэндийн хөгжлийн төв, 2019; Эрүүл мэндийн хөгжлийн төв, 2016)
- Нөхөн үржихүйн эрүүл мэнд нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн хувьд шийдвэрлэх шаардлагатай асуудал болж байна. Жишээ нь ХЭҮК-ийн Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлд (2019) дурдсанаар судалгаанд оролцсон хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн 16% нь нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдээллийг эмч, мэргэжилтнүүдээс, 84% нь найз нөхөд, гэр бүлийн гишүүн, интернет, мэдээллийн хэрэгсэл зэрэг эх сурвалжаас авч байна. Мөн давхардсан тоогоор тэдний 51% нь энэ төрлийн мэдээллийг телевизээс авдаг ч телевизийн мэдээлэл нь харааны болон сонсголын бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй бус байгааг Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооноос 2015 онд Монгол Улсын Засгийн газарт өгсөн зөвлөмжид дурдсан байна (х.72). Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд эмэгтэйчүүдийн эмчгүй, эсхүл эмч нар нь туршлага багатай, дүүргийн эмнэлэгт үзүүлэхэд 1-2 сар хүлээдэг, эмнэлэгт дохионы хэлний орчуулагч байдаггүй, эмч нарын ажлын ачаалал их, харилцаа хандлага муу зэргээс шалтгаалан эрүүл мэндийн байгууллагаас дээрх үйлчилгээг авахад хүндрэлтэйг ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагад оролцогчид дурджээ (х.73). Мөн судалгаанд хамрагдсан оюуны бэрхшээлтэй эмэгтэйчүүдтэй хийсэн ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагаар хот, орон нутагт оюуны бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд жирэмслэлтээс сэргийлэх тариаг заавал хийдэг, татгалзсан тохиолдолд халамжийн тэтгэмж олгохгүй, асаргааг сунгахгүй гэх мэтээр халамжийн ажилтан, өрхийн эмч нар дарамт үзүүлж хүчээр хийдэг, зарим аймагт 3 сар тутмын аян болгож энэ ажлыг зохион байгуулдаг гэж хариулсан байна (х.85). Судалгаанд оролцогчид ерөндөг, эм, хуанлийн аргыг хамгийн их хэрэглэдэг гэжээ. Гэхдээ жирэмслэлтээс хамгаалах хэрэгслийг ашиглахад санхүүгийн боломжгүй, эмнэлгийн орчны хүртээмжгүй байдал болон өөрт тулгарсан асуудлыг эмч, эмнэлгийн ажилтнуудад ойлгуулахад хэцүү байдаг гэж хариулсан байна (х.83).

Хорт хавдар:

- Эмэгтэйчүүдийн дунд тохиолдож байгаа хорт хавдар 2018 оны байдлаар эхний тавд элэг (33%), умайн хүзүү (12,4%), ходоод (10,3%), хөх (8,1%), улаан хоолой (5,9%) байна. Умайн хүзүүний хорт хавдрын 372 шинэ тохиолдол бүртгэгдсэн нь 100,000 эмэгтэй хүн амд 23.2 байна. 100,000 эмэгтэй хүн амд Дархан-Уул, Сэлэнгэ, Дорнод, Говьсүмбэр, Говь-Алтай, Баянхонгор, Хэнтий, Өмнөговь, Дундговь аймагт улсын дунджаас /23.2/-аас өндөр байна. Хорт хавдрын оношлогдох үеийг харахад умайн хүзүүний өмөнгийн нийт тохиолдлын 49.0% нь 2-р үе шатандаа оношлогдсон нь өмнөх онтой харьцуулахад буураагүй байна (Эрүүл мэндийн хөгжлийн төв, 2019).

Эмэгтэйчүүдийн боловсрол:

- Дэлхийн эдийн засгийн форумас жил бүр тооцон гаргадаг жендэрийн ялгаатай байдал (gender gap index)-ын индексийг тодорхойлдог гол үзүүлэлтийн нэг болох боловсролын түвшингээр Монгол Улс 2019 оны эцсийн байдлаар дэлхийн 153 орноос 71 дүгээрт (0.993) эрэмбэлэгдэж байна. (Үндэсний Статистикийн хороо, 2019)
- МУ-ын Засгийн газар, ШХА-с хэрэгжүүлж буй “Тогтвортой хөгжлийн боловсрол” төслийн захилгаар гүйцэтгэсэн “Бага, дунд боловсролын жендэрийн шинжилгээ” жендэрийн дүн шинжилгээг цогцоор хийсэн анхны судалгаа юм. Судалгаагаар Монголын боловсролын тогтолцоонд сүүлийн арван жилд олон тооны өөрчлөлт шинэчлэлт хийгдлээ. Тухайлбал, ерөнхий боловсролын тогтолцоог 3 удаа өөрчилсөн, хичээлийн хөтөлбөрийг 3 үе шаттайгаар шинэтгэсэн, сургуульд элсэх нас 8 байсныг 6 болгосон, 2007-2015 оны хооронд ерөнхий боловсролын сургалтыг 12 жил болгох ажлыг шат дараатайгаар хийж гүйцэтгэсэн. Арван хоёр жилийн сургалтыг бүрэн дүүргэсэн анхны төгсөлт 2020 онд болно. (Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэн, 2016)
- Аймаг, дүүргийн боловсролын газраас ЕБС-иудад жендэрийн талаар баримтлах чиглэлээ өгдөггүй нь жендэрийн тэгш байдлыг хангах, жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль хэрэгжихгүй орхигдоход хүрч болзошгүй байна. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 12-р зүйлийн 12.3. дахь хэсэгт Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны тайланд жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлын үр дүн, гарсан зөрчил, түүнийг арилгах талаарх авсан арга хэмжээг тусгах бөгөөд жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлын үр дүн нь сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгчийн үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх шалгуур үзүүлэлтийн нэг байна гэж заасан ч сургуулийн удирдах ажилтнууд тус хуулийн талаар хангалттай ойлголт мэдээлэлгүй байна. (Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэн, 2016)
- Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд нийт хүүхдүүдийн 20.2% буюу таван хүүхдийн нэг нь хамрагдаж чадахгүй байгаа ба эдгээрт хот суурин газрын ядуу болон шилжин суурьшсан өрхийн хүүхэд, хөдөөгийн малчдын хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд зонхилж байна. Сургуулийн өмнөх боловсролын талаар дэвшүүлсэн зорилтуудыг бүрэн хангах, бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нийгэм, эдийн засгийн салбарын бодлогын уялдаа, оролцооны үр өгөөж хангалттай түвшинд тогтвортой байж чадахгүй байна. (БСШУСЯ, 2019, х.7)
- Хөдөө орон нутгаас нийслэлд болон аймгийн төвд шилжин ирж буй иргэдийн тоо жилээс жилд өсөн нэмэгдэж, нийгмийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага түүний дотор ЕБС-ийн суудлын тоо, хүчин чадал хүн амын өсөлтийг гүйцэж, шилжилт хөдөлгөөний өөрчлөлтийг бүрэн дааж чадахгүй болсноос 3 ээлжээр хичээллэж байгаа сургуулийн тоо буурахгүй байна. Мөн бүлэг дүүргэлт улсын хэмжээнд хэвийн байгаа ч бүс нутаг, байршлын хувьд харилцан адилгүй байна. Багийн сургуульд хамгийн бага, хотын сургууль хамгийн их бүлэг дүүргэлттэй байна. Иймд шилжилт хөдөлгөөн ихсэж, бүлэг дүүргэлт хот, хөдөөд ялгаатай болж, боловсролын үйлчилгээний чанар, үр дүнд сөрөг нөлөө үзүүлж байгаа нь зөвхөн боловсролын салбарын төдийгүй нийгэм, эдийн засгийн шинжтэй томоохон асуудал болохыг харгалзан ЕБС-ийн бүтэц, хэв шинж, байршлыг Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн оновчтой болгож, сургуулийн шинэ зураглал (School mapping)-ыг хийх шаардлагатай байна. Түүнчлэн сургалтын орчин болон дотуур байрны нөхцөл, сургалтын хэрэглэгдэхүүнд нарийвчилсан үнэлгээ хийж, суралцахуйн зарчмууд



хэрэгжих боломжтой, суралцагчид бүтээлч үйлээрээ мэдлэг бүтээхэд шаардлагатай сургалтын шинэ орчин, эрүүл аюул осолгүй суралцаж, амьдрах нөхцөлийг хангасан байхаар сургуулийн болон дотуур байрны барилгын зураг дизайныг үе шаттайгаар шинэчлэн сайжруулах төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх хэрэгтэй байна. (БСШУСЯ, 2019, х.9)

- Мэргэжлийн боловсрол, сургалтын удирдлагын тогтолцоо оновчгүй, салбар дундын зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал байна. МБС-ыг эрхлэх төрийн захиргааны байгууллагыг салбар дундын зарчмаар байгуулах, тогтвортой ажиллуулах замаар олон улсын жишигт нийцсэн, удирдлагын илүү оновчтой, үр дүнтэй тогтолцоонд шилжих шаардлагатай. Энэ шилжилтийг МБСҮЗ-ын статусыг өндөржүүлэх замаар шийдвэрлэх боломжтой. Энэ шийдэл нь мэргэжилтэй ажилтан бэлтгэх тогтолцоог шинэчлэх, улмаар мэргэжлийн боловсрол, сургалтын төдийгүй нийгмийн хөгжлийн зангилаа асуудлуудыг шийдвэрлэх оновчтой шийдэл болно. (БСШУСЯ, 2019, х.11)
- 25-аас дээш насны эмэгтэйчүүдийн 91.2% нь, эрэгтэйчүүдийн 86.3% нь дундаас дээш боловсролтой байна (Үндэсний Статистикийн хороо, 2018). Дээд боловсролтой хүн амд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 2011-2018 оны дунджаар 58.3 байна. 15-24 насны хүн амын бичиг үсэг тайлагдалтын хувь, эрэгтэй 97.6%, эмэгтэйчүүд 99.3% байна.
- Дээд боловсрол эзэмшихээр суралцаж буй суралцагчдын жендэрийн тэнцвэрт байдлын индекс буюу дээд боловсрол эзэмшихээр суралцаж буй 100 эрэгтэй суралцагч тутамд ногдож буй эмэгтэй суралцагчдын тоо 2014/2015 оны хичээлийн жил хүртэл буурч байсан бол 2015/2016 оны хичээлийн жилээс өсөх хандлага ажиглагдаж байна (ҮСХ, Дээд боловсролын үндсэн үзүүлэлтүүдийн төлөв байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээ, х.7, 2019).
- Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчдын 49.8%-ийг охид, 50.2% -ийг хөвгүүд бүрдүүлж байгаагаас бага ангийн нийт суралцагчдын 48.9%, дунд ангийн 49.7%, ахлах ангийн 53.7%-ийг охид эзэлж байна. Их, дээд сургууль, коллежийн нийт суралцагчдын 63.2 % нь эмэгтэй суралцагчид байна.
- Эмэгтэйчүүд, охидын боловсролын асуудлаар тусгай судалгаа байхгүй, судалгааны тайлангуудад энэ тухай тусгагдахгүй байна. Хэдийгээр боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, тэдгээрийн сайжруулахад чиглэсэн шинжлэх ухааны үндэслэл бүхий үндэсний хэмжээний иж бүрэн судалгаа хийж эхэлсэн ч тэдгээрийг нэгдмэл зорилтын хүрээнд цогц байдлаар тогтвортой явуулахад нэгдсэн бодлого, зохицуулалт, хөрөнгө санхүү, хүний нөөцийн дутагдал хомсдол нөлөөлсөөр байна. (БСШУСЯ, 2019, х.10). Харин хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролын талаар зарим тодорхой асуудлууд тусгагдсан сайн тал байна.
- Боловсролын байгууллагын эрх зүйн баримт бичиг болох сургуулийн дотоод журам, сургуулийн ёс зүйн дүрэм, сурагчийн дүрэм зэрэгт жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэлтэй холбоотой заалтыг тусгасан ч, хариу, урьдчилан сэргийлэх тодорхой арга хэмжээг тусгаж хэвшээгүй байна (Ц.Одгэрэл нарын бүтээл, 2016).
- Охид, хөвгүүдийн харьцаа 2006 онд дунд боловсролын түвшинд 1.14, дээд боловсролын түвшинд 1.64 байсан бол 2018 онд тус тус 1.11 ба 1.43 болж дээшилсэн ч дэлхийн улс орнуудад гарсан эерэг өөрчлөлтийн хурдыг гүйцэхгүй байна. Боловсролд хамрагдалтын хувьд тэгш бус байдлын үзүүлэлт 2006 онд 0.704 байснаа 2018 онд 0.780 болж, 20-р байрнаас 70-р байр руу ухарчээ (Ц.Одгэрэл нарын бүтээл, 2016).
- Монгол эмэгтэйчүүд шаардлагатай боловсрол, мэргэжлийг эзэмшиж байгаа ч тухайн чадамжаа ашиглах, боломж, давуу тал болгох байдал дутмаг байна (IRIM судалгааны хүрээлэн, 2017). Хүн амын дунд дээд боловсролтой эмэгтэйчүүдийн эзлэх хувь өссөн хэдий ч шийдвэр гаргах түвшинд Жендэрийн эрх тэгш байдлын хуульд заасан квотын түвшинд хүрээгүй байна. Өөрсдийн олж авсан боловсролыг ашиглаж, хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцох боломжоор харьцангуй дутмаг байна. Эмэгтэйчүүдийн олонх нь, ялангуяа хөдөө орон нутагт баталгаагүй албан бус салбарт болон цалин хөлсгүй өрх гэрийн ажил хийж, эрэгтэйчүүдтэй харьцуулахад бизнесийн салбарт



эмэгтэйчүүдийн оролцоо хавьгүй доогуур байна (Дэлхийн банк, 2019).

- Боловсролын салбарт эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх орчин бүрдүүлэх бодлого хөтөлбөр байхгүй, боловсролын агуулга, арга зүй, үнэлгээний стандартад жендэрийн тэгш байдлын үнэт зүйл, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг төлөвшүүлэх болон жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгах агуулга тусгагдаж чадахгүй байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй эрэгтэй хүмүүс, охид хөвгүүдийн боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хэрэгцээ хангагдаагүй хэвээр байна гэдгийг судалгааны үр дүн нотолж байна (БСШУСЯ, 2019, х.11).
- Хөдөлмөрийн зах зээл дээр ажил мэргэжлүүд хүйсээр ангилагдсан байх нь элбэг байна. Тэгш цалин хөлс олгох тал дээр жендэрийн зөрүүтэй байдал хэвээр байна. (БСШУСЯ, 2019, х.145)

Гэрлэлт, гэр бүлийн харилцаа:

- Үндэсний статистикийн хорооны мэдээгээр гэр бүл цуцлалтын талаарх тоон мэдээлэл нь 2015 онд 3873, 2016 онд 4003, 2017 онд 3945, 2018 онд 4201, 2019 онд 4262 байна. Үүнээс гэр бүл байсан хугацаагаар нь авч үзвэл долоогоос дээш жил амьдарсан хүний гэрлэлтийн харилцаа дуусгавар болж байгаа талаар мэдээлсэн байна. (ҮСХ, Гэр бүл цуцлалтын тоо, 2019)
- Гэр бүлийн байдлыг 2017 оны статистик тоо баримтад тулгуурлан авч үзвэл 1000 гэрлэлт тутмын 1.9 нь гэр бүлээ цуцлуулж байна. (ГБХЗХГ, Дэлхийн зөн Монголд ОУБ, 2018) 2018 оны статистик тоо баримтаас харахад 1000 гэрлэлт тутмын 2 нь гэр бүлээ цуцалжээ.
- Хүчирхийлэл үйлдэгчээс гэрлэлт цуцлуулах, хүүхдээ асрамжиндаа авах, эд хөрөнгөө нэхэмжлэхэд гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид болон эрхэлсэн тодорхой ажилгүй бага насны хүүхэдтэй эмэгтэйчүүдэд тулгардаг хамгийн хүндрэлтэй асуудал нь Улсын тэмдэгтийн хураамжийн асуудал юм. 2 хүүхэдтэй, 2 өрөө байртай гэр бүл гэрлэлтээ цуцлуулахад 600000 /зургаан зуун мянга/ орчим төгрөгийн улсын тэмдэгтийн хураамж төлөх шаардлагатай болдог. Гэрлэлт цуцлуулах нэхэмжлэл болон түүнийг дагалдан гарцаагүй үүсч байгаа хүүхдийн асрамж, хүүхэд, хөдөлмөрийн чадваргүй эхнэр, нөхрөө тэжээн тэтгэх, хамтран өмчлөх дундын эд хөрөнгөө хуваах тухай шаардлагыг тус тусдаа нэхэмжлэлийн шаардлага гэж үзэж байгаагаас шүүхэд төлөх улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээ хэт өссөн байна. Шүүх гэрлэлт цуцлалтыг тусад нь, хүүхдийн асрамж, тэтгэмж, эд хөрөнгийн маргааныг мөн тус бүрт нь бие даасан нэхэмжлэлд тооцон тэмдэгтийн хэмжээ тогтоож байгаа нь нэхэмжлэгчийн шүүхэд хандах эрхэд санхүүгийн хувьд томоохон дарамт үүсгэж байна. Ялангуяа гэр бүлийн хүчирхийлэлтэй, орлого бага, бага насны хүүхэдтэй нэхэмжлэгчид хүнд дарамт болж байна. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.3-т зааснаар гэр бүлийн маргааныг оролцуулаад аливаа хэрэг маргаанд “Нэхэмжлэгч төлбөрийн чадваргүй болох нь түүний тайлбар, бусад нотлох баримтаар тогтоогдсон буюу хуульд заасан бусад үндэслэл байвал түүнийг улсын тэмдэгтийн хураамж төлөхөөс шүүгчийн захирамжаар чөлөөлнө” гэж заасан. Гэр бүлийн бодит хүчирхийллийн улмаас гэрлэлт цуцлуулахаар гаргасан олон нэхэмжлэгч нь эрүүл мэнд, сэтгэл санааны хувьд хохирсон, орон байрнаасаа дайжсан, тогтмол орлогогүй, бага насны хүүхэдтэй, аюулгүй байдал нь эрсдэлд орсон нөхцөлд байдаг. Энэ нөхцөлд олон төрлийн нотлох баримтыг бүрдүүлэхэд хүндрэлтэй, бүрдүүлсэн ч шүүгчээс тэдгээрийг хангалттай нөхцөл байдал гэж үзэхгүй байх нь элбэг байна. (ХЭҮТ, 2018)
- Хүүхдийн тэтгэмжийн хэмжээ бага байна. Гэрлэгчид гэрлэлтээ цуцлуулснаар үүсэх хүүхдийн тэтгэлгийн харилцааг амьжиргааны баталгаажих доод түвшинтэй холбосон нь нэг талаар хүүхдийн амьжиргааны доод түвшний баталгааг хийж өгсөн мэт боловч нөгөө талаар үүнээс илүү байх нөхцөлийг хязгаарласан, хүүхдээ бололцоотой хэмжээндээ тэжээн тэтгэх үүргээс зайлсхийх боломж олгож байна. Иймд хүүхдийн онцлог хэрэгцээ, амьдралын нөхцөлийг аль болох дордуудахгүй байх, тэтгэмж төлөгчийн цалин орлогын байдлыг харгалзан, эсхүл хүүхдийн тэтгэлгийн хэмжээг амьжиргааны баталгаажих түвшнээс “багагүй” гэх томъёоллыг хуульд оруулж, уян хатан болгох шаардлагатай. Хүүхдийн тэтгэлийг төлж эхлэх хугацааг шүүхийн шийдвэр гарснаас хойш биш гэрлэлт



цуцалсан хугацаатай холбохгүйгээр аль нэг тал нь хүүхдээ тэжээн тэтгэх үүргээ зогсоосон үеэс нотлох баримтыг үндэслэн тооцож олгох шаардлагатай байна. Шүүхээс хүүхдийн тэтгэлгийг тогтоодог боловч шийдвэр гүйцэтгэл дээр очоод биелдэггүй. Хариуцагч “ажил хөдөлмөр эрхэлдэггүй”, “хөдөлмөрийн чадваргүй (өвчтэй)”, “шоронд ял эдэлж байгаа” гэхчлэн шалтгаанаар хүүхдийн тэтгэмж төлдөггүй. (ХЭҮТ, 2018)

БОДЛОГЫН ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ: ДЭМЖИЖ БАЙГАА ЗОХИЦУУЛАЛТ

Эрүүл мэнд:

- **“Захиргааны ерөнхий хууль”**-ийн 13.4-т захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүн оролцох тохиолдолд дохио, зангаа, тусгай тэмдэгт ашиглан хэлмэрчийн тусламжтайгаар оролцоно.
- **“Хөдөлмөрийн тухай хууль”**-д хөгжлийн бэрхшээлтэй ажилтны ажлын цагийг богиносгох, ээлжийн амралтыг уртасгах, аж ахуйн нэгжид хөгжлийн бэрхшээлтэй иргэнг ажиллуулах квот тогтоох, биелүүлээгүй тохиолдолд торгууль/төлбөр ногдуулах
- **“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль”**-д ажил олгогч нарт хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулсны хөлсний зохих хувийг (60%) нөхөн төлөх, түүнчлэн тус ажилтныг 1 жилээс илүү хугацаагаар ажиллуулбал хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5 болон 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшуулал олгох

Боловсрол:

- **“Боловсролын тухай хууль”**-д Монгол Улсын иргэний боловсрол нь суралцагчийн хэрэгцээ, хувийн болон хөгжлийн онцлогт нийцсэн олон хувилбартай байх, хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэгт ердийн бүлгийн хүүхдүүдтэй, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 2 хүртэл хүүхэд нэг бүлэг байж болох
- **“Барилгын тухай хууль”**-д барилга байгууламж нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээг хангасан байх, барилгын зураг төсөл нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээг хангах арга хэмжээг тусгасан байх
- **“Хот байгуулалтын тухай хууль”**-д дэд бүтцийн байгууламжуудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст саад болохгүй нөхцөлийг хангах төлөвлөлтийг норм болон дүрэм, журамд заасныг баримтлах, ийм нөхцөлийг хангаагүй хот төлөвлөлт болон барилгажилтын шийдэл, зураг төсөл, интернетийн, нийгмийн дэд бүтцийг барьж байгуулах аливаа төсөлд зөвшөөрөл олгохыг хориглох
- **“Авто тээврийн тухай хууль”**-д нийтийн тээврийн хэрэгслээр зорчиж байгаа хараагүй хүнд зориулж буудлыг зарлах, сонсголын бэрхшээлтэй иргэнд зориулж, буудал бүрт нэр, хаяг, чиглэлийг бичмэл буюу зургийн хэлбэрээр байрлуулах, өөрчлөх шийдвэрийг тухайн шатны Засаг дарга гаргана.
- **“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”**-д Монгол Улсын нутаг дэвсгэрт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хэм хэмжээний шаардлага нэгдмэл байх ба хуулийн 16.1-т хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрны нөхцөл нь тэдний хөдөлмөрлөх чадварт нь тохирсон байна мөн 16.2-т хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байр нь түүнийг орж, гарахад нь саад болохооргүй байдлаар тоноглогдсон байна гэжээ.
- **“Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”**-д нийгмийн тогтвортой хөгжлийг хангах зарчмын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэх, нийгмийн үйлчилгээнд эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлнэ гэж заасан.
- **“Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого (2016-2025)”**-д нөхөн үржихүйн

насны болон жирэмсэн эмэгтэйчүүд, эх, нярайд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хүртээмж, чанар, аюулгүй байдлыг сайжруулах, жирэмсэн эмэгтэйчүүд, эх, нярайд үзүүлэх нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах, нэмэгдүүлэх, гэр бүл, эмэгтэйчүүдийг хүүхдийн тоо, төрөлт хоорондын зайг өөрсдөө зохицуулах нөхөн үржихүйн эрхийг хангасан гэр бүл төлөвлөлтийн чанартай, хүртээмжтэй, цогц үйлчилгээгээр хангахаар тусгасан байхад **“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд Үндэсний хөтөлбөр (2016–2020)”**-т жирэмслэхээс сэргийлэх эм хэрэгслийн санхүүжилтийг үе шаттай нэмэгдүүлэх; гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээний талаарх бодлого, шийдвэрийг бүх шатны эрүүл мэндийн байгууллагад хэрэгжүүлэх талаар шийдвэр гаргагч нарт сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулна гэжээ.

- **“МУ-ын Засгийн газрын 2016–2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”**-т хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлэх бодлого баримтлах,
- **“Боловсролын тухай хууль”**-ийн 4 дүгээр зүйлд “Монгол Улсын боловсролын зорилго нь иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино” гэж заажээ. Мөн Монгол Улсын иргэний боловсрол нь суралцагчийн хэрэгцээ, хувийн болон хөгжлийн онцлогт нийцсэн олон хувилбартай байх, хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэгт ердийн бүлгийн хүүхдүүдтэй хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 2 хүртэл хүүхэд нэг бүлэг байж болно гэжээ.
- **“Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль”**-д мэргэжлийн боловсрол, сургалтын агуулга, зорилго, бүтэц, түүний удирдлага, зохион байгуулалтыг тодорхойлж, иргэнд мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх, мэргэжлийн ур чадвар олгох, дээшлүүлэх сургалтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгад нийцүүлэн зохион байгуулах, энэ үйл ажиллагаанд оролцогчийн эрх, үүрэгтэй холбогдсон харилцааг тусгасан байна. Тус мэргэжлийн боловсрол, сургалтын бүтэц, бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн боловсрол, сургалтын төвүүд хамаарна. Хүмүүжүүлэгчдийг чадваржуулах, мэргэжил дээшлүүлэх сургалтад тогтмол хамруулна.
- Монгол Улсын Засгийн газраас 2010 онд баталсан **“Боловсрол үндэсний 2010– 2021”, хөтөлбөрийн Стратегийн зорилт 2-т “Шинжлэх ухаан, технологийн ололтод тулгуурлан боловсролын стандартын шалгуурыг нарийвчлан тогтоох”** хүрээнд “боловсролын үйлчилгээний орчны стандартыг боловсруулж мөрдөх” гэж заасан байна.
- МУИХ-ын 2015 оны 12-р тогтоолын хавсралтаар **“Төрөөс боловсролын салбарт баримтлах бодлогыг (2014–2024 он)”** батлан гаргасан. Зорилго нь иргэн бүр авьяас, чадвараа хөгжүүлэн, үр бүтээлтэй хөдөлмөрлөж, аз жаргалтай амьдрахад шаардагдах мэдлэг, чадвар, чадамжийг эзэмшин, ёс суртахуун, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахиж, үндэсний нийтлэг үнэт зүйлсийг өвлөн насан туршдаа суралцах боломжоор хангах зорилго бүхий үйл ажиллагааны цогц тогтолцоо бүрдүүлэхэд оршино.
- **“Монгол Улсын Засгийн газрын 2016–2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт”** хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үеийн найзуудтайгаа хамт суралцах нөхцөлийг бүрдүүлж, шаардлагатай дэд бүтцийг сайжруулна мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сурах, хөгжих үйлчилгээ үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангасан аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлнэ гэж заасан.
- **“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг дэмжих хөтөлбөр”** нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрт бэлтгэх, дэмжлэгтэйгээр ажилд зуучлах, тэдний аж ахуй эрхлэлт болон хөдөлмөр эрхлэх ур чадвар олгох сургалтанд хамруулах, урамшуулал, санхүүгийн дэмжлэг, хөдөлмөр эрхлэлтийн тусгай үйлчилгээ, арга хэмжээнд хамруулж дэмжлэг үзүүлэх замаар хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан байнгын ажлын байрыг нэмэгдүүлэх, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд оршино.
- **“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”** (2018–2022 он)-ийг Засгийн газрын 2017 онд баталсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай



хуулийн хэрэгжилтийг хангах, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийгмийн бүхий л харилцаанд бүрэн дүүрэн оролцох нөхцөлийг бүрдүүлэх, тэдний дуу хоолойг олон нийт, шийдвэр гаргах түвшинд хүргэх хөгжлийн бэрхшээлийн талаар эерэг ойлголт, хандлагыг нийгэмд төлөвшүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх зорилготой хөтөлбөр юм.

- **“Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”** нь Монгол Улсын хөгжлийн бодлого, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, шаардлагад нийцсэн, иргэдийн хэрэгцээ, авъяас, сонирхолд тохирсон мэргэжлийн болон техникийн боловсролыг шинэчлэн хөгжүүлж, чанар, хүртээмж, үр өгөөжийг дээшлүүлэхэд чиглэнэ. Мөн хөтөлбөрт мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын шинэчлэлийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодит 26 механизм бүрдүүлж төлөвшүүлэх, үйлдвэрлэлийн хөгжлийн хэрэгцээтэй холбож төрөлжүүлэх, мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт, хөтөлбөрийг шинэчлэх, багш нарыг заах арга зүй болон мэргэшсэн инженер, техникийн ажилтны түвшинд чадваржуулах, сургалтын нөхцөлийг орчин үеийн шаардлагад нийцүүлэх, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах, иргэдийн хэрэгцээнд суурилсан үйлчилгээг нэвтрүүлэх, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх зэрэг асуудлыг тусгасан. Хөтөлбөрт **“хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг мэргэжлийн боловсрол, сургалтад тэгш хамруулах боломжийг нэмэгдүүлэх”** талаар тусгасан ба тус хөтөлбөрт 2019 онд хэрэгжилтийн дунд хугацааны зорилтот түвшинд, 2021 онд зорилтот түвшинд хүрсэн эсэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхээр төлөвлөжээ.

Гэрлэлт, гэр бүлийн харилцаа:

- **“Гэр бүлийн тухай хууль”**-ийг 1999 онд баталсан. Тус хууль нь 9 бүлэг, 76 зүйлтэй бөгөөд тус хуулиар “гэрлэх, гэрлэлт дуусгавар болох, гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох журам, нөхцөлийг тогтоож, гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус харилцаа, хүүхэд үрчлэх, гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх, тэжээн тэтгэх, асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна гэжээ.
- **“Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”**-д гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх урьдчилсан арга хэмжээний төрлүүдийг хуульчилж өгсөн. Шүүгч захирамж гарган насанд хүрээгүй хүүхэд болон хөдөлмөрийн чадваргүй эцэг, эхийн тэжээн тэтгүүлэх, хүүхдийг эцэг, эхийн хэн нэг дээр байлгах, гэрчлэгчдийг тусдаа амьдрахыг даалгах, гэрлэгч хэн нэгнийг тэжээн тэтгүүлэх, орон сууц болон хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг өмчлөх эрхийг бусдад шилжүүлэх, худалдах, бэлэглэх, захиран зарцуулахыг хоригдох, шүүхийн зардлын зохих хувийг урьдчилгаа болгон төлүүлэх, зохиогчид эвлэрүүлэн зуулчлалын журмаар эвлэрэх хугацаа заах гэх мэт арга хэмжээ авч боломжтой болсон.
- **“Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль”**-ийн 14 дүгээр зүйлд гэр бүлийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудлыг хөндсөн бөгөөд гэрлэлт, гэр бүлийн харилцаан дахь тодруулбал, гэрлэлт, цуцлалт, гэр бүл төлөвлөлт, хүсээгүй жирэмслэлтээс хамгаалах, дундын өмчлөлийн эд хөрөнгийг захиран зарцуулах, орлого олох зэрэгт эрэгтэй, эмэгтэйчүүд тэгш эрхтэй, тэгш оролцоотойг нарийвчлан баталгаажуулж, бусдынхаа эрх, эрх чөлөөг зөрчих, хүйсийн шинжээр хязгаарлах, ялгаварлахыг хориглосон. Түүнчлэн, жендэрийн эрх тэгш байдлын тухай ойлголт, хүнийг хүйсийн шинжээр үл ялгаварлах үзэл, зан үйлийг өөрсдийн үлгэр дууриал, гэр бүлийн хүмүүжлээр олгох эцэг эхийн үүргийг тодорхойлж, гэрийн хөлсгүй хөдөлмөрийн үнэлгээг нийгмийн баялаг бүтээх болон өрхийн эдийн засагт оруулсан хувь хэмээн тооцох үзэл баримтлалыг хуульчлан тогтоож өгчээ.
- **“Хүүхдийн эрхийн тухай хууль”**-ийг 2016 онд баталсан бөгөөд тус хуулиар хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, иргэн, хуулийн этгээдийн бүрэн эрхийг тодорхойлж, хүүхдийн эрхийг хангах тогтолцоог бий болгоход анхаарсан.



- **"Хүүхэд хамгааллын тухай хууль"**-ийг 2016 онд баталсан бөгөөд гэр бүл дэх хүүхэд хамгаалал, талуудын үүрэг оролцоог тодорхойлж, хүүхдийг үл хайхрах байдал, дарамт, мөлжлөг, хүчирхийллийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад анхаарсан бөгөөд төрийн зүгээс үзүүлэх үйлчилгээг нарийвчлан тодорхойлсон.
- **"Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"** хөтөлбөрт ...ядуурлын бүх төрлийг эцэс болгох, орлогын тэгш бус байдлыг багасгаж, нийт хүн амын 80% нь дундаж чинээлэг дундаж давхаргын ангилалд багтсан байх, суурь болон мэргэжлийн боловсролд хамрагдалтын түвшинг 100%- д хүргэх, монгол хүний эрүүл, урт удаан амьдрах нөхцөлийг хангаж, дундаж наслалтыг 78-д хүргэх, хүний хөгжлийн өндөр үзүүлэлт бүхий эхний 70 орны нэг болох гэсэн үндсэн зорилтыг дэвшүүлсэн байна.
- **"Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль"**-ийн (ТМЭ, №1, 2011) 7-р зүйлд шүүхээс эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхэд хураах тэмдэгтийн хураамжийн хувь хэмжээг тогтоосон байдаг. 2011 оны нэмэлт өөрчлөлтөөр "эд хөрөнгийн бус, түүнчлэн үнэлэх боломжгүй нэхэмжлэлд 70200 төгрөг"-ний хураамжтай гэж хуульчилсан байна.

ЗӨРЧИЛДӨЖ БАЙГАА ЗОХИЦУУЛАЛТ:

Эрүүл мэнд:

- **"Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд Үндэсний хөтөлбөр (2016-2020)"**-т нөхөн үржихүйн эрүүл мэндийн өвөрмөц хэрэгцээ, тухайлбал үргүйдэл, цэвэршилт, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудал орхигдсон байна.

Боловсрол:

- Одоогоор нарийн зөрчилтэй зохицуулалт байхгүй байна. Гэхдээ Боловсролын салбарын хууль эрх зүйн орчны нарийвчилсан судалгааг зайлшгүй хийх шаардлагатай байгаа нь ажиглагдлаа.
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиар хэвшмэл ойлголтыг халах асуудлыг зохицуулсан хэдий ч энэ талаар Боловсролын салбарт хэрхэн тусгах талаар зохицуулалт байхгүй байна.

Гэрлэлт, гэр бүлийн харилцаа:

- **"Гэр бүлийн тухай хууль"-ийн (1999)** 40-р зүйл буюу Тэтгэлгийн хэмжээ тогтоохдоо насны байдлыг харгалзан 2 байдлаар тогтоодог бөгөөд үүнд "11 хүртэлх насны хүүхдэд тухайн бүс нутагт тогтоосон амьжиргааны доод түвшний 50%- иар", 11-16 нас (суралцаж байгаа бол 18 нас)-тай болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдэд амьжиргааны доод түвшний хэмжээгээр тогтоодог.
- **"Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль" (2010)** нь гэр бүл цуцлалтын холбоотой нэхэмжлэл гаргахад 70200 төгрөгний хураамжийг төлдөг. Үүнийг шүүх эрх мэдлийн байгууллагууд гэр бүл цуцлалтын хэрэг дээр харилцан адилгүй, хураамж тооцон авч байна.



АСУУДАЛ ҮҮСЭХЭД НӨЛӨӨЛЖ БАЙГАА ХҮЧИН ЗҮЙЛС:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудалд нөлөөлж байгаа хүчин зүйлс :

Хууль, эрх зүйн зохицуулалт:

- Иргэд олноор үйлчлүүлдэг аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн нөхөн үржихүйн кабинетад тулгуур эрхтний бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд тохирсон хүртээмжтэй үзлэгийн ор, харааны болон сонсголын бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн онцлогт тохирсон угтах үйлчилгээ, дохионы хэлмэрч, орчуулагч байдаггүй. Мөн нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын бүртгэл, мэдээлэлд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдтэй холбоотой асуулт ордоггүй тул дээрх эмэгтэйчүүд ямар төрлийн үйлчилгээг илүү авдаг, жилд хэдэн эмэгтэй үйлчилгээнд хамрагдаж буй талаар тоон мэдээлэл улсын хэмжээнд гардаггүй байна. Энэ төрлийн судалгаа, тоо баримт байхгүй тул тухайн асуудлаар бодлого, төлөвлөлт хийдэггүй, улмаар тэдний онцлог хэрэгцээнд тохирсон үйлчилгээ үзүүлж чаддаггүй байна (Хүний эрхийн үндэсний комисс, 2019, х.69)

Соёл, уламжлал болон нийгмийн хүчин зүйлс:

- Хөгжлийн бэрхшээлтэй залуучууд, эмэгтэйчүүдийг бэлгийн харилцаанд орох шаардлагагүй, хүүхэд төрүүлэх, гэрлэх боломжгүй, чадваргүй гэх үзэл тэдний мэдээлэл авах, хүчирхийллээс ангид байх, найдвартай, аюулгүй нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломжийг нь хязгаарладаг ажээ. Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст халамжийн үйлчилгээг хүргэхдээ гэр бүлийнхэнд нь даатгах, тэднийг асран хамгаалагчид мөнгөн тэтгэмж олгох зэрэг хэлбэрээр хэрэгжүүлдэг учраас хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрт хамаарах асуудлаар шийдвэр гаргах, бие даан амьдрах, гэр бүлтэй болох, бэлгийн хамтрагчтай байх, хүүхэд төрүүлэх, эцэг эх байх эрхээ эдлэхэд гэр бүлийн гишүүд хөндлөнгөөс нөлөөлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрхийг хангах нь төрийн үүрэг тул тулгамдаж буй асуудлыг тоо баримт, судалгааны үндэслэлтэйгээр баримтжуулж, бодлого тодорхойлогч, шийдвэр гаргагч, олон нийтийн анхааралд хүргэх шаардлагатай байгааг ХЭҮК онцолжээ (Хүний эрхийн үндэсний комисс, 2019, х.69)



2015-2019 ОНД МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

МУ-ын Засгийн газрын түвшинд хэрэгжүүлсэн үйл ажиллагааг нэгд бодлогын орчныг сайжруулах чиглэлээр, хоёрт төсөв, гуравт сургалт, дөрөвт судалгаа гэсэн ангиллаар төрийн холбогдох байгууллагуудаас ирүүлсэн мэдээллийг нэгтгэв. Нийт нэр бүхий 11 газарт мэдээлэл хүссэн албан тоотыг хургүүлсэн ба үүнээс 10 газар нь хариу ирүүлсэн. Хүний эрхийн үндэсний комисс ямар нэгэн хариу өгөөгүй байна.

Нэрс	Бодлогын орчинг сайжруулах чиглэлээр				Төсөв				Сургалт				Судалгаа		
	ЭМ	БО	ГЭГБ	ЭМ	ЭМ	БО	ГЭГБ	БО	ЭМ	ЭМ	БО	ГЭГБ	ЭМ	БО	ГЭГБ
1 ХЗДХЯ, МУ-д ГХУСАЗЗ	×	×	×	×	×	×	×	×	×	×	×	×	×	×	×
2 ХНХЯ	×	×	×	×	×	×	×	×	×	×	×	×	×	×	×
3 ЭМЯ	✓	×	×	✓	×	×	×	×	×	×	×	×	×	×	×
4 БСШУСЯ	×	✓	×	×	×	×	×	✓	×	×	×	×	×	✓	×
5 ШЕЗ	×	×	×	×	×	×	×	×	×	×	×	×	×	×	×
6 УЕПГ	×	×	×	×	×	×	×	×	×	×	×	×	×	×	×
7 ЦЕГ	×	×	×	×	×	×	×	×	×	×	×	×	×	×	✓
8 ГБХЗХГ	×	×	×	×	×	×	×	×	×	×	×	×	×	×	×
9 ХБХЕГ	×	×	×	×	×	×	×	×	×	×	×	×	×	×	×
10 ЖҮХ	×	×	×	×	×	×	×	×	×	×	×	×	×	×	×
11 ХЭҮК	Мэдээлэл ирүүлээгүй														


ЭМ=Эрүүл мэнд, БО=Боловсрол, ГЭГБ=Гэрлэлт, гэр бүл
 ✓ Тийм
 ✗ Үгүй





БАРИМТЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН:

Гэрлэлт, гэр бүлийн харилцаа





БАРИМТЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН:
Эмэгтэйчүүдийн боловсролын асуудал





БАРИМТЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН:
Эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудал



ДҮГНЭЛТ:

ЭРҮҮЛ МЭНД

1. Эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндтэй холбоотойгоор анхаарал хандуулах шаардлагатай асуудал бол 20-оос доош насны охидын жирэмслэлт үр хөндөлт нэмэгдэж байгаа явдал юм. Булган, Өмнөговь, Дархан-Уул аймгуудад энэ тоо бусад аймагтай харьцуулахад анхаарал татахуйц их байна.
2. Эмэгтэйчүүдийн дундах жирэмслэлтээс хамгаалах арга хэрэгслийн хэрэглээ нийслэл, сум, багт ялгаатай байгаа төдийгүй аймгаар нь авч үзэхэд ч анхаарч судлахаар харагдаж байна.
3. БЗДХ бусад өвчлөлийн дотор хамгийн өндөр байгаа ба эмэгтэйчүүд илүүтэй өртөмтгий байна.
4. Мөн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрх хангагдаагүй, тэд онцлог хэрэгцээндээ тохирсон НҮЭМ-ийн тусламж үйлчилгээ, сургалт мэдээлэл авч чадахгүй байна.
5. Хууль тогтоомж болон үндэсний хөтөлбөрүүдийн хоорондын уялдаа, хөтөлбөр хэрэгжүүлэх санхүүжилт тодорхой бус байгаагаас эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалах бодлогын хэрэгжилтийн үр нөлөө хангалтгүй байна.
6. Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, ялангуяа алслагдсан орон нутагт амьдарч байгаа хөдөөгийн эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудалд анхаарал хандуулах шаардлагатай байна.

ГЭРЛЭЛТ

1. Иргэний журмаар шүүхэд гэр бүл цуцлалтын асуудлаар хандахад улсын тэмдэгтийн хураамжийг харилцан адилгүй тооцохын зэрэгцээ хүн тус бүрээр нь хураамж тооцон нэхэмжлэлийг авч байна.
2. Шүүхээс хүүхдийн тэтгэмж тогтоох нөхөн төлүүлэх шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагаа хангалтгүй байна.

БОЛОВСРОЛ

1. Эмэгтэйчүүдийн боловсролын түвшин өндөр боловч бизнесийн салбарт эмэгтэйчүүдийн оролцоо бага, албан бус салбарт эмэгтэйчүүд олноор ажиллаж, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо хуульд заасан квотын хэмжээнд хүрэхгүй байна. Энэ нь нэг талаас эмэгтэйчүүд боловсрол эзэмших, ур чадвараа нэмэгдүүлэх боломжийг хязгаарлаагүй албан боловсролоос гадна тэдний нийгэм-эдийн засгийн чадавх, ур чадварыг нэмэгдүүлэхэд насан туршийн боловсрол буюу албан бус боловсрол хэрэгтэй байж болохыг харуулж байна.
2. Боловсролын үр өгөөж эмэгтэйчүүдэд ямар байгааг тодорхойлохын тулд боловсролын бүх салбарын статистик мэдээллийг хүйсээр ангилах, бусад нийгмийн салбарын үзүүлэлтүүдтэй харьцуулан хангалттай түвшинд судлах шаардлагатай байна.
3. Боловсролын салбарт хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүдийн стратегийн зорилт, суурь зарчимд тэгш байдал, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах үзэл санаа, жендер, жендерийн мэдрэмжтэй төлөвлөлт, дүн шинжилгээний талаар тусгагдахгүй байна.



ЗӨВЛӨМЖ

ЭМЭГТЭЙЧҮҮД ЭРҮҮЛ МЭНД

Бодлогын орчин сайжруулах чиглэлээр:

1. Хууль тогтоомж болон үндэсний хөтөлбөрүүдийн хоорондын уялдаа сул, хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилт тодорхой бус байгааг анхаарч, сайжруулах;
2. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн хэрэгцээнд тохирсон НҮЭМ-ийн тусламж үйлчилгээг бий болгох;
3. Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж хөдөө, орон нутагт тэгш бус байгааг анхаарч хөдөөд мэргэшсэн боловсон хүчнийг ажиллуулах нөхцөл, боломж, хангамжийг бүрдүүлэх;
4. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг малчин эмэгтэйчүүдийн хэрэгцээнд нийцүүлэн хүргэх боломжийг бүрдүүлэх;
5. Алслагдсан орон нутагт амьдарч байгаа хөдөөгийн эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудалд анхаарал хандуулах. Тэдэнд эрүүл мэндийн иж бүрэн оношилгооны явуулын үйлчилгээ үзүүлэх, аймгуудыг орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангах, алслагдсан сум, багийн малчин эмэгтэйчүүдэд урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэг, тогтмол хийх.

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН БОЛОВСРОЛ

1. Боловсролын үр өгөөж эмэгтэйчүүдэд ямар байгааг тодорхойлохын тулд боловсролын бүх салбарын статистик мэдээллийг бусад нийгмийн салбарын үзүүлэлтүүдтэй харьцуулан судлах
2. Боловсролын салбарын бодлогыг бусад хөгжлийн бодлоготой нийцүүлэх, нүүдлийн уламжлалт малчин хүний эрхэд суурилсан хандлагаар өөрчлөн боловсруулах судалгаа, үнэлгээний ажил эхлүүлэх
3. Боловсролын салбарт хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүдийн стратегийн зорилт, суурь зарчимд тэгш байдал, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах үзэл санаа, жендер, жендерийн мэдрэмжтэй төлөвлөлт, дүн шинжилгээ, жендерийн хэвшмэл ойлголтыг арилгах агуулга тусгах, хэрэгжүүлэх.
4. Нүүдлийн уламжлалт мал аж ахуй, хүүхдийн насны онцлогт нийцүүлэн одоогийн бага ангийн боловсрол олгох тогтолцоог сайжруулах, сургалтын олон талт хэлбэрийг хөгжүүлэх
5. Боловсролын салбар дахь охид, эмэгтэйчүүдийн эрхийн зөрчилтэй холбоотой тоо мэдээллийг бүртгэдэг болох, түүнийгээ боловсролын болон бусад салбарын бодлого төлөвлөлтөд тусгах

ГЭРЛЭЛТ, ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦАА

1. Гэр бүлийн хөгжлийг дэмжсэн төрийн бодлогыг тодорхой болгох, бодлогыг хэрэгжүүлэх төсвийг батлан хуваарилах;
2. 1999 оны “Гэр бүлийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгыг яаралтай батлуулах;
3. Хүүхдийн тэтгэлгийн хэмжээг эцэг, эхийн цалин, орлогын тодорхой хувиас тооцох, хамгийн багадаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр нас харгалзахгүй олгож байхаар хуульчлах. Мөн тусгай

хэрэгцээтэй хүүхдэд нэмэгдэл тэтгэвэр олгох хувилбарыг судлах;

4. Гэр бүлийн хүчирхийллийн мөн хүүхдийн тэтгэвэр тогтоолгохтой холбоотой нэхэмжлэлийг улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх;
5. Гэрлэлтээ цуцлуулахаар шүүхэд хандсан хэргийн оролцогчид ялангуяа хүүхдийн эрх ашиг хөндөгдөн гарч байгаа үед хүүхдийн байцаагчийг Гэр бүл цуцлалттай холбоотой нэхэмжлэлийг хянан шийдвэрлэгдэж дуустал нь хүүхдийн эрхийг хамгаалан ажиллах эрх зүйн орчин бүрдүүлэх.



ХАВСРАЛТ 1: СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ

АСУУДАЛ: ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ

1. Баримтын судалгааны аргачлал:

1.1 Бодлогын баримтын шинжилгээ

Конвенцийн заалт	Үндэсний хууль тогтоомж/ Үндэсний хөтөлбөр	Зорилгод хүрсэн байдал	Практикт нийцэж байгаа байдал		
			Эерэг үр дагавар (заалт тусгах)	Сөрөг үр дагавар (заалт тусгах)	Хүндрэл, бэрхшээл (Жишээгээр тодорхойлж гаргах)

1.2 Судалгааны тайлангуудын шинжилгээ

Гэр бүлийн хүчирхийлэл:

Гол асуулт	Дэд асуулт
Гэр бүлийн хүчирхийллийн өнөөгийн нөхцөл байдал	Үндэсний хэмжээнд
	Орон нутгийн хэмжээнд
	Малчин эмэгтэйчүүд
	Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд
	Бэлгийн цөөнх эмэгтэйчүүд
	Эмзэг бүлгийн эмэгтэйчүүд/казак, ахмад настай, амьжиргааны түвшингээс доогуур орлоготой/
Конвенцийг хэрэгжүүлэх хэрэгжилтийг хангахад ЗГ-ын хийсэн ажил (2015-2019)	Асуудлыг шийдвэрлэхийн тулд төр ямар үйлчилгээ үзүүлж байна вэ?
	Үйлчилгээ үзүүлж байгаа ТББ-уудын магадлан итгэмжлэл, түншлэгч ТББ-уудтай хэрхэн хамтран ажиллаж байгаа тухай мэдээлэл
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд
	Эмзэг бүлгийн эмэгтэйчүүд /казак, ахмад настан, амьжиргааны түвшингээс доогуур орлоготой/
	Бэлгийн цөөнх
	Бодлогын орчинд гарсан өөрчлөлт
	Улсын төсөвт санхүүжилт тусгагдсан эсэх
	Хүний нөөцийн сургалт, чадавхижуулалт
	Нэг цэгийн үйлчилгээний хүртээмж, хангалттай байдал
	Хамгаалах байрны хүртээмж

Эмэгтэйчүүдийн хүний эрхийн зөрчилтэй холбоотой тоон мэдээ (2015-2019)	Цагдаагийн байгууллагын тоо
	Прокурорын байгууллагын тоо
	Шүүхийн тоо
	ХЭҮК-т хандсан гомдлын тоо (АББД, Эмэгтэйчүүдийн эрхтэй холбоотой гомдлын тоо)
	Төрийн бус байгууллагын тоон мэдээлэл
Эмэгтэйчүүдийн хүний эрхийг хэрэгжүүлэхэд тулгарч буй саад бэрхшээл	Соёл уламжлал
	Хууль, эрх зүйн зохицуулалт
	Нийгэм
	Баримт, кейс
Судалгааны дүгнэлт, зөвлөмж	

Хүн худалдаалах гэмт хэрэг

Гол асуулт	Дэд асуулт
Хүн худалдаалах гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал	Үндэсний хэмжээнд
	Орон нутгийн хэмжээнд
	Малчин эмэгтэйчүүд
	Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд
	Бэлгийн цөөнх эмэгтэйчүүд
	Эмзэг бүлгийн эмэгтэйчүүд/казак, ахмад настай, амьжиргааны түвшингээс доогуур орлоготой/
Конвенцийг хэрэгжүүлэх хэрэгжилтийг хангахад ЗГ-ын хийсэн ажил (2015-2019)	Асуудлыг шийдвэрлэхийн тулд төр ямар үйлчилгээ үзүүлж байна вэ?
	Үйлчилгээ үзүүлж байгаа ТББ-уудын магадлан итгэмжлэл, түншлэгч ТББ-уудтай хэрхэн хамтран ажиллаж байгаа тухай мэдээлэл
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд
	Эмзэг бүлгийн эмэгтэйчүүд /казак, ахмад настан, амьжиргааны түвшингээс доогуур орлоготой/
	Бэлгийн цөөнх
	Бодлогын орчинд гарсан өөрчлөлт
	Улсын төсөвт санхүүжилт тусгагдсан эсэх
	Хүний нөөцийн сургалт, чадавхижуулалт
	Нэг цэгийн үйлчилгээний хүртээмж, хангалттай байдал
	Хамгаалах байрны хүртээмж

Эмэгтэйчүүдийн хүний эрхийн зөрчилтэй холбоотой тоон мэдээ (2015-2019)	Цагдаагийн байгууллагын тоо
	Прокурорын байгууллагын тоо
	Шүүхийн тоо
	ХЭҮК-т хандсан гомдлын тоо (АББД, Эмэгтэйчүүдийн эрхтэй холбоотой гомдлын тоо)
	Төрийн бус байгууллагын тоон мэдээлэл
Эмэгтэйчүүдийн хүний эрхийг хэрэгжүүлэхэд тулгарч буй саад бэрхшээл	Соёл уламжлал
	Хууль, эрх зүйн зохицуулалт
	Нийгэм
	Баримт, кейс
Судалгааны дүгнэлт, зөвлөмж	

Ажлын байран дахь бэлгийн дарамт

Гол асуулт	Дэд асуулт
Ажлын байран дахь бэлгийн дарамтын өнөөгийн нөхцөл байдал	Үндэсний хэмжээнд
	Орон нутгийн хэмжээнд
	Малчин эмэгтэйчүүд
	Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд
	Бэлгийн цөөнх эмэгтэйчүүд
	Эмзэг бүлгийн эмэгтэйчүүд/казак, ахмад настай, амьжиргааны түвшингээс доогуур орлоготой/
Конвенцийг хэрэгжүүлэх хэрэгжилтийг хангахад ЗГ-ын хийсэн ажил (2015-2019)	Асуудлыг шийдвэрлэхийн тулд төр ямар үйлчилгээ үзүүлж байна вэ?
	Үйлчилгээ үзүүлж байгаа ТББ-уудын магадлан итгэмжлэл, түншлэгч ТББ-уудтай хэрхэн хамтран ажиллаж байгаа тухай мэдээлэл
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд
	Эмзэг бүлгийн эмэгтэйчүүд /казак, ахмад настан, амьжиргааны түвшингээс доогуур орлоготой/
	Бэлгийн цөөнх
	Бодлогын орчинд гарсан өөрчлөлт
	Улсын төсөвт санхүүжилт тусгагдсан эсэх
	Хүний нөөцийн сургалт, чадавхижуулалт
	Нэг цэгийн үйлчилгээний хүртээмж, хангалттай байдал
	Хамгаалах байрны хүртээмж
Эмэгтэйчүүдийн хүний эрхийн зөрчилтэй холбоотой тоон мэдээ (2015-2019)	Цагдаагийн байгууллагын тоо
	Прокурорын байгууллагын тоо
	Шүүхийн тоо

	ХЭҮК-т хандсан гомдлын тоо (АББД, Эмэгтэйчүүдийн эрхтэй холбоотой гомдлын тоо)
	Төрийн бус байгууллагын тоон мэдээлэл
Эмэгтэйчүүдийн хүний эрхийг хэрэгжүүлэхэд тулгарч буй саад бэрхшээл	Соёл уламжлал
	Хууль, эрх зүйн зохицуулалт
	Нийгэм
	Баримт, кейс
Судалгааны дүгнэлт, зөвлөмж	

Бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх гэмт хэрэг

Гол асуулт	Дэд асуулт
Бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал	Үндэсний хэмжээнд
	Орон нутгийн хэмжээнд
	Малчин эмэгтэйчүүд
	Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд
	Бэлгийн цөөнх эмэгтэйчүүд
	Эмзэг бүлгийн эмэгтэйчүүд/казак, ахмад настай, амьжиргааны түвшингээс доогуур орлоготой/
Конвенцийг хэрэгжүүлэх хэрэгжилтийг хангахад ЗГ-ын хийсэн ажил (2015-2019)	Асуудлыг шийдвэрлэхийн тулд төр ямар үйлчилгээ үзүүлж байна вэ?
	Үйлчилгээ үзүүлж байгаа ТББ-уудын магадлан итгэмжлэл, түншлэгч ТББ-уудтай хэрхэн хамтран ажиллаж байгаа тухай мэдээлэл
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд
	Эмзэг бүлгийн эмэгтэйчүүд /казак, ахмад настан, амьжиргааны түвшингээс доогуур орлоготой/
	Бэлгийн цөөнх
	Бодлогын орчинд гарсан өөрчлөлт
	Улсын төсөвт санхүүжилт тусгагдсан эсэх
	Хүний нөөцийн сургалт, чадавхижуулалт
	Нэг цэгийн үйлчилгээний хүртээмж, хангалттай байдал
	Хамгаалах байрны хүртээмж
Эмэгтэйчүүдийн хүний эрхийн зөрчилтэй холбоотой тоон мэдээ (2015-2019)	Цагдаагийн байгууллагын тоо
	Прокурорын байгууллагын тоо
	Шүүхийн тоо
	ХЭҮК-т хандсан гомдлын тоо (АББД, Эмэгтэйчүүдийн эрхтэй холбоотой гомдлын тоо)
	Төрийн бус байгууллагын тоон мэдээлэл

Эмэгтэйчүүдийн хүний эрхийг хэрэгжүүлэхэд тулгарч буй саад бэрхшээл	Соёл уламжлал
	Хууль, эрх зүйн зохицуулалт
	Нийгэм
	Баримт, кейс
Судалгааны дүгнэлт, зөвлөмж	

2. Чанарын судалгаа:

Ганцаарчилсан ярилцлагын чиг асуултууд

Эрх зүйн орчин:

1. “Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай” Конвенцын талаар Та хэр сайн мэдэх вэ? Мэддэг бол шийдвэр гаргах үйл ажиллагаанд эх сурвалж болгон авч хэрэгжүүлдэг үү?
2. Эмэгтэйчүүдийн хүний эрхийг хангах чиглэлээр МУ-ын ЗГ-ын авч хэрэгжүүлж буй бодлогын талаар та хэр сайн мэдэх вэ? Энэ талаар та ямар санал, бодолтой байдаг вэ?
3. ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж буй ажлаас дурдана уу? Эдгээр үйл ажиллагаа нь хэр үр дүнтэй байдаг гэж та боддог вэ? Хэрэв хангалттай биш бол хэрхэн сайжруулж болох вэ?
4. Гэр бүлийн хүчирхийлэл, хүн худалдаалах, ажлын байран дахь бэлгийн дарамт, бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх гэмт хэрэгтэй тэмцэж буй эрх зүйн орчин хангалттай, үр дүнтэй байна гэж бодож байна уу?
 - Тийм бол дурдана уу?
 - Үгүй бол яагаад?
5. Засгийн газар жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэхэд санаачилгатай ажиллаж байгаа юу? Таны бодол?
 - Салбар дундын бодлого тодорхой болсон эсэх
 - Салбар дундын бодлогыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагааны төсөв хангалттай байдаг уу. Тусгайлан улсын төсөв батлагдсан уу?
 - Салбар дундын бодлогыг сайжруулахын тулд юу хийх шаардлагатай вэ гэж бодож байна вэ?
6. Хүчирхийлэл үйлдэгчид хүлээлгэж буй хуулийн хариуцлага оновчтой байж чадаж байна уу? Хэрэв үгүй бол аль хуулийн ямар зохицуулалтыг яаж өөрчилбөл зохимжтой вэ?

Үйлчилгээ:

7. Жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөн хохирогч нарт үзүүлдэг үйлчилгээг та хэрхэн үнэлэх вэ?

8. Үйлчилгээ үзүүлэх орчин, бодлого тодорхой байдаг уу?
9. Хохирогчдод цогц нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлж чадаж байгаа юу? Үгүй бол яагаад?
10. Хохирогч нарт үзүүлэх үйлчилгээнд төрөөс санхүүгийн дэмжлэг хангалттай юу? Хангалтгүй байгаа бол яагаад?
11. Хохирогчидтой ажиллах боловсон хүчний нөөц хангалттай юу? Мэргэшсэн хүний нөөц байгаа юу?

Хэргийн шийдвэрлэлт:

12. Гэр бүлийн хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын хэргийн шийдвэрлэлтийн талаарх тодруулах
 - Зөрчил, гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа явуулахад тулгардаг хүндрэл бэрхшээл юу вэ?
 - Гэмт хэрэгтэнд оногдуулж буй ял шийтгэлийн оновчтой эсэх талаар таны бодол
 - Энэ төрлийн гэмт хэргийн хохирогчдын талаар ямар бодолтой байдаг вэ? Тэд өөрсдийгөө хамгаалах боломжтой юу? Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, хөдөө орон нутгийн иргэд зэрэг онцлог бүлгүүдийн хэрэгцээ ялгаатай байдаг уу?
 - Хохирогч хамгааллын бодлого оновчтой байна уу? Үгүй бол хэрхэн сайжруулах вэ?
 - Хэргийн шийдвэрлэлтэд зарцуулж буй хугацаа

Цаашид авах арга хэмжээ:

13. Эдгээр зөрчил, гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ялангуяа шүүх эрх мэдэл болон хууль сахиулах байгууллага, төрийн захиргааны байгууллагын зүгээс сайжруулахад юу хийх хэрэгтэй вэ?
 - Эрх зүйн орчны хувьд
 - Салбар дундын бодлогын хувьд
14. Судалгаатай холбоотойгоор танд өөр нэмж хэлэх санал юу байна вэ?

Чанарын мэдээлэлд дүн шинжилгээ хийх загвар:

	Төрийн байгууллага	Төрийн бус байгууллага	Хохирогч
Эрх зүйн орчин			
Тусламж, үйлчилгээ			
Хэргийн шийдвэрлэлт			
Цаашид анхаарах асуудал			
Дүгнэлт:			
Санал, зөвлөмж			

АСУУДАЛ: ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИН ДЭХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦОО

1. Баримтын судалгааны аргачлал:

1.1 Бодлогын баримтын шинжилгээ

Конвенцийн заалт	Үндэсний хууль тогтоомж/ Үндэсний хөтөлбөр	Зорилгод хүрсэн байдал	Практикт нийцэж байгаа байдал		
			Эерэг үр дагавар (заалт тусгах)	Сөрөг үр дагавар (заалт тусгах)	Хүндрэл, бэрхшээл (Жишээгээр тодорхойлж гаргах)

1.2 Судалгааны тайлангуудын шинжилгээ

Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо:

Гол асуулт	Дэд асуулт
Өнөөгийн нөхцөл байдал	Үндэсний хэмжээнд шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо
	Орон нутгийн хэмжээнд шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо
	Хөдөө орон нутаг, малчин эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо
	Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо
	Бэлгийн цөөнх эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо
	Эмзэг бүлгийн эмэгтэйчүүд/казак, ахмад настай, амьжиргааны түвшингээс доогуур орлоготой/-ийн улс төрийн оролцоо
Конвенцийг хэрэгжүүлэх хэрэгжилтийг хангахад ЗГ-ын хийсэн ажил (2015-2019)	Парламентийн гишүүн эмэгтэйчүүдийн тоо, сонгуульд нэр дэвших жагсаалтанд эмэгтэйчүүдийн эзлэх тоог нэмэгдүүлэх чиглэлээр
	Олон нийтийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр
	Хүний нөөцийн сургалт, чадавхижуулах чиглэлээр
	Бэлгийн цөөнх эмэгтэйчүүдийн оролцоог хангах
	Эмзэг бүлгийн эмэгтэйчүүд/казак, ахмад настай, амьжиргааны түвшингээс доогуур орлоготой/-ийн улс төрийн оролцоог хангах
Эмэгтэйчүүдийн хүний эрхийг хэрэгжүүлэхэд тулгарч буй саад бэрхшээл	Соёл уламжлал
	Хууль, эрх зүйн зохицуулалт
	Нийгэм
	Баримт, кейс
Судалгааны дүгнэлт, зөвлөмж	

Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах үндэсний тогтолцоо:

Гол асуулт	Дэд асуулт
Өнөөгийн нөхцөл байдал	Үндэсний хэмжээнд
	Орон нутгийн хэмжээнд
	Малчин эмэгтэйчүүд
	Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд
	Бэлгийн цөөнх эмэгтэйчүүд
	Эмзэг бүлгийн эмэгтэйчүүд/казак, ахмад настай, амьжиргааны түвшингээс доогуур орлоготой/
Конвенцийг хэрэгжүүлэх хэрэгжилтийг хангахад ЗГ-ын хийсэн ажил (2015-2019)	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, ахицын талаар
	Жендэрийн үндэсний хорооны санхүүжилтийг бэхжүүлэх чиглэлээр
	Жендэрийн үндэсний хорооны хүний нөөцийг бэхжүүлэх чиглэлээр
	Жендэрийн үндэсний хорооны техникийн чадавхийг бэхжүүлэх чиглэлээр
	Соёл уламжлал
Эмэгтэйчүүдийн хүний эрхийг хэрэгжүүлэхэд тулгарч буй саад бэрхшээл	Хууль, эрх зүйн зохицуулалт
	Нийгэм
	Баримт, кейс
	Баримт, кейс
	Судалгааны дүгнэлт, зөвлөмж
	Баримт, кейс
Судалгааны дүгнэлт, зөвлөмж	

2. Чанарын судалгаа

Фокус бүлгийн ярилцлагын чиг асуултууд

Тогтолцоо:

- Манай улс Үндсэн хууль, ЖЭТБХТ хууль, ЖЭТБХ Үндэсний хөтөлбөр зэрэг баримт бичгийн хүрээнд улс төрийн болон төрийн захиргаа, төрийн тусгай албанд эмэгтэйчүүдийн оролцоог 10-30% хүртэлх квоттой байдаг ч энэ зорилтондоо бид хүрч чадахгүй байна. Өмнөх судалгаануудын үр дүн эмэгтэйчүүдтэй холбоотой нийгэм дэх тогтсон хандлага, тэдний эдийн засгийн чадавх, нам доторх дэмжлэг бага зэрэг шалтгаан үүнд нөлөөлж байгааг харуулсан байна. Та бүхний бодлоор уг бодлогыг хэрэгжүүлэхэд эдгээрээс өөр ямар нэгэн саад, бэрхшээл байдаг болов уу?
- Орон нутагтаа амьдардаг эмэгтэйчүүд яагаад УИХ-д нэр дэвшиж чаддаггүй гэж та бодож байна вэ?
- Орон нутагт квот тогтоох хэрэгтэй гэж та бодож байна уу?
 - Тийм бол яагаад,
 - Үгүй бол яагаад

3. Үүнээс үүсэх эерэг болон сөрөг талыг тодруулах

Намын дотоод дэмжлэг:

4. Нам дотор эмэгтэйчүүдийн оролцоо, дэмжлэг бага байгаа нь тогтсон хандлага, хөрөнгө санхүүгийн боломжоос өөр ямар шалтгаантай байж болох вэ?
5. Нам доторх эмэгтэйчүүдийн бодит оролцоог нэмэгдүүлэх, оролцуулахын тулд хэн, юу хийх ёстой вэ?
 1. Бодлогын орчинд
 2. Намын орчинд
 3. Олон нийтийн хандлага

Ур чадварыг дэмжих тухай:

6. Эмэгтэй нэр дэвшигчид ямар дэмжлэг хэрэгтэй байдаг бол?
 1. Ур чадварын хувьд
 2. Нийгмийн дэмжлэгийн хувьд
 3. Эдийн засгийн хувьд
 4. Олон бүлгийн төлөөллийг дэмжихийн тулд
7. Эдгээр дэмжлэгийг бодитоор бий болгох ямар боломж, гарц өнөөгийн нөхцөлд байна гэж та бодож байна вэ?
8. Олон янзын бүлгийн төлөөллийг (ХБ, ЛГБТИ, Малчин гэх мэт) орон нутгийн болон УИХ шийдвэр гаргах түвшинд оролцуулахад тулгамдаж буй асуудал юу байна вэ?
9. Судалгаатай холбоотойгоор танд өөр нэмж хэлэх санал юу байна вэ?

Ганцаарчилсан ярилцлагын чиг асуултууд

Тогтолцоо:

1. Манай улс Үндсэн хууль, ЖЭТБХТ хууль, ЖЭТБХ Үндэсний хөтөлбөр зэрэг баримт бичгийн хүрээнд улс төрийн болон төрийн захиргаа, төрийн тусгай албанд эмэгтэйчүүдийн оролцоог 10-30% хүртэлх квоттой байдаг ч энэ зорилтондоо бид хүрч чадахгүй байна. Өмнөх судалгаануудын үр дүн эмэгтэйчүүдтэй холбоотой нийгэм дэх тогтсон хандлага, тэдний эдийн засгийн чадавх, нам доторх дэмжлэг бага зэрэг шалтгаан үүнд нөлөөлж байгааг харуулсан байна. Та бүхний бодлоор уг бодлогыг хэрэгжүүлэхэд эдгээрээс өөр ямар нэгэн саад, бэрхшээл байдаг болов уу?
2. Орон нутагтаа амьдардаг эмэгтэйчүүд яагаад УИХ-д нэр дэвшиж чаддаггүй гэж та бодож байна вэ?
3. Орон нутагт квот тогтоох хэрэгтэй гэж та бодож байна уу?
 1. Тийм бол яагаад,
 2. Үгүй бол яагаад
 3. Үүнээс үүсэх эерэг болон сөрөг талыг тодруулах

Намын дотоод дэмжлэг:

4. Нам дотор эмэгтэйчүүдийн оролцоо, дэмжлэг бага байгаа нь тогтсон хандлага, хөрөнгө санхүүгийн боломжоос өөр ямар шалтгаантай байж болох вэ?
5. Нам доторх эмэгтэйчүүдийн бодит оролцоог нэмэгдүүлэх, оролцуулахын тулд хэн, юу хийх ёстой вэ?
 1. Бодлогын орчинд
 2. Намын орчинд
 3. Олон нийтийн хандлага

Ур чадварыг дэмжих тухай:

6. Эмэгтэй нэр дэвшигчид ямар дэмжлэг хэрэгтэй байдаг бол?
 1. Ур чадварын хувьд
 2. Нийгмийн дэмжлэгийн хувьд
 3. Эдийн засгийн хувьд
 4. Олон бүлгийн төлөөллийг дэмжихийн тулд
7. Эдгээр дэмжлэгийг бодитоор бий болгох ямар боломж, гарц өнөөгийн нөхцөлд байна гэж та бодож байна вэ?
8. Олон янзын бүлгийн төлөөллийг (ХБ, ЛГБТИ, Малчин гэх мэт) орон нутгийн болон УИХ шийдвэр гаргах түвшинд оролцуулахад тулгамдаж буй асуудал юу байна вэ?
9. Судалгаатай холбоотойгоор танд өөр нэмж хэлэх санал юу байна вэ?

Экспертийн ярилцлага

1. Манай улс Үндсэн хууль, ЖЭТБХТ хууль, ЖЭТБХ Үндэсний хөтөлбөр зэрэг баримт бичгийн хүрээнд улс төрийн болон төрийн захиргаа, төрийн тусгай албанд эмэгтэйчүүдийн оролцоог 10-30% хүртэлх квоттой байдаг ч энэ зорилтондоо бид хүрч чадахгүй байна. Өмнөх судалгаануудын үр дүн эмэгтэйчүүдтэй холбоотой нийгэм дэх тогтсон хандлага, тэдний эдийн засгийн чадавх, нам доторх дэмжлэг бага зэрэг шалтгаан үүнд нөлөөлж байгааг харуулсан байна. Та бүхний бодлоор уг бодлогыг хэрэгжүүлэхэд эдгээрээс өөр ямар саад, бэрхшээл байдаг вэ?
2. Суудлын квот хадгалах нь эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшин дэх оролцоог баталгаажуулах нэг арга байх боломжтой юу?
 1. Хэрэв тийм бол хэрхэн баталгаажуулах боломжийн тухай асууна
 2. Хэрэв үгүй бол яагаад гэдгийг тодруулах
3. Эмэгтэйчүүдийн эрхийг хангахтай холбоотой үндэсний тогтолцоо, механизмыг сайжруулах санал бодол. Одоогийн тогтолцоо асуудлыг бүрэн шийдвэрлэж, хамгаалж чадаж байгаа эсэх, Тусдаа бие даасан бүтэц байх хэрэгтэй эсэх
 1. Тийм бол яагаад
 2. Үгүй бол яагаад
4. Ялгаварлан гадуурхахын эсрэг бие даасан процессын хуультай болохыг юу гэж бодож байна вэ?

5. Нам дотор эмэгтэйчүүдийн оролцоо, дэмжлэг бага байгаа нь тогтсон хандлага, хөрөнгө санхүүгийн боломжоос өөр ямар шалтгаантай байж болох вэ?
6. Ялгаа бүхий бүлгүүдийн төлөөллийг (ХБИ, ЛГБТИ, малчин г.м) оролцуулах боломж юу байна вэ?
7. Нам доторх эмэгтэйчүүдийн бодит оролцоог нэмэгдүүлэхийн тулд хэн, юу хийх ёстой вэ?
 1. Бодлогын орчинд
 2. Намын орчинд
 3. Олон нийтийн хандлага
8. Эмэгтэй нэр дэвшигчдийг хэрхэн дэмжих хэрэгтэй вэ? 1. Ур чадварын хувьд
 2. Нийгмийн дэмжлэгийн хувьд
 3. Эдийн засгийн хувьд
9. Судалгаатай холбоотойгоор танд өөр нэмж хэлэх санал юу байна вэ?

Намын удирдлагатай хийх ганцаарчилсан ярилцлага

1. Манай улс Үндсэн хууль, ЖЭТБХТ хууль, ЖЭТБХ Үндэсний хөтөлбөр зэрэг баримт бичгийн хүрээнд улс төрийн болон төрийн захиргаа, төрийн тусгай албанд эмэгтэйчүүдийн оролцоог 10-30% хүртэлх квоттой байдаг ч энэ зорилтондоо бид хүрч чадахгүй байна. Өмнөх судалгаануудын үр дүн эмэгтэйчүүдтэй холбоотой нийгэм дэх тогтсон хандлага, тэдний эдийн засгийн чадавх, нам доторх дэмжлэг бага зэрэг шалтгаан үүнд нөлөөлж байгааг харуулсан байна. Та бүхний бодлоор уг бодлогыг хэрэгжүүлэхэд эдгээрээс өөр ямар саад, бэрхшээл байдаг вэ?
2. Суудлын квот хадгалах нь эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшин дэх оролцоог баталгаажуулах нэг арга байх боломжтой юу?
 1. Хэрэв тийм бол хэрхэн баталгаажуулах боломжийн тухай асууна
 2. Хэрэв үгүй бол яагаад гэдгийг тодруулах
3. Нам дотор эмэгтэйчүүдийн оролцоо, дэмжлэг бага байгаа нь тогтсон хандлага, хөрөнгө санхүүгийн боломжоос өөр ямар шалтгаантай байж болох вэ?
4. Ялгаа бүхий бүлгүүдийн төлөөллийг (ХБИ, ЛГБТИ, малчин г.м) оролцуулах боломж юу байна вэ?
5. Нам дотрох эмэгтэйчүүдийн бодит оролцоог нэмэгдүүлэхийн тулд хэн, юу хийх ёстой вэ?
 1. Бодлогын орчинд
 2. Намын орчинд
 3. Олон нийтийн хандлага
6. Эмэгтэй нэр дэвшигчдэд ямар дэмжлэг хэрэгтэй байдаг вэ?
 1. Ур чадварын хувьд
 2. Нийгмийн дэмжлэгийн хувьд
 3. Эдийн засгийн хувьд
7. Судалгаатай холбоотойгоор танд өөр нэмж хэлэх санал юу байна вэ?

Чанарын мэдээлэлд дүн шинжилгээ хийх загвар:

Улс төрийн нам	Эксперт	Нэр дэвшигч эмэгтэйчүүд (хот, хөдөө)
Тогтолцоог сайжруулах чиглэлээр		
Нам доторх дэмжлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр		
Эмэгтэйчүүдэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр		
Цаашид анхаарах асуудал		
Дүгнэлт:		
Санал, зөвлөмж		

АСУУДАЛ: ХӨДӨӨГИЙН ЭМЭГТЭЙЧҮҮД

1. Баримтын судалгааны аргачлал:

1.1 Бодлогын баримтын шинжилгээ

Конвенцийн заалт	Үндэсний хууль тогтоомж/ Үндэсний хөтөлбөр	Зорилгод хүрсэн байдал	Практикт нийцэж байгаа байдал		
			Эерэг үр дагавар (заалт тусгах)	Сөрөг үр дагавар (заалт тусгах)	Хүндрэл, бэрхшээл (Жишээгээр тодорхойлж гаргах)

1.2 Судалгааны тайлангуудын шинжилгээ

Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо:

Гол асуулт	Дэд асуулт
Орон нутгийн эмэгтэйчүүдийн өнөөгийн нөхцөл байдал	Санхүү
	Эрүүл мэнд
	Боловсрол
	Хүнсний аюулгүй байдал, хомсдол
	Байгаль орчин
	Нийгэм, гэр бүл

	Зээл, санхүүгийн дэмжлэг
	Хөгжлийн бэрхшээлтэй
	Бэлгийн цөөнх эмэгтэйчүүд
	Эмзэг бүлгийн эмэгтэйчүүд /казак, ахмад настан, амьжиргааны түвшингээс доогуур орлоготой/
	Санхүү
Малчин эмэгтэйчүүдийн өнөөгийн нөхцөл байдал	Эрүүл мэнд
	Боловсрол
	Хүнсний аюулгүй байдал, хомсдол
	Байгаль орчин
	Нийгэм, гэр бүл
	Зээл, санхүүгийн дэмжлэг
	Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд
	Бэлгийн цөөнх эмэгтэйчүүд
	Эмзэг бүлгийн эмэгтэйчүүд /казак, ахмад настан, амьжиргааны түвшингээс доогуур орлоготой/
Конвенцийг хэрэгжүүлэх хэрэгжилтийг хангахад ЗГ-ын хийсэн ажил (2015-2019)	Хөдөө орон нутгийг хөгжүүлэх стратегийг боловсруулж, түүндээ жендэрийн асуудлыг тусгах, хөдөө орон нутгийн эмэгтэйчүүдийг оролцуулах чиглэлээр авсан арга хэмжээ
	Цаг уурын өөрчлөлт, гамшгийн хариу арга хэмжээ болон эрсдэл бууруулах бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, түүндээ жендэрийн асуудлыг тусгах, хөдөө орон нутгийн эмэгтэйчүүдийг оролцуулах чиглэлээр авсан арга хэмжээ
	Уул уурхайн салбар дахь аж үйлдвэрийн үйл ажиллагаатай холбоотой бодлого, стратегийг боловсруулж, түүндээ жендэрийн асуудлыг тусгах, хөдөө орон нутгийн эмэгтэйчүүдийг оролцуулах чиглэлээр авсан арга хэмжээ
	Ядуурлыг бууруулах чиглэлээр
	Хөдөө орон нутгийн эмэгтэйчүүдийн шударга ёс, боловсрол, сургалт үйлдвэрлэлийн салбар дахь ур чадвар олгох сургалтын чиглэлээр
	Албан ёсны салбар дахь хөдөлмөр эрхлэлт, орлого олох боломж, бичил зээл, газрын эзэмшлийг сайжруулах чиглэлээр
	Хэрэгцээнд нийцсэн орон сууц, аюулгүй ундны ус, эрүүл мэндийн халамж үйлчилгээ, ариун цэвэр, эрүүл ахуйн хүртээмжийг хангах талаар авсан арга хэмжээ
	Улсын төсөвт санхүүжилт тусгагдсан эсэх
	Хүний нөөцийн сургалт, чадавхижуулалт
Эмэгтэйчүүдийн хүний эрхийн зөрчилтэй холбоотой тоон мэдээ (2015-2019)	ХЭҮК-т хандсан гомдолын тоо
	Төрийн бус байгууллагын тоон мэдээлэл
Эмэгтэйчүүдийн хүний эрхийг хэрэгжүүлэхэд тулгарч буй саад бэрхшээл	Соёл уламжлал
	Хууль, эрх зүйн зохицуулалт
	Нийгэм
	Баримт, кейс
Судалгааны дүгнэлт, зөвлөмж	

2. Чанарын судалгаа

Фокус бүлгийн ярилцлагын чиг асуултууд

1. Хөдөөгийн эмэгтэйчүүд тухайлбал Малчин эмэгтэйчүүдийн амьдралын чанарыг сайжруулах чиглэлээр ямар ямар тусгай хөтөлбөр танай орон нутагт хэрэгждэг вэ?
2. Эдгээр хөтөлбөр нь та бүхний болон танай орон нутгийн бусад малчин эмэгтэйчүүдийн амьдралын чанарт нөлөөлж үр дүнгээ өгч чадаж байна уу?
 - a. Тийм бол хэрхэн
 - b. Үгүй бол ямар учраас
3. Зуд, ган, хүний хүчин зүйлээс шалтгаалсан УА-ийн өөрчлөлттэй холбоотой байгалийн хүчин зүйлс нь малчин эмэгтэйчүүдийн амьдралын чанар буурах/муудах нэг гол хүчин зүйл болдог. Яг ийм шалтгаанаар тухайлбал та бүхэнд ямар байдлаар нөлөөлсөн жишээ юу байна вэ?
4. Ер нь байгаль орчноос өөр ямар хүчин зүйлс малчдыг ядууралд өртөхөд нөлөөлж байна вэ?
5. Эдгээр асуудлыг малчид, тэр дундаа эмэгтэйчүүд хэрхэн даван туулах, энэ эрсдэлд дахин өртөхгүй байхын тулд юу хийж чадах вэ? Ямар боломж та нарт байвал хамгийн чухал дэмжлэг болж чадах вэ?
6. Хэрэв та багийн засаг дарга/ЗД/ЗГ/УИХ байсан бол жил бүр тохиллодож байгаа эдгээр бэрхшээлтэй асуудлуудыг шийдэхийн тулд малчин эмэгтэйчүүд рүү чиглэсэн ямар ажил хийх вэ? Тэднийг ямар шийдвэр, ямар арга зам бий болгоосой гэж хүсч байна вэ?
 1. Төр
 2. Орон нутаг
 3. Малчид өөрсдөө
7. Та бүхэн өнгөрсөн 12 сарын хугацаанд ямар зорилгоор, хэдэн удаа эмнэлгээр үйлчлүүлсэн бэ? Үгүй бол ямар учраас эмнэлэгт очиж чадаагүй вэ?
8. Та бүхэн өнгөрсөн 12 сарын хугацаанд ямар нэгэн сургалт, мэдлэг, мэдээлэл олж авах үйл ажиллагаанд хамрагдсан уу? Тийм бол ямар?
9. Малчдад зориулсан эрүүл мэнд (тэр дундаа нөхөн үржихүйн эрүүл мэнд), боловсролын үйлчилгээг (зөвхөн хүүхэд, залууст биш насанд хүрсэн хүмүүст зориулсан амьдрах ухааны, аж ахуйн, бизнес эрхлэлт, байгаль орчин гэх мэт мэдлэг, боловсрол) ямар байгаасай гэж та бүхэн хүсдэг вэ?
 - Арга хэлбэрийн хувьд
 - Хүний нөөцийн хувьд
10. 10. Та бүхэн орон нутгийнхаа шийдвэр гаргах үйл явцад хэр их оролцоотой байдаг вэ?
11. Малчид идэвх оролцоо бага байдаг, гэр орны ажлаа зохицуулах боломжгүй, жолоо барих чадваргүй, гэх мэт асуудлаас шалтгаалан орон нутгийнхаа хурал, уулзалтанд очиж чаддаггүй гэж өмнө хийсэн судалгаанд дурдагдсан байсан. Та бүхний бодлоор өөр ямар хүчин зүйлс иргэдийн оролцоо, тэр дундаа эмэгтэйчүүдийн оролцоо бага байхад нөлөөлж байгаа бол?
12. Энэ нөхцөл байдлыг өөрчлөхийн тулд юу хийх хэрэгтэй юм бол? Малчин эмэгтэйчүүдийн дуу хоолойг тэдний амьдрал, аж ахуйтай холбоотой шийдвэр гаргаж байгаа хүмүүст хэрхэн хүргэх вэ?

13. Судалгаатай холбоотойгоор танд өөр нэмж хэлэх санал юу байна вэ?

Ганцаарчилсан ярилцлагын чиг асуулт

1. Хөдөөгийн эмэгтэйчүүд тэр дундаа малчин эмэгтэйчүүдийн аж амьдрал, амьдралын чанар, эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа ямар үйл ажиллагаа, хөтөлбөр байна вэ?
2. Эдгээр үйл ажиллагаа, хөтөлбөр нь танай орон нутгийн малчин өрхүүдэд үр дүнгээ өгч чадаж байна уу? Тийм бол хэрхэн, Үгүй бол ямар учраас
3. Зуд, ган гэх мэт байгалийн хүчин зүйлс нь малчин өрхөд амьжиргаа буурах нэг хүчин зүйл болдог. Ер нь байгаль орчноос өөр ямар хүчин зүйлс малчдыг ядууралд өртөхөд нөлөөлж байна вэ?
4. Малчдыг ядууралд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах төрийн тусгайлсан бодлого юу байна вэ?
5. Ядуурлыг бууруулах, эмзэг байдлыг багасгах ажлыг малчид, тэр дундаа эмэгтэйчүүдийн хувьд үр өгөөжтэйгээр шийдвэрлэхийн тулд юу хийх хэрэгтэй вэ? (Төр, Орон нутаг, Малчид өөрсдөө)
6. Эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, боловсрол (насан туршийн, албан бус боловсрол)-тай холбоотой шийдвэрлэх шаардлагатай ямар асуудалтанай орон нутагт байна вэ?
7. Эдгээр асуудлын шалтгааныг та юу гэж бодож байна?
8. Эрүүл мэнд, боловсрол гэх мэт нийгмийн үйлчилгээ хөдөө орон нутагт чанарын хувьд ялгаатай, тухайн үйлчилгээг авахын тулд хол зам туулдаг, хүний нөөцийн хомсдол, дотуур байр, сургуулийн хүртээмж, аюулгүй байдал гэх мэт асуудал байна. Мөн хүүхдүүд сургуульд сурахын тулд малчин гэр бүл тусдаа байх зэрэг түгээмэл асуудал байдаг. Түүнчлэн насанд хүрсэн иргэд тэр бүр мэдлэг, боловсролоо нэмэгдүүлэх боломж манай орны хэмжээнд дутмаг байна. Ер нь эдгээр эрүүл мэнд, боловсролын үйлчилгээг малчдад хүртээмжтэй байдлаар зохион байгуулахын тулд ямар өөрчлөлтийг хийх ёстой вэ? (Бодлогын орчинд, Зохион байгуулалт, Хүний нөөц)
9. Малчин иргэдийг шийдвэр гаргах үйл явцад оролцуулах зорилгоор төрийн байгууллагын зүгээс ямар ажил хийдэг вэ? Давуу болон сул талыг нь та юу гэж хэлэх вэ?
10. Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх ямар боломж, гарц байна вэ?
11. Судалгаатай холбоотойгоор танд өөр нэмж хэлэх санал юу байна вэ?

Чанарын судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийх загвар:

	Эксперт	Төрийн байгууллага	Малчин эмэгтэйчүүд
Эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх, ядуурлаас урьдчилан сэргийлэх			
Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах			
Боловсролын үйлчилгээний (ялангуяа албан бус боловсрол) хүртээмж, чанарыг сайжруулах чиглэлээр			
Хөдөлмөрлөх эрхтэй холбоотой асуудал ба түүний шийдэл			
Малчдын оролцоог орон нутгийн шийдвэр гаргах түвшинд нэмэгдүүлэх чиглэлээр			
Дүгнэлт			
Санал, зөвлөмж			

АСУУДАЛ: ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХИЙН БУСАД АСУУДЛУУД

(хөдөлмөр эрхлэлт,эрүүл мэнд,боловсрол,гэрлэлт,гэр бүлийн харилцаа)

1. Баримтын судалгааны аргачлал:

1.1 Бодлогын баримтын шинжилгээ

Конвенцийн заалт	Үндэсний хууль тогтоомж/ Үндэсний хөтөлбөр	Зорилгод хүрсэн байдал	Практикт нийцэж байгаа байдал		
			Эерэг үр дагавар (заалт тусгах)	Сөрөг үр дагавар (заалт тусгах)	Хүндрэл, бэрхшээл (Жишээгээр тодорхойлж гаргах)

1.2 Судалгааны тайлангуудын шинжилгээ

Гэрлэлт, гэр бүлийн харилцаа:

Гол асуулт	Дэд асуулт
Гэр бүлийн хүчирхийллийн өнөөгийн нөхцөл байдал	Үндэсний хэмжээнд
	Орон нутгийн хэмжээнд
	Малчин эмэгтэйчүүд
	Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд
	Бэлгийн цөөнх эмэгтэйчүүд
	Эмзэг бүлгийн эмэгтэйчүүд/казак, ахмад настай, амьжиргааны түвшингээс доогуур орлоготой/
Конвенцийг хэрэгжүүлэх хэрэгжилтийг хангахад ЗГ-ын хийсэн ажил (2015-2019)	Гэр бүл, хүүхдийн тэтгэмжийг хангалттай байлгах чиглэлээр
	Гэр бүл салалтын үе дэх өмчийн эзэмшил, менежментийн чиглэлээр
	Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд
	Эмзэг бүлгийн эмэгтэйчүүд /казак, ахмад настан, амьжиргааны түвшингээс доогуур орлоготой/
	Бэлгийн цөөнх
	Улсын төсөвт санхүүжилт тусгагдсан эсэх
	Хүний нөөцийн сургалт, чадавхижуулах
Эмэгтэйчүүдийн хүний эрхийн зөрчилтэй холбоотой тоон мэдээ (2015-2019)	Шүүхийн тоо
	ШШГЕГ
	ХЭҮК-т хандсан гомдлын тоо (АББД, Эмэгтэйчүүдийн эрхтэй холбоотой гомдлын тоо)
	Төрийн бус байгууллагын тоон мэдээлэл

Эмэгтэйчүүдийн хүний эрхийг хэрэгжүүлэхэд тулгарч буй саад бэрхшээл	Соёл уламжлал
	Хууль, эрх зүйн зохицуулалт
	Нийгэм
	Баримт, кейс
Судалгааны дүгнэлт, зөвлөмж	

Эрүүл мэнд:

Гол асуулт	Дэд асуулт
Эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн өнөөгийн нөхцөл байдал	Нөхөн үржихүйн эрүүл мэнд
	Агаарын бохирдол
	Эмэгтэйчүүдийн дундах хорт хавдар (умайн хүзүүний, хөхний гэх мэт)
	Хөдөө орон нутаг, малчин эмэгтэйчүүдэд чиглэсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж
	Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд чиглэсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж
	Бэлгийн цөөнх эмэгтэйчүүдэд чиглэсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж
Конвенцийг хэрэгжүүлэх хэрэгжилтийг хангахад ЗГ-ын хийсэн ажил (2015-2019)	Охид, эмэгтэйчүүдийн эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг баталгаажуулсан байдал /нэмэлт өөрчлөлтүүд/
	Эрүүл мэндийн салбарт жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх агуулга тусгагдсан эсэх
	Хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн хэрэгцээг хангах тогтолцоо (хүний нөөцийн сургалт, мэдээллийн хүртээмж г.м)
	Бэлгийн цөөнх эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн хэрэгцээг хангах тогтолцоо (хүний нөөцийн сургалт, мэдээллийн хүртээмж г.м)
	Эмзэг бүлгийн охид, эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн хэрэгцээг хангах тогтолцоо (хүний нөөцийн сургалт, мэдээллийн хүртээмж г.м)
	Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох
	Жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслийн хүртээмжийг нэмэгдүүлэх ба өртгийг бууруулах
	Эх хүүхдийн эрүүл мэнд, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын ахиц
	Агаарын бохирдлоос үүдэн эмэгтэйчүүдэд учирч байгаа асуудлыг шийдвэрлэх чиглэлээр хийгдсэн ажлууд
	Умайн хүзүүний хор хавдараас урьдчилан сэргийлэх чиглэлээр. Хийсэн ажил (Хүний нөөцийн сургалт)
	Хөдөө орон нутаг, өсвөр насны охидод ээлтэй эмнэлгүүдийн тоо нэмэгдсэн байдал
	Жирэмсэн хөхүүл, төрсний дараах үеийн эмэгтэйчүүдийн хоол тэжээлийн нэмэгдэл, НҮЭМ-ийн байдлыг сайжруулах санхүүжилтийг нэмэгдүүлэх
Эмэгтэйчүүдийн хүний эрхийн зөрчилтэй холбоотой тоон мэдээ (2015-2019)	Шүүхийн тоо
	ХЭҮК-т хандсан гомдлын тоо (АББД, Эмэгтэйчүүдийн эрхтэй холбоотой гомдлын тоо)

	Төрийн бус байгууллагын тоон мэдээлэл
Эмэгтэйчүүдийн хүний эрхийг хэрэгжүүлэхэд тулгарч буй саад бэрхшээл	Соёл уламжлал
	Хууль, эрх зүйн зохицуулалт
	Нийгэм
	Баримт, кейс
Судалгааны дүгнэлт, зөвлөмж	

Хөдөлмөр эрхлэлт:

Гол асуулт	Дэд асуулт
Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдал	Хөдөлмөрийн зах зээлд эмэгтэйчүүдийн эзлэх байр суурь
	Эмэгтэйчүүдийн дундах ажилгүйдлийн түвшин
	Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт
	Бэлгийн цөөнх эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт
	Малчин эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт
	Эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт /казак, ахмад настан, амьжиргааны түвшингээс доогуур орлоготой/
	Хүүхэд асрах байгууллагын хүрэлцээ болон боломжийн өнөөгийн байдал
	Бизнес эрхэлдэг эмэгтэйчүүдийн байдал
	Ядууралд өртөж байгаа эмэгтэйчүүдийн өнөөгийн байдал
	Ажилд авах үйл явцад жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх агуулга тусгагдсан эсэх
Конвенцийг хэрэгжүүлэх хэрэгжилтийг хангахад ЗГ-ын хийсэн ажил (2015-2019)	Ажлын байран дахь ялгаварлан гадуурхалтыг зөрчилд тооцохоор тусгасан эсэх
	Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх
	Бэлгийн цөөнх эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрхийг баталгаажуулах
	Эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг баталгаажуулах / казак, ахмад настан, амьжиргааны түвшингээс доогуур орлоготой/
	Гадаадын цагаач эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрхийг баталгаажуулсан байдал
	хөдөлмөрийн хяналтын үндэсний системийн хүчин чадлыг дээшлүүлэх;
	хориглосон ажил болон салбаруудын жагсаалтыг хянаж, ялангуяа уул уурхайн салбарт ажлын нөхцөл болон мэргэжлийн эрүүл мэнд ба аюулгүй байдлыг сайжруулах;
	хөдөлмөр эрхлэлт болон тэтгэврийн хувьд эрх тэгш боломжийг хангахын тулд эмэгтэйчүүдийн тэтгэврийн насыг эрэгтэйчүүдийнхтэй адил болгож сунгах.
	Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой жендэрийн хэвшмэл ойлголтыг бууруулах олон нийтийн арга хэмжээ
	Эмэгтэйчүүдийн эдийн засгийг чадавхижуулах, эрх мэдэлжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
Зээл, санхүүгийн бодлого нь эмэгтэйчүүдэд хүртээмжтэй байхад чиглэсэн арга хэмжээнүүд	
Эмэгтэйчүүдийн ядуурлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	

Эмэгтэйчүүдийн хүний эрхийн зөрчилтэй холбоотой тоон мэдээ (2015-2019)	Шүүхэд хандсан тоо
	Шүүхээр шийдвэрлэгдсэн тоо
	Шүүхийн шийдвэр биелэгдсэн тоо
	ХЭҮК-т хандсан гомдлын тоо (АБ-н дарамт, эмэгтэйчүүдийн эрхтэй холбоотой гомдлын тоо)
	Төрийн бус байгууллагуудын тоон мдэээлэл
	Хуулийн хэрэгжилтийн ялгаатай байдал
Хуульд огт тусгагдаагүй боловч эмэгтэйчүүдэд тулгамдаж буй асуудал	Хэрэгжихгүй байгаа хуулийн зүйл, заалт
	Хувийн хэвшил болон албан бус салбарт ажиллаж байгаа эмэгтэйчүүдэд тулгамдаж буй асуудал
Асуудлыг үүсэхэд нөлөөлж байгаа хүчин зүйлс нь юу байна вэ?	Соёл уламжлал
	Хууль эрх зүйн зохицуулалт
	Нийгэм
	Эдийн засаг
	Баримт, кейс

Боловсрол:

Гол асуулт	Дэд асуулт
Эмэгтэйчүүдийн боловсролын өнөөгийн байдал	Эмэгтэйчүүдийн боловсролын өнөөгийн байдал (бичиг үсэгт тайлагдах, бага, дунд, их дээд сургууль, МСҮТ-д суралцсан байдал г.м)
	Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн боловсролын өнөөгийн байдал (бичиг үсэгт тайлагдах, бага, дунд, их дээд сургууль, МСҮТ-д суралцсан байдал г.м)
	Бэлгийн цөөнх эмэгтэйчүүдийн боловсролын өнөөгийн байдал (бичиг үсэгт тайлагдах, бага, дунд, их дээд сургууль, МСҮТ-д суралцсан байдал г.м)
	Эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийн боловсролын өнөөгийн байдал (бичиг үсэгт тайлагдах, бага, дунд, их дээд сургууль, МСҮТ-д суралцсан байдал г.м) эрхлэлт /казак, ахмад настан, амьжиргааны түвшингээс доогуур орлоготой/
Конвенцийг хэрэгжүүлэх хэрэгжилтийг хангахад ЗГ-ын хийсэн ажил (2015-2019)	Боловсрол эзэмших үйл явцад жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалтаас урьдилан сэргийлэх агуулга тусгагдсан эсэх
	Хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдийн боловсрол эзэмших боломжийг нэмэгдүүлсэн байдал (багш нарын сургалт, хууль тогтоомжийн өөрчлөлт гэх мэт)
	Бэлгийн цөөнх эмэгтэйчүүдийн боловсрол эзэмших боломжийг нэмэгдүүлсэн байдал (багш нарын сургалт, хууль тогтоомжийн өөрчлөлт гэх мэт)
	Эмзэг бүлгийн охид, эмэгтэйчүүдийн боловсрол эзэмших боломжийг нэмэгдүүлсэн байдал (багш нарын сургалт, хууль тогтоомжийн өөрчлөлт гэх мэт)
	Жирэмсэн охид, залуу эмэгтэйчүүдийг сургуульд үргэлжлүүлэн суралцуулах, нийгмийн амьдралд оролцуулах талаар авсан арга хэмжээ
	Боловсролын салбар дахь бэлгийн дарамт, хүчирхийллийг хуулиар шийдвэрлэсэн байдал

	Боловсролын салбар дахь жендэрийн хэвшмэл ойлголтыг бууруулах олон нийтийн арга хэмжээ, түүнд оролцогч талууд
Эмэгтэйчүүдийн хүний эрхийн зөрчилтэй холбоотой тоон мэдээ (2015-2019)	Шүүхийн тоо
	ХЭҮК-т хандсан гомдлын тоо
	Төрийн бус байгууллагын тоо
Асуудлыг үүсэхэд нөлөөлж байгаа хүчин зүйлс нь юу байна вэ?	Соёл уламжлал
	Хууль эрх зүйн зохицуулалт
	Нийгэм
	Эдийн засаг
	Баримт, кейс

2. Чанарын судалгаа

Гэрлэлт, гэр бүлийн харилцаа:

Ганцаарчилсан ярилцлагын чиг асуулт (нэхэмжлэгч)

1. Гэр бүл цуцлалтын талаарх хууль эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалж чадна гэж та бодож байна уу?
2. Та гэрлэлтээ цуцлуулах нэхэмжлэлийг иргэний болон захиргааны журмаар гаргахад ямар хугацаа зарцуулсан бэ?
3. Та хэдэн хүүхэдтэй вэ? Хүүхдүүд хэдэн настай вэ? Хаана суралцдаг вэ? Цэцэрлэгт явдаг уу?
4. Таны сарын орлого хэд вэ?
5. Нэхэмжлэл гаргахад улсын тэмдэгтийн хураамж хэдийг төлсөн вэ?
6. Нэхэмжлэлийг ямар хугацаанд шийдвэрлэсэн вэ?
7. Нотлох баримт гарган өгөхөд хүндрэл учирсан уу? Тийм бол ямар хүндрэл байсан вэ?
8. Гэр бүлийн гишүүдийн дундын хөрөнгийн хэрхэн шийдвэрлэсэн вэ?
9. Хүүхдийн тэтгэлэг таны хувьд оновчтой тогтоогдож чадсан уу? Шүүхийн шийдвэрээр тогтоогдсон тэтгэлгийг авч чадаж байгаа юу?
10. Судалгаатай холбоотойгоор танд өөр нэмж хэлэх санал юу байна вэ?

Ганцаарчилсан ярилцлагын чиг асуулт (шүүгч)

1. Өнөөгийн гэр бүлийн эрх зүйн зохицуулалтын тулгамдаж буй асуудлыг юу гэж бодож байна.
 - o Хангалтай сайн
 - o Хангалтгүй
2. Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалахад гэр бүлийн эрх зүйн зохицуулалт бүрэн нийцэж байгаа эсэх? Сайжруулах санал?

- a. Эрх зүйн орчны хувьд
 - b. Бодлогын түвшинд
 - c. Хууль хэрэгжүүлэгч байгууллагын түвшинд
3. Гэр бүлийн гишүүдийн хөрөнгийн эрхийн зохицуулалтыг хэрхэн сайжруулах вэ? \
 4. Шүүхэд хандаж буй гэр бүл цуцлалттай холбоотой нэхэмжлэлийн улсын тэмдэгтийн хураамжийн талаар таны бодол? Яагаад гэр бүлийн гишүүн бүрээр хураамж тооцон нэхэмжлэлийг хүлээн авч байна вэ?
 5. Хүүхдийн тэтгэвэр, тэтгэмжийн оногдуулж буй зохицуулалтыг сайжруулахын тулд ямар арга хэмжээ авч болох вэ?
 - a. Бодлогын хувьд
 - b. Эрх зүйн зохицуулалтын хувьд
 6. Гэр бүл цуцлалтын холбоотой шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаарх таны санал?
 7. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийн нэхэмжлэлийг шийдвэрлэлт, хүүхдийн асрамжийн асуудлыг хуулийн хүрээнд сайжруулах зохицуулалтыг санал болгох вэ?
 8. Судалгаатай холбоотойгоор танд өөр нэмж хэлэх санал юу байна вэ?

Хөдөлмөр эрхлэлт:

Бүлгийн ярилцлагын чиг асуулт

1. Эмэгтэй ажилтантай байх давуу болон бэрхшээлтэй талыг та юу гэж хэлэх вэ?
2. Эмэгтэй ажилтны хөдөлмөрлөх эрхийг хангахад Таны зүгээс хүндрэлтэй зүйл гардаг уу? Жирэмсний амралт, хүүхэд харах, нийгмийн даатгал гэх мэт? Тийм бол тодруулна уу, хэрхэн шийдвэрлэг вэ?
3. Ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулдаг уу? Хуулийн дагуу байдаг уу? Үгүй бол яагаад хөдөлмөрийн гэрээ хийдэггүй вэ?
 1. Ажил олгогчийн хувьд хүндрэлтэй зүйл нь (бизнес тогтворгүй, байнгын бус, ажлын байр байнгын бус, түрээсийн гэрээний хугацаа богино гэх мэт)
 2. Ажилтны хувьд хүндрэлтэй зүйл нь..... (татварын суутгалууд өндөр гэх мэт)
4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, хөтөлбөрт хамрагдаж байсан уу? Ажил олгогчийг дэмжиж чаддаг уу? Бүртгэлтэй ажилгүйчүүдээс ажилд авдаг уу, үгүй бол яагаад?
5. Харьяа сум, дүүргийн төрийн байгууллагад бүртгэлтэй юу?
 1. Тийм бол ямар статусаар бүртгэлтэй вэ? (иргэн, нөхөрлөл, хоршоо, бусад.....)
 2. Үгүй бол ямар шалтгаан, бэрхшээл байдаг вэ? (татвар, шимтгэл, суутгал, зөвшөөрөл)
6. Бага насны, хөхүүл хүүхэдтэй, жирэмсэн эмэгтэйчүүдэд танай байгууллага ямар нэгэн нэмэлт орчин нөхцөл бий болгож чаддаг уу?
 1. Тийм бол эерэг, ажил олгогч танд үр ашигтай зүйл нь юу вэ? (ажилтнаа алдахгүй, идэвхтэй, тогтмол ажиллах гэх мэт)

2. Үгүй бол яагаад? Эмэгтэйчүүдэд ээлтэй орчин бүрдүүлэх боломжгүй байгаа шалтгаан нь юу вэ?
7. Адил албан тушаалд адил цалин хөлс, урамшуулал өгч чаддаг уу? Нэмэлт цалин урамшуулал олгох үзүүлэлт нь эрэгтэй, эмэгтэй хүмүүст ялгаатай тусдаг зүйл бий юу? (ажлын цаг бүртгэл, тасралтгүй ажилласан жил, гаргасан бүтээмж гэх мэт)
8. Бага насны болон хөхүүл хүүхэдтэй эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдийн нэгэн адил ажиллуулъя, цалин хөлс урамшуулал олгоё гэвэл бид юу хийх хэрэгтэй гэж та бодож байна вэ?
 1. Төр
 2. Хувийн хэвшил, ажил олгогч
 3. Ажилтан өөрөө

Экспертийн ярилцлагын чиг асуулт

1. Эмэгтэйчүүдийн ажил хөдөлмөр эрхлэхэд тулгамдаж буй асуудал өнөөгийн дүр төрх мөн албан бус салбарт ажиллаж буй эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрхтэй холбоотой тулгамдаж буй асуудлуудыг та юу гэж тодорхойлох вэ?
2. Эмэгтэйчүүд хүн амын 51% эзэлдэг хирнээ ажилгүйдэл, эдийн засгийн идэвхгүй байдал нь өндөр байна. Дундаж цалин эрэгтэйчүүдийнхээс доогуур, үнэлгээгүй хөдөлмөрт олноор ажиллаж байна. Эмэгтэйчүүдийн боловсролын түвшин өндөр ч яагаад хөдөлмөрийн зах зээлд үр өгөөжээ өгч чадахгүй байна вэ?
3. Эдгээр нь хөдөлмөрлөх эрхийн зөрчил нь юунаас үүдэлтэй гэж та боддог вэ?
4. Ажлын байран дах ялгаварлан гадуурхалт, дарамтын асуудлыг зохицуулах ямар боломж байна вэ?
 1. Эрх зүйн орчин
 2. Байгууллагын дүрэм, журам
 3. Бусад
5. Эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрхтэй холбоотой Монгол Улсын бодлого, хууль тогтоомжид дэмжиж байгаа болон дэмжихгүй байгаа зохицуулалт юу байна вэ? Албан бус салбарт ажиллаж байгаа эмэгтэйчүүд хөдөлмөрлөх эрхээ хамгаалуулах эрх зүйн орчин бий юу?
 1. Дэмжиж байгаа бол зохицуулалтыг бичих
 2. Дэмжихгүй байгаа бол зохицуулалтыг бичих
6. Хөдөлмөрлөх эрхийг эрэгтэй эмэгтэйд адил эдлүүлэхэд хөдөлмөр эрхлэлтийн бодлого жендерийн мэдрэмжтэй байх хэрэгтэй юу? Жендерийн мэдрэмжгүй байгааг арилгахын тулд ямар арга хэмжээ авах нь үр дүнтэй вэ?
 1. Төр
 2. Ажил олгогч
 3. Бусад
7. Малчин эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрхийн асуудал буюу хийсэн ажилдаа тохирсон цалин хөлстэй байх, аюулгүй орчин нөхцлөөр хангагдах, нийгмийн халамж хүртэхийн тулд бодлого, эрх зүйн орчин мөн түүний хэрэгжилтийг хангахад юу хийх хэрэгтэй гэж та боддог вэ?

8. Ажил олгогч нарын хувьд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг хангахад ямар бэрхшээл тулгардаг вэ?
9. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн тусгай бодлого байх хэрэгцээ шаардлагатай юу?
10. Эмэгтэйчүүд бага насны хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй болон ахмад настныг асарч үйлчилдэг гэсэн шалтгаанаар эдийн засгийн идэвхгүй болж, хөдөлмөр эрхлэх боломж хумигдаж, ажил орлогогүй болох нь нэмэгдэж байна. Цаашид эмэгтэйчүүдийн эдийн засгийн идэвхийг нэмэгдүүлэхэд юу хийх ёстой вэ?
11. Хөдөлмөрлөх эрхтэй холбоотой маргааныг хэрхэн оновчтой зохицуулах боломж байна вэ? Түүнчлэн салбар хоорондыг бодлогын зохицуулалтыг ямар байгаасай гэж бодож байна.
 1. Төр
 2. Ажил олгогч
 3. Үйлдвэрчний эвлэл
 4. Бусад
12. Судалгаатай холбоотойгоор танд өөр нэмж хэлэх санал юу байна вэ?

Онлайн судалгааны асуумж:

Эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрх

Энэхүү судалгаа нь жирэмсэн болон бага насны хүүхэдтэй эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэнд тулгамдаж буй бэрхшээлийг тодорхойлох зорилготой юм. Таны өгсөн мэдээллийг бид зөвхөн судалгааны зориулалтаар ашиглах бөгөөд хувь хүний ямар нэгэн мэдээлэл ашиглагдахгүй болно.

1. Таны нас:
2. Гэрлэлтийн байдал
 1. Гэрлэлтээ батлуулсан
 2. Хамтран амьдардаг
 3. Тусдаа амьдардаг
 4. Салсан
 5. Бэлэвсэн
3. Ажил эрхлэлтийн байдал
 1. Ажил хийж байгаа
 2. Цагийн ажил хийдэг
 3. Хүүхдээ асрах чөлөөтэй байгаа (7-р асуултруу шилжих)
 4. Ажилгүй (7-р асуултруу шилжих)

4. Хэрэв ажил эрхэлдэг бол ямар салбарт ажилладаг вэ?
 1. Төрийн байгууллага
 2. Бизнесийн байгууллага
 3. Жижиг, дунд үйлдвэрлэл
 4. Үйлчилгээний салбар (үсчин, тогооч, худалдагч г.м)
 5. Туслах малчин
5. Та ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ байгуулсан уу?
 1. Тийм
 2. Үгүй
 3. Бусад
6. Та нийгмийн даатгалд хамрагддаг уу?
 1. Тийм, хөдөлмөрийн гэрээний дагуу
 2. Тийм, сайн дурын даатгалд
 3. Үгүй
7. Танд хөдөлмөр эрхлэхтэй холбоотой дараах бэрхшээлүүд тулгардаг уу? (олон сонголттой)
 1. Хүүхэд асрах хүн байхгүй
 2. Өдөр өнжүүлэх төв хүртээмжгүй (үнэтэй, цөөхөн)
 3. Цэцэрлэг болон ажлын цаг давхцдаг
 4. Ажлын ачаалал их
 5. Ажлын цаг хязгааргүй
 6. Ажил олгогчийн сөрөг хандлага
 7. Хөлсгүй ажиллуулдаг
 8. Боловсрол, ур чадвар дутмаг
 9. Бусад (бичих)
8. Таныг жирэмсэн эсвэл хүүхэд асрах чөлөөтэй байх үед ажлаас гарахыг шаардаж байсан тохиолдол бий юу?
 1. Тийм
 2. Үгүй
9. Хэрэв тийм бол ажил олгогчийн шаардлагыг хүлээн авсан уу?
 1. Тийм
 2. Үгүй

10. Ажил хийж байх үедээ удирдлага, ажил олгогч болон хамт олны зүгээс ялгаварлан гадуурхалт, ажлын байрны дарамтанд өртөж байсан байсан тохиолдол бий юу?

1. Тийм
2. Үгүй

11. Хэрэв тийм бол эдгээрээс аль нь тохиолдсон бэ? (хэдийг ч сонгож болно)

1. Насаар ялгаварлах
2. Хүйсээр ялгаварлах
3. Удирдах албан тушаалтнаас дарамт ирэх
4. Цалин, урамшуулал нэмэхгүй байх
5. Албан тушаал дэвшүүлэхгүй байх
6. Цалинг барьцаалах
7. Бартераар цалинжуулах
8. Улс төрийн үзэл бодлоор ялгаварлах
9. Бусад (тодорхой дурьдана уу)

12. Таны хөдөлмөрлөх эрх зөрчигдсөнтэй холбоотойгоор гомдол гаргаж байсан уу?

1. Тийм
2. Үгүй (16-р асуулт руу шилжих)

13. Хэрэв тийм бол хаана хандаж байсан вэ?

1. Хүний нөөцийн ажилтан
2. Үйлдвэрчний эвлэл
3. Маргаан таслах комисс
4. Иргэний шүүхэд
5. Бусад

14. Таны гаргасан гомдол хэрхэн шийдвэрлэгдсэн вэ?

1. Гомдол гаргагчийн талд
2. Ажил олгогчийн талд

15. Таны бодлоор жирэмсэн болон бага настай эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэн, юу хийгээсэй гэж хүсч байна вэ?

16. Танд судалгаатай холбоотой нэмэлт санал байна уу?

Танд баярлалаа

Чанарын судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийх загвар

Гэрлэлт, гэр бүлийн харилцаа:

	Шүүх эрх мэдлийн байгууллага	Нэхэмжлэгч
Эрх зүйн орчин		
Тусламж, үйлчилгээ		
Хэргийн шийдвэрлэлт		
Цаашид анхаарах асуудал		
Дүгнэлт		
Санал, зөвлөмж		

Хөдөлмөр эрхлэлт:

	Эксперт	Төрийн байгууллага	Ажил олгогч
Эрх зүйн орчин			
Хөдөлмөр эрхлэхтэй холбоотой зөрчлүүд, түүнийг хянан шийдвэрлэж буй байдал			
Эмэгтэйчүүдийн эрхийг хангахын тул ямар арга хэмжээ авах талаар			
Ажил олгогчдын хувьд эмэгтэйчүүдийг нэмэн авбал зохих арга зам			
Хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх өнөөгийн байдал, хяналтын тогтолцоог сайжруулах арга зам			
Дүгнэлт			
Санал, зөвлөмж			

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХИЙГ ХАНГАХТАЙ ХОЛБООТОЙ (2015-2019) СҮҮЛИЙН ТАВАН ЖИЛИЙН ХУГАЦААНД МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ НЭГТГЭЛ

МУ-ын Засгийн газрын түвшинд хэрэгжүүлсэн үйл ажиллагааг нэгд бодлогын орчинг сайжруулах чиглэлээр, хоёрт жөндөрт суурилсан хүчирхийлэлтэй холбоотой хэргийн шийдвэрлэлт, гуравт сургалт, дөрөвт судалгаа, тавд төсөв гэсэн ангиллаар төрийн холбогдох байгууллагуудаас ирүүлсэн мэдээллийг нэгтгэв. Нийт нэр бүхий 11 газарт мэдээлэл хүссэн албан тоот хүргүүлсэн ба үүнээс Хүний эрхийн үндэсний комисс ямар нэгэн хариу ирүүлээгүй.



Нэрс	Жөндөрт суурилсан хүчирхийлэл				Улс төр дэх эмэгтэйчүүд ийн оролцоо	Хөдөөгийн эмэгтэйчүүд	Эмэгтэйчүүдийн эрх				
	Гэр бүлийн хүчирхийлэл	Хүн худалдаалах гэмт хэрэг	Ажлын байран дахь бэлгийн дарамт	Бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх гэмт хэрэг			Хөдөлмөр эрхлэлт	Эрүүл мэнд	Боловсрол		
1 ХЗДХЯ, МУ-д ГХУ/СА33	✓	✓	✓	✗	✗	✗	✗	✗	✗	✗	
2 ХНХЯ	✓	✓	✗	✓	✗	✓	✗	✗	✗	✗	
3 ЭМЯ	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✓	✗	✗	
4 БСШУСЯ	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	
5 ШЕЗ	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	
6 УЕПГ	✓	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	
7 ЦЕГ	✗	✓	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	
8 ГБХЗХГ	✓	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	
9 ХБХЕГ	✓	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	
10 ЖҮХ	✗	✗	✗	✗	✓	✗	✗	✗	✗	✗	
11 ХЭҮК											

Мэдээлэл ирүүлээгүй

Цаашид анхаарах асуудал:

- Үндэсний хууль тогтоомжийн уялдаа холбоогт сайжруулах, хийдлийг арилгах арга хэмжээ авах.
- Конвенцын үзэл санаанд үндэслэн ялгаварлан гадуурхалтыг эсрэг хуулийн санаачлан гаргах боломжийг бүрдүүлэх

ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ

Нэрс	Жендэрт суурилсан хүчирхийлэл				
	Гэр бүлийн хүчирхийлэл	Хүн худалдаалах	Ажлын байран дахь бэлгийн дарамт	Бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх гэмт хэрэг	Тайлбар
1 ХЗДХЯ, МУ-д ГХУСАЗЗ	×	×	×	×	
2 ХНХЯ	×	×	×	×	
3 ЭМЯ	×	×	×	×	
4 БСШУСЯ	×	×	×	×	
5 ШЕЗ	✓	✓	×	✓	
6 УЕПГ	Хорооноос ирүүлсэн хүний наймааны 26 эрүүгийн хэрэгтэй холбоотой тайлбарт хариуг өгөөгүй.				
7 ЦЕГ	✓	✓	×	✓	
8 ГБХЗХГ	×	×	×	×	
9 ХБХЕГ	×	×	×	×	
10 ЖҮХ	×	×	×	×	
11 ХЭҮК	Мэдээлэл ирүүлээгүй				

Цаашид анхаарах асуудал:

- Шүүхийн шийдвэрт уг Конвенцыг эшлэсэн, хэрэглэсэн эсэх талаарх мэдээлэл нь шүүх байгууллагын хэмжээнд судалгаа, мэдээллийн үзүүлэлт болгон бүртгэгддэггүй бөгөөд ШЕЗ-өөс энэ төрлийн мэдээллийг эх сурвалжуудаар дамжуулан үзэхэд сүүлийн таван жилийн байдлаар тус конвенцыг хэрэглэсэн тохиолдол хараахан гараагүй байна.
- - Хэргийн шийдвэрлэлтийн хэсэгт УЕПГ-аас мэдээлэл өгөөгүй ба энэ нь Эрүүгийн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлттэй уялдуулан, цахим бүртгэлийн нэгдсэн системд шинэчлэл, хөгжүүлэлт хийж байгаа тул Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шийдвэрлэлтийн судалгааг гаргах боломжгүй.
- - Цагдаагийн байгууллагаас улсын хэмжээнд 2018 онд насанд хүрээгүй үедээ жирэмсэн болсон тохиолдол өмнөх оноос 466 буюу 31.7%- иар, үр хөндүүлсэн охид 73 буюу 35.7% - иар, хүүхэд төрүүлсэн охид 393 буюу 44.4%- иар тус тус өссөн үзүүлэлттэй байгаагаас харахад насанд хүрээгүй охидын жирэмслэлт, үр хөндөлт, төрөлт эрс ихэссэн бөгөөд цаашид өсөх хандлагатай байгаа тул энэ зорилтод бүлэг рүү чиглэсэн ажил хийх хэрэгтэй талаар санал өгсөн.
- санал өгсөн.

СУРГАЛТ

Нэрс	Жендэрт суурилсан хүчирхийлэл				Улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоо	Хөдөөгийн эмэгтэйчүүд	Эмэгтэйчүүдийн эрх				
	Гэр бүлийн хүчирхийлэл	Хүн худалдаалах	Ажлын байран дахь бэлгийн дарамт	Бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх гэмт хэрэг			Хөдөлмөр эрхлэлт	Эрүүл мэнд	Боловсрол		
1 ХЭДХЯ, МУ-д ГХУ/СА33	✓	✓	✗	✓	✗	✗	✗	✗	✗	✗	✗
2 ХНХЯ	✓	✗	✗	✓	✗	✗	✗	✗	✗	✗	✗
3 ЭМЯ	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗
4 БСШУСЯ	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✓
5 ШЕЗ	✓	✓	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗
6 УЕПГ	✓	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗
7 ЦЕГ	✓	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗
8 ГБХЗХГ	✓	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗
9 ЖҮХ	✓	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗
10 ХЭҮК					✓	✗	✗	✗	✗	✗	✗

Мэдээлэл ирүүлэггүй

Цаашид анхаарах асуудал:

- Төрийн байгууллагууд эмэгтэйчүүдийн эрхийг хангах чиглэлээр тусгай сургалт зохион байгуулаагүй ба жендэр, жендэрийн үндсэн ойлголт, жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл гэсэн сэдэвт сургалт нь Олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдаж байгаа нь ажиглагдлаа.
- Шүүх эрх мэдэл, хууль сахиулах байгууллагын алба хаагчдыг сургах тогтолцоо тогтмол бус, түр зуурын шинжтэй, олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр зохион байгуулагдаж байгаа хэвээр байна. Иймээс хүний эрхийг хангах чиглэлээр ажиллаж буй алба хаагчдыг мэргэшүүлэн сургадаг тогтолцоог бий болгох, улсын төсөвт сургалтын санхүүжилтийг тусгасан байх

СУДАЛГАА

Нэрс	Жендэрт суурилсан хүчирхийлэл				Улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоо	Хөдөөгийн эмэгтэйчүүд	Эмэгтэйчүүдийн эрх			Гэрлэлт		
	Гэр бүлийн хүчирхийлэл	Хүн худалдаалах	Ажлын байран дахь бэлгийн дарамт	Бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх гэмт хэрэг			Хөдөлмөр эрхлэлт	Эрүүл мэнд	Боловсрол			
1 ХЗДХЯ, МУ-д ГХУСА33	✓	✓	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗
2 ХНХЯ	✓	✗	✗	✗	✗	✗	✗	✓	✗	✗	✗	✗
3 ЭМЯ	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗
4 БСШУСЯ	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✓	✗
5 ШЕЗ	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗
6 УЕПГ	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗
7 ЦЕГ	✓	✓	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗
8 ГБХЗХГ	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗
9 ХБХЕГ	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗
10 ЖҮХ	✓	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗
11 ХЭҮК												

Цаашид анхаарах асуудал:

- Эмэгтэйчүүдийн эрхийн хэрэгжилтийн талаарх дагнасан тусгай, бие даасан судалгаа хийгдээгүй байна. НҮБХАС, Швейцарийн хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн "Хүчирхийллийн нүцгэн үнэн 2018" судалгаа нь суурь судалгааны эх сурвалж болон төрийн байгууллагуудад хэрэглэгдэж байна.
- Жирэмсэн охидыг сургуульд үргэлжлүүлэн сургах, залуу ээж нарт амьдрах ухааны боловсрол олгох, нийгэмшүүлэх чиглэлээр авсан арга хэмжээ байхгүй.
- Жирэмсэн охид болон залуу ээж нар сургуульдаа буцаж орсон тоон мэдээлэл байхгүй.
- Боловсролын салбарт гарсан бэлгийн хүчирхийлэл болон дарамт халдлагын тохиолдлыг мөрдөн шалгаж, ял шийтгэл оногдуулсан эсэх тоо мэдээлэл байхгүй.

ТӨСӨВ

Нэрс	Жендэрт суурилсан хүчирхийлэл				Улс төр дэх эмэгтэйчүүд ийн оролцоо	Хөдөөгийн эмэгтэйчүүд	Эмэгтэйчүүдийн эрх					
	Гэр бүлийн хүчирхийлэл	Хүн худалдаалах	Ажлын байран дахь бэлгийн дарамт	Бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх гэмт хэрэг			Хөдөлмөр эрхлэлт	Эрүүл мэнд	Боловсрол			
1 ХЗДХЯ, МУ-д ГХУСА33	✓	✓	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	
2 ХНХЯ	✓	✗	✗	✗	✗	✗	✗	✓	✗	✗	✗	
3 ЭМЯ	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✓	✗	
4 БСШУСЯ	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	
5 ШЕЗ	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	
6 УЕПГ	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	
7 ЦЕГ	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	
8 ГБХЗХГ	✓	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✓	
9 ХБХЕГ	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	
10 ЖҮХ	✓	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	✗	
11 ХЭҮК												

Мэдээлэл ирүүлээгүй.

Цаашид анхаарах асуудал:

- Одоогийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь Олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжиж байна. Энэ нь үйл ажиллагаа тогтмол бус, хүртээмжгүй байх эрсдэлийг дагуулж байна. Иймд МУ-ын нэгдсэн төсөвт эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлийн төсвийг нэмэгдүүлэх шаардлагатай байна

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ:

1. Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц (1981)
2. Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцын нэмэлт Протокол (2000)
3. Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн тухай Конвенц (1954)
4. Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцын 20-р зүйлийн 1 дэх хэсэгт оруулах нэмэлт өөрчлөлт (1995)

ХУУЛЬ ТОГТООМЖ:

1. Боловсролын тухай хууль (2002)
2. Гэр бүлийн тухай хууль (1999)
3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2016)
4. Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль (2013)
5. Даатгалын тухай хууль (2004)
6. Донорын тухай хууль (2018)
7. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011)
8. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль (2019)
9. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай (2017)
10. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль (2019)
11. Захиргааны ерөнхий хууль (2015)
12. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2016)
13. Зөрчлийн тухай хууль (2017)
14. Иргэний хууль (2002)
15. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2002)
16. МУ-ын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль (2002)
17. МУИХ-ын сонгуулын тухай хууль (2019)
18. Монгол Улсын Үндсэн хууль (1992)
19. Монгол Улсын Хүний эрхийн үндэсний Комиссын тухай хууль (2020)
20. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай (2011)

21. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай (1994)
22. Нийгмийн даатгалын тухай хууль (1994)
23. Нийгмийн халамжийн тухай хууль (2012)
24. Нийтийн сонсголын тухай хууль (2015)
25. Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль (1998)
26. Сонгуулийн тухай хууль (2015)
27. Төрийн албаны тухай хууль (2017)
28. Төрийн бус байгууллагын тухай хууль (1997)
29. Улс төрийн намын тухай хууль (2005)
30. Улсын бүртгэлийн ерөнхий хууль (2018)
31. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль (2016)
32. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль (2011)
33. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль (2008)
34. Хөдөлмөрийн тухай хууль (1999)
35. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль (2012)
36. Хүүхдийн эрхийн тухай хууль (2016)
37. Хүүхэд хамгааллын тухай хууль (2016)
38. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль (1998)
39. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (2017)
40. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль (2016)
41. Эрүүгийн хууль (2015)
42. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017)
43. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль (2015)
44. Эрүүл мэндийн тухай хууль (2011)

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР:

1. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр (2018)
2. Гурван тулгуурт хөгжлийн бодлого (2018)
3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2017)

4. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр (2019)
5. Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр (2019)
6. Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр (2016)
7. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал (2001)
8. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр (2016)
9. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030 (2016)
10. Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал (2010)
11. Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого (2016)
12. Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр (2017)
13. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр (2017)

СУДАЛГАА:

1. АББД-тай тэмцэх ТББ-дын Эвсэл. (2016). *Ажлын байрны бэлгийн дарамтлалын эсрэг авах арга хэмжээний талаарх олон нийтийн хандлага Онлайн судалгаа, Улаанбаатар хот: Мөнхийн үсэг.*
2. Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн; Нээлттэй нийгэм форум. (2018). *Монголын улс төрийн санхүүжилтийн эрх зүйн орчин: Дүн шинжилгээ, санал зөвлөмж.*
3. Бодлогын судалгааны хүрээлэн. (2018). *Тавантолгойн бүлэг ордын нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагааны хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ. Хүний эрхийн үндэсний комисс.*
4. БСШУСЯ (2019). *Монгол Улсын боловсролын суурь мэдээллийн тайлан. Улаанбаатар хот: Гоо дизайн ХХК.*
5. ГБХЗХГ, Дэлхийн зөн Монголд ОУБ. (2018). *Монголын гэр бүлийн асуудал, хэрэгцээ, үйлчилгээний хувилбар судалгаа, Улаанбаатар хот.*
6. ГБХЗХГ. (2018). *Монгол гэр бүлийн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдсан асуудлууд үйлчилгээний хувилбар.*
7. Л.Ганбаатар. (2019). *Гэрч, хохирогчийн хамгаалалт бодлогын судалгаа. Нээлттэй нийгэм форум.*
8. С.Дондов. (2018). *Хүн худалдаалах гэмт хэргийг шийдвэрлэж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд хийсэн үнэлгээ. Улаанбаатар хот.*
9. Дэлхийн банк. (2019). *Хөдөлмөр эрхлэлтийн баталгаагүй байдлын дүр зураг. Улаанбаатар хот.*
10. Жендэрийн үндэсний хороо. (2019). *Монгол Улсын Жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ: 2005 оноос өнөөг хүртэлх ололт амжилт ба сорилт, сургамж. Улаанбаатар.*
11. МОНЭС. (2018). *Уурхайн олборлолт явагдаж буй газар нутагт хийсэн жендэрийн үр нөлөөний үнэлгээ.*
12. Монгол Улсын Засгийн газар (2016). *ЭАБХУТ НҮБ-ын Конвенцын хэрэгжилтийн асуудлаар тайлан 8 ба 9-р илтгэл, УБ.*

13. Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо; Хүний эрхийн үндэсний комисс. (2019). *Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрх судалгаа*.
14. МУЗГ. (2018). *50-р тогтоол*.
15. МУЗГ. (2019). *Хүний эрхийн төлөв байдлын 3 дахь илтгэл, УБ*.
16. Монгол Улсын Иргэний Нийгмийн байгууллагуудын Сүлжээ. (2019). *ТХЗ-ын хэрэгжилтийн бэлэн байдал ИНБ-ын тайлан*. https://worldvision.mn/media/worldvision/content/Togtvortoi_hugjil_tailan_Mongol_CSOs.pdf
17. Нийгмийн бодлого хөгжлийн судалгааны хүрээлэн. (2016). *Бага, дунд боловсролын жендэрийн дүн шинжилгээ*.
18. Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэн. (2016). *Ерөнхий боловсролын жендэрийн дүн шинжилгээ, Улаанбаатар: Жендэрийн үндэсний хорооны дэргэдэх Жендэр консорциум*.
19. НҮБХАС. (2016). *Хүний хөгжлийн тайлан, УБ*.
20. Нээлттэй нийгэм форум. (2019). *Бүлгийн эрхийн нөхцөл байдал тайлан, УБ*.
21. МУ-ын Эдийн засаг, нийгмийн 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт: Аудитын ерөнхий дүн, УБ.
22. Олон улсын хөдөлмөрийн байгууллага. (2019). *Зохистой хөдөлмөрийг дэмжиж 2030 он хүртэлх ТХЗ-ын хэрэгжилтийг эрчимжүүлэх нь хэсэг, ТХЗ-ын хэрэгжилтийг хяналт шинжилгээ, улс орны төлөв байдал МУ-ын тайлан. Улаанбаатар*.
23. Үндэсний Статистикийн хороо. (2019). *Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо. Улаанбаатар*.
24. Үндэсний Статистикийн хороо. (2018). *МУ-ын хүний хөгжлийн үзүүлэлтүүдийг олон улстай харьцуулсан судалгаа. Улаанбаатар хот*.
25. Үндэсний статистикийн хороо. (2015). *Цаг ашиглалтын судалгаа*.
26. Үндэсний статистикийн хороо. (2016). *Ажиллах хүчний оролцооны түвшин, 2004-2016. Улаанбаатар*.
27. Үндэсний статистикийн хороо. (2018). *Хүчирхийллийн нүцгэн үнэн жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааны тайлан-2017, УБ*.
28. Үндэсний статистикийн хороо. (2019). *Гэр бүл цуцлалтын тоо*.
29. Үндэсний статистикийн хороо. (2019). *Дээд боловсролын үндсэн үзүүлэлтүүдийн төлөв байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээ, Улаанбаатар хот*.
30. Үндэсний статистикийн хороо, Дэлхийн банк. (2019). *Ядуурлын дүр төрх – 2018*.
31. Хүний эрхийн үндэсний комисс. (2017). *Жижиг, дунд үйлдвэр дэх хөдөлмөрлөх эрхийн зарим асуудал: Худалдаа үйлчилгээ, ноос ноолуурын салбар*.
32. Хүний эрхийн үндэсний комисс. (2018). *Үйл ажиллагааны тайлан*.
33. Хүйсийн тэгш эрх төв. (2019). *Бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх гэмт хэрэг илтгэл*.
34. Хүйсийн тэгш эрх төв. (2018). *Охид, эмэгтэйчүүдийн ажлын байран дах бэлгийн дарамтын төлөв*

байдал, хандлага» харьцуулсан судалгаа.

35. Хүний эрхийн үндэсний комисс. (2018). *МУ дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13 дах илтгэл. УБ.*
36. Хүчирхийллийн эсрэг үндэсний төв. (2018). *Гэр бүлийн маргаантай хэргийг шүүхээр шийдвэрлэх ажиллагаа, Баримтын дүн шинжилгээ. Улаанбаатар хот.*
37. Хүчирхийллийн эсрэг үндэсний төв. (2018). *Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар цагдаагийн алба хаагчид хүлээлгэсэн үүргийн хэрэгжилт (Мониторингийн тайлан).*
38. Хүчирхийллийн эсрэг үндэсний төв. (2019a). *Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хэрэгжилтийн Мониторингийн тайлан.*
39. Хүчирхийллийн эсрэг үндэсний төв. (2019b). *НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд илгээсэн тайлан «Гэр бүлийн хүчирхийлэл».*
40. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт. (2018). *Малчдын аж байдлын судалгаа.*
41. Шилэн нам авлигын эсрэг түншлэл. (2018). *Улс төрийн санхүүжилтийн ил тод байдал, авлигын эрсдэлийн үнэлгээ судалгааны тайлан, Улаанбаатар хот: Мөнхийн үсэг ХХК.*
42. Эмэгтэй удирдагч сан. (2019). *Спортын салбар дахь жендэр ба эмэгтэй тамирчдын эрх жендэрийн дүн шинжилгээний тайлан, дүгнэлт, Улаанбаатар хот.*
43. Б.Энхболд, С.Гантулга, Б.Мөнхзул. (2019). *Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэгт ял оногдуулж буй байдалд хийсэн дүн шинжилгээ. Нээлттэй нийгэм форум.*
44. Эрүүл мэндийн хөгжлийн төв. (2019). *Монгол улсын эрүүл мэндийн үзүүлэлт – 2018. <https://www.chd.mohs.mn/2019/sariin%20medee/2018.pdf>*
45. International Republican Institute. (2016). *Улс төрд эмэгтэйчүүдийн оролцоо: Бэрхшээлийг даван туулах нь. Улаанбаатар.*
46. IRIM судалгааны хүрээлэн. (2017). *Байгаль орчны салбарын жендэрийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ (Ойн салбарын жишээ). Улаанбаатар хот.*
47. MMCG. (2017). *Малчин өрхийн нийгэм, эдийн засгийн суурь судалгааны тайлан.*
48. Swiss Agency for Development and Cooperation SDC. (2015). *Gender analysis in pastoral livestock herding in Mongolia.*

